



ӨМГӨӨЛЛИЙН “ТРИТИ” ХХН

**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ, ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЛБА БАЙГУУЛЖ, ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ
ХАНГАХ АСУУДЛААР ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА**

ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот. 2024 он

АГУУЛГА

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл	1
Судалгааны зорилго, судалгаа явуулсан арга, хэлбэр	2

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал	3
1.1.1. Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллага, эрх зүйн орчин, үйл ажиллагааны хэрэгжилт	4
1.1.2. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллага, үйл ажиллагааны хэрэгжилт	17
1.1.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий этгээд, эрх зүйн орчин, практик хэрэгжилтийн байдал	21
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд	24
1.3. Асуудал үүсгэж байгаа учир шалтгаан, нөхцөл	30

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	28
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	29
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	29
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр	29
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэж байгаа байдал	29

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

6.1. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ	31
6.2. Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт	34

ДҮГНЭЛТ ДОЛОО. ЗӨВЛӨМЖ НОМ ЗҮЙ

ХАВСРАЛТ. БУСАД ХУУЛИЙН ТӨСЛИЙН БҮТЭЦ, АГУУЛГА, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ ХУУЛИЙН ТАЛААР

Хавсралт 1. Үр нөлөөний үнэлгээ	
Хавсралт 2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал	59
Хавсралт 3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөл	66
Хавсралт 4. Хуулийг дагаж гарах хууль тогтоомжийн төсөл	105

УДИРТГАЛ

1.Судалгааны ажлын үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна”, Арван зургадугаар зүйлийн 13-т “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 2-т “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь ...хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1-р үе шат буюу 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.3.9-д Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авахаар тусгагдсан.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийн дагуу Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг баталсан бөгөөд арга хэмжээний 26-д “108.126. Эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг айлган сүрдүүлэх, дарамтлах, эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх, гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий бие даасан, хөндлөнгийн хараат бус үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ тусгагдсан.

Мөн Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хорооны зөвлөмж 611.26-д “2014 онд Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх тусгай мөрдөн байцаах албыг татан буулгаж, чиг үүргийг Авилгатай тэмцэх газарт шилжүүлсэн нь тухайн төрийн албан хаагчийн эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан гэх үйлдлийг өөр нэг төрийн албан хаагчаар мөрдүүлж байгаа одоогийн энэ бүтэц нь ижил түвшинд мөрдөн шалгах бие даасан байдал алдагдахад хүргэж, цаашлаад үр дүнтэй хяналтыг бий болгохгүй” гэжээ. 614.29-т “Төрийн алба хаагчид, түүний дотор цагдаагийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг Улсын ерөнхий прокурорын газрын дотоод бүтцэд дахин бий болгохыг Оролцогч улсад зөвлөж байна. Бүх мөрдөн шалгалтыг хараат бусаар, алагчлалгүй, үр дүнтэй, мөрдөгч болон гэмт хэрэгтнүүдийн хооронд ямар нэг холбоо үүсэхээс сэргийлсэн байдлаар явуулахыг Оролцогч улс нягтлан шалгах ёстой.” гэж тус тус зөвлөжээ.

Улсын Их Хурлын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны 35 дугаар тогтоолын 1.4.6-д эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулахыг Засгийн газарт даалгасан.

Мөн Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 3 дугаар илтгэлийг хэлэлцүүлсний мөрөөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтийн дунд хугацааны явцын тайлан /2024/ -гийн 116.51, 116.53, 116.54-т эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэргийг мөрдөн шалгах хараат бус, бие даасан байгууллага байгуулахыг зөвлөсөн бөгөөд НҮБ-ын Хүний эрхийн механизмын Зөвлөмжийн нэгтгэл /2023 он/ -ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны зөвлөмжийн 508-д “Оролцогч улс нь эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал гаргагчдыг ял завшихаас сэргийлэх үүднээс үр дүнтэй, хараат бус мөрдөн шалгах механизм байгуулах хэрэгтэй байна.”, мөн Хүний эрхийн зөвлөлийн эрүүдэн шүүхийн Тусгай илтгэгч “эрүүдэн шүүх асуудал цагдаагийн газар, цагдан хорих төвүүдэд голчлон тохиолдохоос гадна энэ талаар ирсэн гомдлыг хүлээн авч, мөрдөн шалгах үр

дүнтэй механизмгүйгээс болж энэ төрлийн гэмт хэрэг ял завшиж байна” (1, 2, 4, 12,16 дугаар зүйл)” гэж тус тус дүгнэжээ.

Дээрх үндэслэлүүдээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах ажиллагаа” хэсгийн 4.2.1.14-т гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргах зорилт дэвшүүлсэн.

Үндэсний бодлогын баримт бичиг, олон улсын байгууллагын өгсөн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад хийнэ.” гэж заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулах асуудлаар хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг хийв.

Судалгааны зорилго

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилго нь гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулж, хохирогчийн эрхийг хангах асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, тэдгээрийн үр нөлөөг урьдчилан тандан судалсны үндсэн дээр асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгоход оршино.

Судалгаа хийх хүрээ

Судалгаа хийх хүрээг ажлын даалгаварт заасан боловсруулах мэдээллийг багцлан дараах байдлаар байдлаар тогтоож байна:

1/гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан алба байгуулах хэрэгцээ шаардлага;

2/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулах хэрэгцээ, шаардлага.

Судалгааны арга, хэлбэр

Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн бөгөөд асуудалд дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандах, олон улсын болон бусад улсын сайн туршлагыг судлах үе шаттайгаар хийсэн болно.

Судалгааг хийхдээ баримт бичгийн шинжилгээгээр үндэсний хууль тогтоомжийг судлах, эрдэмтэн, багш, судлаачдын судалгааны тайлан, нийтлэл, ном, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, статистик тоо баримт цуглуулж, тэдгээрт дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтан, судлаачидтай уулзаж ярилцах, хэрэгжүүлэгч байгууллагаас тайлан мэдээ гаргуулан авч, дүн шинжилгээ хийх, мөн олон улсын баримт бичиг, гэрээ, гадаадын зарим улсын хууль тогтоомж, үйл ажиллагааны туршлагыг судлах аргуудыг ашиглалаа.

Судалгааг бие даасан байдлаар шинжлэх ухааны түгээмэл арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон гүйцэтгэв.

Судалгааны багт Өмгөөллийн “Трити” ХХН-ийн Удирдах партнер л Э.Цацрал, магистр (ИБУИНХУ-ын Дандий Их сургууль), докторант (Япон, Нагояагийн ИС), Судлаач хуульч Э.Цэнгэл, магистр (Английн Ливерпүүлийн ИС) Хуульч, өмгөөлөгч Б.Энхтунгалаг нар ажиллаж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар гүйцэтгэв.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулж, хохирогчийн эрхийг хангах асуудал нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул Урьдчилан тандан судлах ажиллагааг уг аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Манай улсад гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг Цагдаагийн ерөнхий газар хэрэгжүүлж байгаа бөгөөд Авилгатай тэмцэх газар болон Тагнуулын ерөнхий газар өөрсдийн харьяалан шалгаж байгаа хэргийн гэрч хохирогчийг хамгаалах үүрэгтэй ажиллаж байгаа бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг Цагдаагийн ерөнхий газар болон Авилгатай тэмцэх газар хэрэгжүүлж байна.

Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлохын тулд Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Авилгатай тэмцэх газраас нөхцөл байдлын талаарх лавлагаа, үйл ажиллагааны тайлан, тоон мэдээлэл цуглуулах, асуудал хариуцсан мэргэжилтэн, албан тушаалтантай ярилцлага хийх, судлаачид болон энэ чиглэлээр ажиллаж байсан албан хаагч, иргэдтэй ярилцлага хийх, тэдгээрийн бичсэн, нийтлүүлсэн баримт мэдээ, материал судлах, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үндэсний болон гадаад улсын хууль тогтоомж судлах хэлбэрээр чанарын мэдээллүүдийг ашигласан болно.

1.1.Асуудлын мөн чанар, цар хүрээ

Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталж, гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн бөгөөд уг хууль 11 дэх жилдээ хэрэгжиж байна. Уг хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг тусалцаа үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлагдсанаас хойш 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд эдгээрээс 1 нь бие даасан, 4 нь бусад хууль батлагдсантай холбогдуулан оруулсан нэмэлт, өөрчлөлт байна. Хуулийн нийт 28 зүйлийн 22 зүйлд нь буюу хуулийн 78 хувьд тодорхой хэмжээгээр нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Энэхүү судалгаагаар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхгүй бөгөөд судалгааны хүрээгээр хязгаарлаж, асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлох дараах бие даасан 2 асуудлыг авч үзнэ:

1/Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн орчин, үйл ажиллагааны практик хэрэгжилтийн байдал, үйл ажиллагаанд гарч байгаа хүндрэлтэй асуудлыг тодорхойлж, бодит байдалд дүгнэлт хийнэ. Мөн гэрч, хохирогчийг хамгаалах бүтцийг шинээр байгуулахтай холбогдуулан 2016 онд хүчингүй болсон Тахарын албаны тухай хуулийн дагуу Тахарын ерөнхий газрын хэрэгжүүлж байсан шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн орчин, практик хэрэгжилтийн байдлыг мөн авч үзнэ.

2/Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллага, түүний эрх зүйн орчин, хэргийн харьяалал, хамаарах субъектийн хүрээ, мөрдөн шалгах ажиллагааны хэрэгжилтийн байдал, тулгарч байгаа хүндрэлтэй асуудал зэргийг тодорхойлж, бодит байдалд дүгнэлт хийнэ.

1.1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллага, эрх зүйн орчин, үйл ажиллагааны практик хэрэгжилт

Эрх зүйн орчин. Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагатай байх зохицуулалтыг анх 2013 онд батлагдсан Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиар бүрдүүлсэн.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйл:

23 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг

/Энэ зүйлийн гарчигт 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

23.1.Хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ:

23.1.1.цагдаагийн алба;

23.1.2.мөрдөх алба;

/Энэ заалтыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

23.1.3.Тахарын алба;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

23.1.4.Авлигатай тэмцэх газар;

23.1.5.Тагнуулын ерөнхий газар.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагууд нь тухайн байгууллагын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна.

23.5.Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ

Хуулийн 23.1.3-т заасан Тахарын алба байгуулах эрх зүйн үндсийг 2013 онд батлагдсан Тахарын албаны тухай хуулиар тогтоосон бөгөөд уг хуулийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэгтэй Тахарын ерөнхий газрыг 2014 онд байгуулж, 2016 он хүртэл үйл ажиллагаа явуулж байгаад 2016 онд Тахарын албаны тухай хуулийг хүчингүй болгож, Цагдаагийн албаны тухай хууль /2013 он/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2002 он/, Авилгын эсрэг хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Тахарын албаны хэрэгжүүлж байсан чиг үүргийг цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлсэн.

-Цагдаагийн албаны тухай хууль /2013/-д:

11 дүгээр зүйл.Олон нийтийн аюулгүй байдлыг хангах

11.1.Цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд доор дурдсан эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

11.1.5-д "цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах эрх хэмжээг хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл.Гэмт хэрэгтэй тэмцэх

9.2.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд доор дурдсан эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

9.2.6.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах, баривчлах; /Энэ заалтыг 2016 оны 7 сарын 21-ний өдрийн хуулиар оруулсан нэмсэн/

9.2.7.яллагдагчийг шүүхэд хуяглан хүргэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

/Энэ заалтыг 2016 оны 7 сарын 21-ний өдрийн хуулиар оруулсан нэмсэн/

Дээрх хуулийн дагуу Тахарын албаны хэрэгжүүлж байсан гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах, яллагдагчийг шүүхэд хуяглан хүргэх чиг үүрэг цагдаагийн албанд шилжсэн байна.

-Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017/:

"10 дугаар зүйл.Гэмт хэрэгтэй тэмцэх

10.1.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.7.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;

10.1.8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;
10.1.9.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;"

12 дугаар зүйл. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах

"12.1.Цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.8.яллагдагч, шүүгдэгч, ялтныг цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хуяглан хүргэх."

46 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох

46.2.Цагдаагийн алба хаагч шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн хүн, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг авна."

2017 онд шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу сэжигтэн, яллагдагчаас гадна шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагаа явуулах, шүүхээс оргон зайлсан тохиолдолд тэдгээрийг эрэн сурвалжлахаар заасан бөгөөд яллагдагчаас гадна шүүгдэгч, ялтныг цагдан хорих байрнаас шүүхэд хуяглан хүргэх, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хуяглан хүргэх чиг үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэхээр өргөжүүлж заасан байна.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль/2002/:

113 дугаар зүйл.Оргосон ялтныг эрэн сурвалжлах

113.1.Баривчлах байр, хорих ангийн харуул хамгаалалтыг зохион байгуулах, баривчлах байр, хорих ангиас оргосон яллагдагч, ялтныг мөрдөн хөөх, баривчлахад албаны нохой ашиглаж болох бөгөөд үүнийг зохих алба хариуцан гүйцэтгэнэ.

113.2.Баривчлах байр, хорих ангиас оргосон яллагдагч, ялтныг мөрдөн хөөх, баривчлах ажиллагааг эрэн сурвалжлах хэсэг гүйцэтгэнэ.

113.3.Онц аюултай буюу зэвсэглэсэн ялтныг мөрдөн хөөх, баривчлах, түүнчлэн ялтны дунд гарсан эмх замбараагүй байдлыг өөрийн хүчээр таслан зогсоох боломжгүй болсон тохиолдолд зохих байгууллагаас нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, хүн хүч, тусгай тоног төхөөрөмжийн туслалцаа авах болон бусад шаардагдах арга хэмжээг нэгдсэн журмаар авч хэрэгжүүлэх ба энэ журмыг Засгийн газраас тогтооно."

/113.1, 113.2, 113.3 дахь хэсэгт 2016 оны 7 сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

Дээрх хуулийн дагуу хоригдлыг эмнэлэгт хүргэх, оргосон ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжсэн бол эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг цагдаагийн байгууллага хариуцахаар заасан байна.

Харин 2017 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ял хорих газарт эдэлж байгаа хоригдол-гэрч, хохирогчийг хамгаалах, ялтныг эрэн сурвалжлах, хуяглан хүргэх, мөрдөн хөөх талаар дараах зохицуулалтыг тусгасан байна:

230 дугаар зүйл.Хоригдлын аюулгүй байдлыг хангах, хоригдлыг тусгаарлах тасалгаанд шилжүүлэх

230.5.Хорих анги, хорих ангийн алба хаагч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авсан хоригдлыг хамгаалах ажиллагаанд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй."

242 дугаар зүйл.Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт

"242.2.Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих ял эдлүүлэх газар, хэлтэс нь хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагатай дараахь чиглэлээр хамтран ажиллана:

242.2.4.оргосон хоригдол, хоригдсон этгээдийг эрэн сурвалжлах, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад туслалцаа авах;

242.2.5.хоригдол, хоригдсон этгээдийг нүүлгэн шилжүүлэх, хуяглан хүргэх ажиллагаанд дэмжлэг авах.

250 дугаар зүйл.Оргосон хоригдол, хоригдсон этгээдийг эрэн сурвалжлах

250.1.Оргосон хоригдлыг мөрдөн хөөх, баривчлах ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага хамтран зохион байгуулна.

250.2.Оргосон хоригдлыг мөрдөн хөөх, баривчлах, эсхүл хорих байгууллагад гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоход бусад байгууллагаас хүч хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж татан оролцуулж болно.

Хуулийн дээрх заалтын дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь оргосон хоригдлыг эрэн сурвалжлах, нүүлгэн шилжүүлэх, хуяглан хүргэх, мөрдөн хөөх, баривчлах ажиллагааг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль сахиулах бусад байгууллагаас дэмжлэг авахаар тусгасан байна.

-Гүйцэтгэх ажлын тухай хууль /1997/:

9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:
9.1.3.цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдал болон шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох; /Энэ заалтад 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
9.1.4.шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах түүнчлэн энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.6-д заасан байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх;
/Энэ заалтад 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
9.1.7.тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, шүүх, шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх
/Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 5-ны хуулиар нэмсэн. 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

Чиг үүргийн шилжилттэй холбогдуулан шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхийг цагдаагийн байгууллагад олгосон.

-Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүхийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүрэг бүхий захиргааны байгууллага байхаар заасан бөгөөд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар дараах зохицуулалтыг тусгажээ:

49 дүгээр зүйл.Шүүгчийн халдашгүй байдал

49.6.Шүүгч аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор бие хамгаалах тусгай хэрэгслийг эзэмших, биедээ авч явах эрхтэй.

71 дүгээр зүйл. Шүүхийн бие даасан байдлыг хангах

71.1.Ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

71.1.22.шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах;

71.2.Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн,шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэх журмыг Ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Дээрх хуулиар шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар хэрхэн ажиллах талаар тодорхой зохицуулалт байхгүй, хамтарсан журмаар зохицуулахаар тусгагдсан байна.

Шүүхийн тухай хуулийн 71.2-т заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2021 оны А116/65 дугаар тушаалаар "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталсан.

-Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам:

2.1.Бүх шатны шүүхийн байнгын болон нүүдэллэн ажиллах байр, шүүхийн захиргааны байр, шүүхийн тусгай архивын байр болон шүүхийн барилга байгууламжийн харуул хамгаалалтыг цагдаагийн байгууллага бүрэн хариуцаж, шүүхийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу гүйцэтгэнэ.

2.2.Цагдаагийн байгууллага нь шүүх, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.2.2.шүүх, шүүхийн барилга байгууламжийг 24 цагаар харуул хамгаалалтад байхаар зохион байгуулж, харуулын цагдаагийн ажиллах дэг горимыг тогтоох;

2.2.5.шүүх хуралдааныг өөр газар явуулах /цагдан хорих байр, нүүдэллэн ажиллах г.м/ болон "Сахилгын хороо"-ны хуралдаанд шүүгч оролцох үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шүүхийн тамгын газартай хамтран зохион байгуулах;

2.2.7.шүүх болон түүний гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гэнэтийн халдлага гарах, шүүгч, гэрч, хохирогчийн амь биед халдах, барьцаалах, шүүхийн байр руу дайрах, бүслэх, үйл ажиллагааг тасалдуулахыг оролдох, галдан шатаах, шүүхийн байрны орчимд замын хөдөлгөөн хаах зэрэг иргэд, байгууллагын зүгээс учруулж буй аливаа хууль бус үйлдлийн улмаас шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй, мөн үйл ажиллагаанд нь саад учруулсан буюу учруулахаар оролдсон онцгой нөхцөл үүссэн тохиолдолд учрах эрсдэл, аюулыг зайлуулах, түүний хохирлыг багасгах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шүүхийн байрыг хүч нэмэгдүүлсэн хамгаалалтад авах;

4.6.Шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлын хамгаалалтыг биечлэн дагах хэлбэрээр зохион байгуулна.

Мөн журмаар цагдаагийн алба хаагчийн шүүх, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах талаар хүлээх эрх, үүрэг, хориглох зүйл, шүүх хуралдааны дэг сахиулах талаар хамгаалалтын албан хаагчийн хэрэгжүүлэх ажиллагааг журамласан.

"Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам"-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/301,186 дугаар тушаалаар баталж, 2021 оны А116/65 дугаар тушаалаар баталсан журмын 4-р бүлгийг хүчингүй болгосон байна.

Уг журмаар шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндийг хамгаалалтад авах хүсэлт гаргах, шийдвэрлэх, хамгаалалт хэрэгжүүлэх гэрээ байгуулах, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх зохицуулалт тусгагдсан байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг 9 хэлбэрийн хамгаалалтын арга хэрэгслээр хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд дараах журмыг эрх бүхий этгээд батлан мөрдүүлж байна:

- "Гадаад төрхийг өөрчлөх аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам" Хууль зүйн сайдын 2014 оны А/110 дугаар тушаалаар баталсан;
- "Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэглэх журам"-ыг Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаалаар баталсан;
- "Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам"-ыг Хууль зүйн сайдын 2014 оны А/113 дугаар тушаалаар баталсан;
- "Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам"-ыг Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356,А/182 дугаар тушаалаар баталсан;

- “Биечилсэн хамгаалалтын журам”-ыг Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан;
- “Нүүлгэн шилжүүлэх журам”-ыг Хууль зүйн сайдын 2016 оны МН/101 дүгээр тушаалаар баталсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны МН/05, 2021 оны МН/111 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан;
- “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/73 дугаар тушаалаар баталсан;
- “Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан.;
- “Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих журам”-ыг Хууль зүйн сайдын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны МН/04, 2021 оны МН/113 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- “Тусгай хамгаалах байр байгуулах, ашиглах журам Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 онд баталсан, нууцын зэрэглэлтэй;
- “Биечилсэн хамгаалалтын заавар”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 онд баталсан, нууцын зэрэглэлтэй;
- “Гэрч, хохирогчийг хамгаалах журам /код 507/”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/275 дугаар тушаалаар баталсан, нууцын зэрэглэлтэй;

Дээрх журам, зааварт батлагдсанаас хойш 1-5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д 2021 оны 294 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулснаар “Нүүлгэн шилжүүлэх журам”, “Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих журам”, “Гэрч, хохирогчийн гадаад төрхийг өөрчлөх журам”-ыг нууцын зэрэглэлээс гаргажээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтад чухал байр эзлэх дараагийн баримт бичиг бол гэрч, хохирогчийг хамгаалах Үндэсний хөтөлбөр юм.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасны дагуу Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Хөтөлбөрийн зорилго нь гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг нь нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, тэдэнд төрөөс нийгмийн халамж, туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгохоор зааж, 6 зорилтын хүрээнд 35 ажил, арга хэмжээг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/46 дугаар тушаалаар “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл”-ийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулан, бүрэлдэхүүнд нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Гадаад харилцааны яам, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл багтсан гишүүдтэй байгуулсан

Зөвлөлөөс Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зарим ажил, арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр 2021, 2022 онд Зөвлөмж гарган, хэрэгжүүлсэн байна.

Дүгнэвэл: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Тахарын албаны тухай хуулиар гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх анхны бие даасан бүтэц ажиллах эрх зүйн үндэс бүрдсэн боловч Тахарын албаны тухай хуулийг хүчингүй болгосноор түүний чиг үүрэг цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, авилгатай тэмцэх газар, тагнуулын байгууллагын үндсэн чиг үүрэг дээр нэмэлт байдлаар хэрэгжихээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулан шилжүүлсэн байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах, оргон зайлсан хоригдлыг эрэн сурвалжлах, мөрдөн хөөх, баривчлах, хоригдлыг нүүлгэн шилжүүлэх, хуяглан хүргэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон цагдаагийн байгууллагын хамтарсан хүчээр хэрэгжүүлэх эрх зүйн орчин үйлчилж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа практик хэрэгжилт: Монгол Улсад гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг 2014-2016 онд Тахарын албаны тухай хуулийн дагуу байгуулагдсан Тахарын Ерөнхий газар хэрэгжүүлж байсан бөгөөд тус газар 2014-2016 онд нийт 41 хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.¹

Тахарын ерөнхий газрын даргаар 2014-2016 онд ажиллаж байсан н.Азбаяртай хийсэн ярилцлагын хэсгээс:

Тахарын Ерөнхий газар анх байгуулагдаад 880 хүнтэй, 1 аймагт 10-аад албан хаагч ажиллаж байсан. Шүүхийн хамгаалалт, захиргаа, хяналт шалгалтын асуудал хариуцсан 3 дэд даргатай. Төрийн тусгай, төрийн захиргааны албан хаагч ажиллаж байсан. Тойргийн системд хувааж байсан. Шүүхийн байран дээр тахар байрладаг байсан. 1 шүүх дээр 17, 18 албан хаагч байсан. Туршлага судлах зорилгоор АНУ-ын Маршалын албаны үйл ажиллагаатай танилцах аяллыг 2 удаа хийсэн. Маршалын албаны академид албан хаагчдыг сургах төлөвлөгөөтэй байсан, сургалт их чухал байдаг. Тахар өөрийн хамгаалах байргүйгээс ТББ-ын байрыг ашиглах талаар яриа хэлцэл хийдэг байсан. Мөн гэрээт харуул хамгаалалттай хамтрах хэрэг ч гардаг. Гэрчийг асуух өрөө бэлдэж туршиж байсан. Орон нутагт 2 жилд хамгаалалт авах хэрэгцээ гараагүй. Гэрч, хохирогчид мөрдөгч нөлөөлж болзошгүй. Жнь: цагдаагийн хэрэг, зоригийн хэрэг г.м. Албадан ирүүлэхэд цагдаатай заавал хамтарч очих хэрэгтэй болдог. Тахарын алба 2016 онд татан буугдахад албан хаагчид цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хуваагдаад очсон. Цагдаад очсон албан хаагчдын цалин, цол буурсан, энэ тал дээр гомдолтой байдаг. Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цалин, цолыг бууруулалгүй ажлын байраар хангасан.

Дүгнэвэл: Тахарын ерөнхий газар хоёр жил гаруй богино хугацаанд боловч аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч байсан, зохих хэмжээний туршлага эзэмшсэн албан хаагчдыг бэлтгэсэн байна.

Мөн тус алба АНУ-ын Маршалын албаны үйл ажиллагаатай газар дээр нь очиж 2 удаа танилцсан, цаашид албан хаагчдыг сургах сургалтуудыг төлөвлөж байснаас харахад үйл ажиллагаандаа Маршалын албаны туршлагыг нэвтрүүлэх зорилго, чиглэл баримталж байжээ.

2016 онд Тахарын албаны чиг үүргийг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлснээр гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх, оргон зайлсан яллагдагчийг эрэн

¹ ЦЕГ-ын Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн тайлан. 2024.9 сар.


сурвалжлах чиг үүргийг цагдаагийн байгууллага, ялтныг хуяглан хүргэх, эрэн сурвалжлах, ялтан шилжүүлэх чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж байна.

Цагдаагийн ерөнхий газарт 2016 онд Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийг Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын шууд удирдлагад 26 орон тоотойгоор байгуулж, гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдэд хуульд заасан туслалцааг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тус хэлтэс 2 тасаг, 41 алба хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд гэрч, хохирогчийг хамгаалах шууд чиг үүрэгтэй 27 алба хаагчийн орон тоотой байна.

ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн бүтэц, орон тоо:

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН
БҮТЭЦ, ОРОН ТОО /2024 он/



Орон нутгийн цагдаагийн хэлтэст гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий тусгайлсан нэгж, албан хаагч байхгүй бөгөөд тухайн нэгжийн даргын тушаалаар тус чиглэлийг хариуцсан албан хаагчийг томилуулан үндсэн чиг үүргийнх нь хүрээнд хавсран гүйцэтгүүлэх байдлаар ажиллуулж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг цагдаагийн байгууллагад шилжсэнээс хойшхи хугацааны буюу 2016-2024 оны эхний 7 сарын байдлаар үйл ажиллагааны төрөл, хэлбэр тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна:

1/ Хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээний төрөл, хэлбэр

Хүснэгт 1

№	Хамгаалалтын арга хэмжээний хэлбэр	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
1	Урьдчилан сануулах	19	5	31	109	77	205	242	129	77	894
2	Тодорхой үйлдлийг хязгаарлах	-	2	3	8	6	4	1	1	-	25
3	Биечилсэн хамгаалалт	5	10	9	12	10	12	10	7	3	78
4	Мэдээллийн нууцлалыг хангах	-	-	1	1	1	2	2	-	-	7
5	Нэг бүрийн тусгай хэрэгсэл, тусгай техник хэрэгслээр хангах	4	3	4	7	4	1	1	2	-	26
6	Аюулгүй газарт түр байрлуулах	5	2	3	7	6	2	5	-	-	30
7	Баримт бичгийг солих	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Нүүлгэн шилжүүлэх	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Гадаад төрхийг өөрчлөх	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ	-	-	-	-	-	6	9	7	5	27
Нийт дүн		33	22	51	144	104	232	270	146	85	1087

Дүгнэвэл: нийт 1103 иргэнийг хамгаалалтад авч, 1087 хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.² Дээрх хүснэгтээс харвал авагдсан хамгаалалтын хэлбэрийн хувьд урьдчилан сануулах хамгаалалт хамгийн олон удаа авагдсан байгаа нь уг арга хэмжээг мөрдөгч бие даан хэрэгжүүлэх боломжтой түүнчлэн хүн хүч, хөрөнгө зардал шаардахгүй хэрэгждэгтэй холбоотой байна. Харин биечилсэн хамгаалалтын арга хэмжээг 78 удаа хэрэгжүүлсэн, цаашид энэ арга хэмжээний хэрэгцээ, шаардлага өсөх хандлагатай тул байгууллага, албан хаагчийн хувьд бэлтгэлтэй байх шаардлагатай байна.

Баримт бичиг солих, гадаад төрх өөрчлөх, нүүлгэн шилжүүлэх хамгаалалт огт авагдаагүй байгаа нь манай улсад эдгээр хамгаалалт хийх хэрэгцээ өнгөрсөн хугацаанд хараахан үүсээгүй бөгөөд энэ чиглэлээр бид хангалттай туршлага хуримтлуулж чадаагүй гэсэн дүгнэлт гарч байна.

2/Хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчийг хэргийн төрлөөр авч үзвэл

Хүснэгт 2

№	Эрүүгийн хэрэг	Хамгаалалтад авагдсан иргэн									Нийт дүн
		2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	9	11	4	3	-	5	3	4	4	43
2	Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /Гэр бүлийн хүчирхийлэл/	16	6	25	98	53	127	71	83	43	522

² ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс ХЗДХЯ-нд ирүүлсэн тайлан, 2024 оны 9-р сар.

3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9	10	10	17	13	55	62	39	28	243
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	-	-	10	-	25	24	97	9	5	170
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	8	3	3	7	4	21	19	3	1	69
6	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	-	-	12	3	1	2	6	-	-	24
7	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	-	-	-	4	1	-	1	-	-	6
8	Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхолын эсрэг гх	-	-	-	-	1	-	-	-	-	1
9	Бусад	-	6	1	2	3	3	2	4	4	25
Нийт		42	36	65	134	101	237	261	138	85	1103

Дүгнэвэл: Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /Гэр бүлийн хүчирхийлэл/, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгийн олон удаа хамгаалалтад авсан байна. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг хамгийн цөөн байна.

3/ Хамгаалалтад авагдсан иргэдийн нас, хүйсийн байдлаар авч үзвэл:

Хүснэгт 3

Он/ нас, хүйс	Хамгаалалтад авагдсан иргэдийн хүйс, насны бүлэг								Нийт
	0-14		15-17		18-35		36-с дээш		
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	
Дүн	116	35	87	8	344	128	261	124	1103
Дүн	151		95		472		385		

Хамгаалалтад авсан насанд хүрээгүй хүүхэд 246 байгаагийн 203 нь эмэгтэй байгаа бөгөөд үүний дийлэнх нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч байна.

4/ Гэрч, хохирогчийг хамгаалалтад авах шийдвэр гаргасан субъект /2016-2023/

Хүснэгт 4

№	Эрх бүхий албан тушаалтан	Шийдвэрийн тоо
1	Шүүгч	21
2	Прокурор	154
3	Цагдаагийн ерөнхий газрын дарга	14
4	Мөрдөгч бие даан шийдвэр гаргасан /урьдчилан сануулах/	898
Нийт		1087

Мөрдөгч болон прокурорын шийдвэрээр гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан тохиолдол өндөр хувьтай байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.1-7.1.6-д заасан хамгаалалтын төрлийн хувьд дундаж хугацаа 1-3 сар байгаа бөгөөд биечилсэн хамгаалалтад авсан хамгийн богино хугацаа 5 хоног, хамгийн урт хугацаа 3 жил 4 сар байсан байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу улсын хэмжээнд цагдаагийн байгууллагаас гадна Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар тус бүр харьяалан шалгаж буй хэргийн шаардлагатай гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалахаар заасан боловч дээрх хоёр байгууллага одоог хүртэл тусгайлсан алба байгуулаагүй, Авлигатай тэмцэх газар нь Цагдаагийн ерөнхий газартай байгуулсан гэрээний үндсэн дээр өөрсдийн харьяалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг цагдаагийн байгууллагаар хамгаалуулж байна.

АТГ-тай хамтран ажиллах гэрээний дагуу 2021 оноос хойш эрх бүхий албан тушаалтны 2 шийдвэрээр 5 төрлийн хамгаалалтын арга хэмжээг ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс хэрэгжүүлсэн бөгөөд үүнд биечилсэн хамгаалалт, аюулгүй газарт түр байрлуулах, нэг бүрийн тусгай хэрэгсэл, техник хэрэгслээр хангах, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ багтсан байна.

Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан "Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн Нэгдүгээр үе шат 2016-2018 он /9.340.3 сая төгрөг/, Хоёрдугаар үе шат 2019-2021 он /5.256.0 сая төгрөг/, Гуравдугаар үе шат 2022-2024 он /6.541.3 сая төгрөг/-д улс, орон нутгийн төсөв, хандивлагч орон болон олон улсын байгууллагын тусламж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн тусламж, бусад эх үүсвэрийн санхүүжүүлэлтээр нийт 21.1 тэрбум төгрөг зарцуулан хэрэгжүүлэхээр баталсан.

Цагдаагийн ерөнхий газрын Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсээс хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 2020 онд 48 ажил, арга хэмжээг 93,4%, 2021 онд 57 ажил, арга хэмжээг 66,5%, 2022 онд 35 ажил, арга хэмжээг 63,1%, 2023 онд 27 ажил, арга хэмжээг 83,7%, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 29 ажил, арга хэмжээг 73,4 хувьтай тус тус хэрэгжүүлжээ.

Үүнээс 19 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөв хөрөнгө зайлшгүй зарцуулахаар тусгагдсан бөгөөд 2020-2023 онд 1.542.0 сая- 304.643.7 сая төгрөгийг төсөвт тусгуулахаар саналыг хүргүүлдэг боловч төсөв батлагддаггүй талаар албаны хүмүүс дурдаж байна.

Дүгнэвэл: Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах зардлыг төсөвт тусгаж өгдөггүйгээс гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зардлаар шийдвэрлэж ирсэн нь хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.

Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудлыг хамгаалалтын арга хэмжээ тус бүрээр тоймловол дараах байдалтай байна:

Хүснэгт 5.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, анхаарах асуудал

Урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хориглох	Хамгаалуулагчийг заналхийлж байгаа этгээдийг судлах, үйл хөдлөлд хяналт тавих, мэдээ, мэдээлэл цуглуулах, хяналтад авах нь чухал байдаг бөгөөд гүйцэтгэх ажил явуулах нь заналхийлэгч этгээдийг бүрэн, тал бүрээс нь тодорхойлох, хяналтад авснаар хамгаалуулагчийн аюулгүй байдал хангагдах ач холбогдолтой. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т зааснаар гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Гүйцэтгэх ажил явуулахаар заасан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяаллын бус хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хязгаарласан. Иймд заналхийлэл байгаа эсэхийг шалгах мөрдөн шалгах эрхийг олгох асуудлыг судлан үзэх шаардлагатай байна.
Биечилсэн хамгаалалт	Хамгаалалтын арга хэмжээ авахад албан хаагчдын тоо хүрэлцэхгүй бусад нэгжээс алба хаагчийг дайчлан ажиллуулах байдлаар зохицуулж ирсэн. Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан Биечилсэн хамгаалалтын зааварт хамгаалуулагчид учирч болох эрсдэлийн түвшингээс хамаарч 1 хамгаалуулагчид 2- 5 буюу түүнээс дээш алба хаагч үүрэг гүйцэтгэхээр заасан нь хамгаалалтыг шууд хэрэгжүүлэх 27 алба хаагчаар тооцвол өндөр эрсдэлтэй 1 хамгаалуулагч, дунд эрсдэлтэй 2 хамгаалуулагчийг хамгаалах хүч юм.

Мэдээллийн нууцлалыг хангах хамгаалалтын арга хэмжээ	Иргэний мэдээллийг хадгалдаг 140 төрлийн цахим санг ашигладаг төрийн болон төрийн бус байгууллагууд программ хангамжийн хувьд нэгдсэн нууцлах систем, мэдээллийн сан байхгүй, хамтран ажиллах уялдаа холбоогүй /иргэний мэдээллийг нууцалсны дараа тухайн иргэний нийгмийн даатгал, татвар, цалин тэтгэмж, халамж, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг бусад шаардлагатай үйлчилгээ авах асуудал тодорхойгүй байгаа нь тус хамгаалалтын арга хэмжээг эрсдэлгүй, түргэн шуурхай, нэгдсэн байдлаар зохион байгуулахад хүндрэл учруулж байна.
Тусгай техник, хэрэгслээр хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ	Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашиглагдах техник, хэрэгслүүд нь хангалтгүй, цахим техник хэрэгсэлд хяналт тавих дэлгэцийг байршуулах нууцлал, аюулгүй байдлыг хангасан өрөө, тасалгааны хүрэлцээ дутмаг.
Аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ	Тус хэлтсийн мэдэлд хамгаалах байр байхгүй, үйл ажиллагаандаа бусад байгууллагын хамгаалах байрыг ашигладаг. Эдгээр байгууллагууд нь тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчийг байрлуулах шаардлагыг тавьдаг нь бусад төрлийн гэмт хэргийн хохирогч, гэрч нарыг байрлуулан хамгаалах боломжийг хязгаарлаж байна. Мөн хамгаалах байр байгуулах, байранд ажиллах хүн хүч, үйл ажиллагааны болон үрсгал засварт зарцуулах төсөв хүрэлцээгүй.
Нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ	Энэ төрлийн хамгаалалтыг хэрэгжүүлээгүй байгаа бөгөөд зохих туршлага хуримтлагдаагүй. Баримт бичиг солих хамгаалалтын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтгүй. Иргэний мэдээллийн санд өөрчлөлт оруулан шинэ хүн бий болгох замаар хэрэгжүүлэх арга хэмжээ тул үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх, тухайн иргэний мэдээлэл, нууцлал аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй. Энэ чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай. Улсын бүртгэлийн иргэний болон эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлд хандах, өөрчлөх, хянах эрх байхгүй.
Бусад асуудлаар: - ЦЕГ-ын Гэрч, хохирогчийн хамгаалах хэлтсийн бүтэц, орон тоогоор хуулийн зорилтыг хангахад хүндрэлтэй байна. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий алба хаагчдын үндсэн ажилд ачаалал үүсгэж буй захиргааны асуудлыг шийдвэрлэх, алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн. Хамгаалалтад алба хаагчдын тоо хүрэлцэхгүй бусад нэгжээс алба хаагчийг ажиллуулах байдлаар зохицуулж ирсэн. Хамаарал бүхий этгээдийг хамгаалалтад авнахад хүн хүч, байр гээд хэрэгцээ өсдөг. Мөн Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн байгууллага тус бүр харьяалан шалгаж буй хэргийн шаардлагатай гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалахаар зохицуулсан боловч дээрх хоёр байгууллага одоог хүртэл тусгайлсан алба байгуулаагүй, Авлигатай тэмцэх газар нь гэрээний үндсэн дээр өөрсдийн хамгаалалтад авах гэрч, хохирогчийг цагдаагийн байгууллагаар хамгаалуулдаг. - Монгол Улсын хэмжээнд гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, туршлага судалж болохуйц бусад байгууллага байдаггүй. Албан хаагчдыг сургалтад хамруулах, туршлага судлуулах ажил төсөв, санхүүгийн хүндрэлээс шалтгаалан хэрэгждэггүй. - Хамгаалалтын үйл ажиллагаанд шаардагдах тусгайлсан зардал, эд зүйлсийг Санхүү, ар талын албаар дамжуулан шийдвэрлүүлж байгаа нь хамгаалалтын арга хэмжээний нууцлал аюулгүй байдал алдагдах, төсөв, санхүүг шийдвэрлүүлэх цаг хугацаа алдах зэрэг эрсдэлийг үүсгэдэг. - Хамгаалуулагч болон албан хаагчид учирч болох гадаад, дотоод эрсдэлийг тооцож хариу арга хэмжээ авах, ГА-ын шугамаар олж авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, магадлалыг тодорхойлон эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллах эрсдэл, дүн шинжилгээний нэгжгүйн улмаас эрсдэлээс урьдчилан сэргийлэх, алба хаагчдыг мэдээ, мэдээллээр хангах, хамгаалалтын үйл ажиллагааг аюул, эрсдэлгүй зохион байгуулахад төвөгтэй.	

Мөн гэрч, хохирогчид нөлөөлж байгаа зорилгыг авч үзвэл шүүгдэгчийн зүгээс хэргийг өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, ял завших зорилгоор мөнгө өгөх, амлах, гуйж, ятгах, өрөвдүүлэх, сүрдүүлэх, заналхийлэх байдлаар нөлөөлдөг бол цагдаагийн байгууллагын ажилтны хувьд хэрэг

илрүүлэх буюу өөрийн албан ажлын зорилгоо гүйцэлдүүлэх зорилгоор таагүй харьцаа байдалтай байх, сүрдүүлэх, дарамтлах байдлаар нөлөөлдөг байна.³

Дүгнэвэл: Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд гарч байгаа хүндрэлийг үүсгэж байгаа шалтгаан нь уг алба бие даасан статусгүй, тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллагын бүтцэд байгаа нь үйл ажиллагааг хангалттай хэрэгжүүлэх хүн хүч, техник, хэрэгсэл, санхүүгийн хувьд хүндрэл үүсгэдэг, мөн цагдаагийн байгууллага гэрч, хохирогчийг хамгаалж байгаа нь үйл ажиллагаа бие даасан төсөв санхүүтэй байх хараат бус байх зарчмыг алдагдуулж байна.

Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд:

Эрх зүйн орчин. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар уг хуулийн зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино гэж тодорхойлсон.

Гэвч 2020 онд хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн зохицуулалтад гэрч, хохирогчоос гадна хүний эрх хамгаалагч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн хүнийг хамааруулж болохоор, 2021 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрч хамаарахаар заасан.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль:

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурлсан утгаар ойлгоно:

4.1.1. "гэрч, хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг;

5 дугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

5.1. Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч хамаарна.

5.2. Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.

5.3. Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.

5.4. Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно.

Хүснэгт 6. Хуулийн үйлчлэлд хамаарч байгаа бусад этгээдийн тодорхойлолтыг холбогдох хуулиас харвал:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2013/	8.1. Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ. 9.6 дугаар зүйл. Гэрч 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.
Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль /2021/	"4.1.1. "хүний эрх хамгаалагч" гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг;"

³ ХЗДХЯ-ны архив. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хувийн хэрэг 2-р хавтас.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /2024/	38.1."Гэрч" гэж тусгай шалгах асуудал, үйл баримтыг нягтлан тодруулахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ.
--	--

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зорилго нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалалтад авахаар анх тодорхойлогдож байсан боловч уг хуульд заасан гэрч, хохирогчоор тогтоогдоогүй этгээд болох хүний эрх хамгаалагч, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалалтад авахаар хамгаалах субъектийн хүрээг өргөжүүлжээ. Мөн хуулийн 5.4 дэх хэсгээр гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн буюу "мэдээлэгч"-ийг хамгаалалтад авах эрхийг нээлттэй үлдээжээ.

Практик хэрэгжилт. Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс авсан тайлан мэдээгээр 2016-2024 онд нийт 1103 этгээдийг хамгаалалтад авсан байна. Хамгаалалтыг хэрэгжүүлсэн субъектээр авч үзвэл дараах байдалтай байна:

Хүснэгт 7. Хамгаалуулагчийн төрөл

№	Он	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
1	Гэрч	4	6	6	8	6	15	12	8	4	69
2	Хохирогч	23	11	39	120	82	212	243	132	79	941
3	Хамаарал бүхий этгээд	12	11	17	4	6	8	4	-	-	62
4	ГХХ тухай хуулийн 5.4-т заасан иргэн	-	3	-	-	-	1	1	2	-	7
5	Шүүгч	3	3	1	-	4	-	1	-	2	14
6	Прокурор	-	2	2	2	3	1	-	-	-	10
7	Нийт	42	36	65	134	101	237	261	142	85	1103

Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 2019-2023 оны хооронд өссөн үзүүлэлттэй байгаа ба дунджаар нэг жилд 30 мянга гаруй иргэн гэмт хэргийн хохирогч болж байна.⁴ гэсэн статистикийн тоо баримт байна. Хамгаалалтад авсан хохирогчийн тоо нийт хамгаалуулагчийн 85 хувийг эзэлж байна.

Хамгаалалтын арга хэмжээ, хамгаалалтад авагдсан гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий иргэдийн тоо 2016-2022 онуудад жил тутам тогтмол өссөн бол 2023 онд буурсан үзүүлэлттэй байна.

2016 онд хүчингүй болсон Тахарын албаны тухай хуулиар гэрч, хохирогч, шүүгчийн аюулгүй байдлыг хангахаас гадна мөн хуулийн 9.7-д Тахарын алба нь шаардлагатай гэж үзвэл улсын яллагчийг хамгаалалтад авахаар заасан. Гэвч уг хууль хүчингүй болсноор улсын яллагчийг хамгаалалтад авах зохицуулалт бусад хуульд тусгагдаагүй орхигдсон байна.

2016-2024 онд шүүгч, прокурорт хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээг авч үзвэл нийт 2 удаа 4 шүүгчид хамаарах урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээ, 7 удаа 14 шүүгчид биечилсэн хамгаалалт, 3 удаа 5 шүүгчид нэг бүрийн тусгай хэрэгсэл, тусгай техник хэрэгслээр хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн бол дээрх хугацаанд 5 удаа 8 прокурорт биечилсэн хамгаалалт, 3 удаа 6 прокурорт нэг бүрийн тусгай хэрэгсэл, тусгай техник хэрэгслээр хангах арга хэмжээг хэрэгжүүлжээ.

⁴ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо, хүйс, насны ангилал, сумаар, жилээр (2019-2023) <http://1212.mn/>, сүүлд үзсэн 2024 оны 9 сар.

Мөн дотоодын зарим байгууллагуудаас хийсэн судалгаагаар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтад зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан гэрч, хохирогчийг хамаарахаар заасан нь хохирогчийн эрхийг хамгаалах тал дээр учир дутагдалтай талаар дурджээ.

Тухайлбал, НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд IRIM судалгааны хүрээлэнгээс 2022 онд хийсэн “Монгол Улс дахь Хүн худалдалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа”-нд “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийг өргөн хүрээнд тодорхойлсон байх бөгөөд хохирогч нь заавал хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл шалтгаалан үйлчилгээ үзүүлэгч байгууллагад шууд хандан хохирогчоор бүртгэгдэж болохоор заасан. Гэтэл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хохирогчоор тогтоогдсон (шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн шийдвэрт үндэслэн) хүн хамаарагдахаар заасан байна. Энэ нь хохирогч хууль хяналтын байгууллагад хандаагүй тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх болон гэрчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын үйлчилгээг авах боломжгүйг харуулж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хохирогч” гэдэгт гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно гэж заасан. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээг авахын тулд зайлшгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчоор тогтоогдсон байхаар заасан нь хохирогч хуулийн байгууллагад хандаж түсламж, дэмжлэг авч чадахгүйд хүргэдэг байна” гэжээ.⁵

Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд хууль зорилгодоо хүрсэн түвшинг үнэлэхдээ “Монгол Улс дахь Хүн худалдалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа”-ны тайлангаас эш татан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хохирогч нь заавал хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл шалтгаалан үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандан хохирогчоор бүртгэгдэж, хамгаалалтын арга хэмжээ авах эрх нь шууд нээгдэх боломжгүй байна. Тус хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хохирогчоор тогтоогдсон (шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн шийдвэрт үндэслэн) хүн хамаарахаар заасан байна. Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар “хохирогч”-ийг тодорхойлсон тодорхойлолтод “эрүүгийн хэрэг” үүсгэж хохирогчоор тогтоосон байх шаардлага тавьсан нь хохирогчийн эрхийг бүрэн хамгаалах нөхцөлд хүрч чадахгүй байдал үүсгэж байна.” гэж дурджээ.⁶

Дүгнэвэл: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй этгээдүүдийг хуулийн зохицуулалтад хамааруулахаар нэмэлт, өөрчлөлт оруулсан нь нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу үүссэн бөгөөд цаашид уг хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, эсхүл бусад хуулиар дээрх бусад этгээдийн хамгаалалтын асуудлыг авч үзэх шаардлагыг үүсгэж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны практик хэрэгжилтийн байдал:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор Цагдаагийн байгууллагад Тахарын албаны зарим чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс байгуулагдаж, шүүхийн байрны хамгаалалт, шүүх хуралдааны дэг сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тус хэлтсийн батлагдсан орон тоо 324, үүнээс офицер 44, ахлагч 280 байгаагаас одоогийн байдлаар 308 алба хаагч (нийслэл 121, орон нутаг 187), үүнээс офицер 44 (нийслэл 20, орон нутаг 24), ахлагч 264 (нийслэл 101, орон нутаг 163) албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

⁵ Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа 2022 он. Холбоос: mongol-uls-dakh-khun-khudaldaalakh-gemt-khergiyn-suur-sudalгаа.pdf (iom.int). Сүүлд үзсэн огноо: 2024.10.10, 85 дахь тал.

⁶ “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлан. 2024. 13 дахь тал Хууль зүйн Үндэсний хүрээлэн.

Улсын хэмжээнд аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан болон давж заалдах, хяналтын шатны нийт 44 шүүхийн (нийслэл 12, орон нутаг 32) байр, шүүх хуралдааны 140 (нийслэл 67, орон нутаг 73) танхим, түр саатуулах 55 өрөө (нийслэл 5, орон нутаг 50)-нд үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 8.Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн өгсөн тоо мэдээгээр сүүлийн 4 жилийн хугацаанд шүүхийн байранд дараах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна:

№	Он	Шалган нэвтрүүлсэн иргэд	Эрүүгийн хэргийн шүүх хурал	Иргэний хэргийн шүүх хурал	Захиргааны хэргийн шүүх хурал	Хуяглан хүргэх ажиллагаа	Албадан ирүүлэх ажиллагаа
1	2021 он	185081	14956	31319	5494	5077	2054
2	2022 он	352688	22392	45438	7051	12208	3268
3	2023 он	394271	26325	49568	7845	10258	4650
4	2024/8 сар	310302	20796	37155	5240	9001	4905
Нийт дүн		1242342	84469	163480	25630	36544	14877

Шүүхийн аюулгүй байдлыг хангах, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх ажлын ачаалал жилээс жилд тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Нийслэлд шүүх хуралдааны 63 танхимд нийт 32, мөн Багануур, Налайх дүүргийн шүүх хуралдааны нийт 4 танхимд 9, орон нутгийн шүүх хуралдааны 73 танхимд 56 алба хаагч үүрэг гүйцэтгэдэг бөгөөд нийт шүүх хуралдааны танхимын 62.8 хувьд биечлэн дэг сахиулж байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2021 оны А/116/65 дугаар тушаалаар баталсан "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын 2.1 дэх хэсэгт зааснаар "Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газар"-ын харуул, хамгаалалтыг цагдаагийн байгууллага бүрэн хариуцаж ажиллах, 3.9.11-д зааснаар "Шүүх хуралдаан бүрт хамгаалалтын цагдаа үүрэг гүйцэтгэх"-ийн тулд хамгаалалтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх /нийслэлд 31, орон нутагт 21, нийт 52/ шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 44 шүүхийн байрнаас нийслэлд 8, орон нутагт 2 нийт 10 байранд 3 ээлжээр аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь хүн хүчний хүрэлцээгүйн улмаас Хөдөлмөрийн тухай хууль зөрчигдөхөд хүргэж байна. Албадан ирүүлэх: Нийслэлд 3 машин, 6 албан хаагч ажилладаг. Төсөв санхүү хүрэлцдэггүйгээс өөрсдөө бензинээ хийж хувийн машинаараа явах тохиолдол байдгийг албаны хүн дурдаж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны хэвийн нөхцөлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байсан Тахарын албыг татан буулгаж, чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан асуудалд шүүмжлэлтэй хандаж байсан хуульч судлаачдын дүгнэлтээс дурдвал:

Хууль зүйн ухааны доктор, дэд профессор О.Мөнхсайхан Тахарын албыг татан буулгах гэж байгаатай холбогдуулан тахарыг үлдээх 5 үндэслэлийг гарган тавьсан байна:

Тахарын алба гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үндсэн чиг үүрэгтэй, үүгээрээ шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхийг зорьдог. Тахарын алба байгуулагдахаас өмнө гэрч, хохирогч, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг бүрэн хамгаалах цогц тогтолцоо хангалттай бүрэлдээгүй байсан. Миний хувьд гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зэрэг тусгай чиг үүргийг цагдаагийн, эсхүл өөр бусад

байгууллагад хавсруулснаас бие даасан, алба, бүрэлдэхүүнд хариуцуулах нь илүү дээр гэж үздэг. Үүнийг таван үндэслэлээр хэлье.

- Нэгд, гэрч, хохирогч, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан алба байснаар мэргэшсэн албан хаагчидтай болж байна. Эдгээр чиг үүргийг дагнасан байгууллага хариуцах, мэргэшсэн албан хаагчдаар гүйцэтгүүлэх нь өөр байгууллагын харьяа болгож хавсарга ажил болгохоос хавьгүй үр дүнтэй.

- Хоёрт, эрх мэдэл хуваарилах зарчим бие даасан Тахарын алба байхыг дэмждэг. Ганцхан хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг биш ерөнхийдөө төрийн ялгаатай чиг үүргүүдийг өөр өөр субъектүүд дээр хэрэгжүүлэх юм бол тэр нь илүү үр дүнтэй гэсэн зарчим олон ардчилсан улсад хэрэгждэг. Цагдаагийн байгууллага бол нийгмийн аюулгүй байдал хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зэрэг үндсэн чиг үүрэгтэй. Гэтэл энэ нь дээр нэмээд Тахарын албаны чиг үүргийг нэмээд өгөхөөр тэнд эрх мэдлийн төвлөрөл бий болдог.

- Гуравт, цагдаагийн байгууллагад шилжүүлэх юм бол үр нөлөө буурна гэж ойлгож болно. Яагаад гэвэл цагдаагийн албан хаагчдын тоо Монголын хүн амын тоотой харьцуулахад тийм хүрэлцээтэй биш гэдэг. Төсөв байхгүй учраас орон тоогоо гүйцээж чадахгүй байгаа шүү дээ. Ийм байхад яаж цагдаагийн байгууллага гэрч хохирогчийг хамгаалах юм бэ. Ийм байхад өөр ажил нэмж өгвөл цалгардах магадлалтай.

- Дөрөвт, тахарын чиг үүрэг Цагдаагийн байгууллагад шилжсэнээр эргээд Цагдаагийн алба хаагчид ч юм уу, эрх мэдэлтэй хүмүүсийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдлээ гэхэд заримдаа ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бий. Жишээ нь, 2012 оны цагдаагийн хурандаа нарын хэрэг.

- Тавд, Тахарын алба байгуулагдаад 3 жил ч хүрээгүй байна. Шинэ хууль, шинэ тогтолцоо, шинэ бүтцийг бий болгочхоод ийм богино хугацааны дараа тогтолцоогоор нь өөрчлөх нь хууль дээдлэх ёсонд харш юм. Хуулийн институт тогтвортой үйлчилж байж үр дүн нь гардаг. Тахарын алба тогтвортой ажиллаж байж гэрч, хохирогч хамгаалагдаж, шүүхийн аюулгүй байдал хангагдана.

Тахарын чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлбэл энэ чиг үүргийн ач холбогдол бүдгэрч, дагалдан шинжтэй болох, улмаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж чадахгүй, гэрч, хохирогчийг хамгаалагдаж чадахгүй болох аюултай.”⁷

-Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт Шүүх, шүүгчийн аюулгүй байдлын хангах чиг үүрэг цагдаагийн байгууллагын бүтцэд шилжсэн талаар⁸:

“Урьд нь анхан шатны шүүхийн хэмжээнд цагдаагийн нэг албан хаагч ажиллаж, аюулгүй байдлыг сахиулдаг байсан.

Өнөөдрийн байдлаар өмнөх Тахарын албатай харьцуулахад шүүхийн барилгад цөөн тооны цагдаагийн албан хаагчид ажиллаж байгаа бөгөөд эдгээр албан хаагчдын гарт шүүхийн аюулгүй байдлыг хангах ажил ногдож байна. Гэхдээ Тахарын албатай харьцуулахад хамгаалалтын арга хэрэгсэл, арга механизм харьцангуй цөөн байгааг дурдах нь зүйтэй.

Тахарын албаны хувьд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр илүү зохион байгуулагдсан, түүнд тусгайлсан чиг үүргийг хариуцуулснаараа цагдаагийн байгууллагаас онцлогтой.

2016 онд Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүхийн хараат бус, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулжээ. Уг нэгжийн үндсэн чиг үүрэг нь шүүхийн хэмжээнд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах ажлыг зохион байгуулах, мөн түүнчлэн шүүгчид нөлөөлөхөөр оролдсон нөлөөллийн мэдүүлгийг хянан шийдвэрлүүлэх чиг үүргийг хүлээж байна.

Шүүгчийн орон байрны халдашгүй байдлыг шүүгч нар зөвхөн өөрсдөө хариуцаж байгаа бөгөөд урьдчилсан байдлаар төрөөс ямар нэг анхааруулга, санамж, зөвлөгөө өгөөгүй байна.

2017 оны 1-р сард нэгэн шүүх хуралдааны явцад шүүгдэгч өөрийнхөө хоолойг хэрчсэн /хумсаараа хоолойгоо зүссэн байх магадлалтай/ тохиолдол гарсан. Шүүгдэгч эмнэлгийн тусламж

⁷ News.mn, “Тахарыг үлдээх таван үндэслэл”, Холбоос: <https://news.mn/r/742689/>, Сүүлд үзсэн огноо: 2024.10.13.

⁸ <https://legaldata.mn/b/1243>

авсан. Гэвч шүүхийн захиргааны байгууллагын зүгээс аюулгүй байдал алдагдсан энэ нөхцөл байдал бол Тахарын албыг татан буулгасантай холбоотой бөгөөд учир нь цагдаагийн байгууллагад шилжсэн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг өмнөхөөс дордож, цагдаагийн хүн хүч, хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас болж ийм нөхцөл үүссэн гэж үздэг. /1 шүүхийн байранд дор хаяж 4-5 цагдаагийн албан хаагч байх шаардлагатай бол зарим шүүхэд хамгаалалт огт байхгүй байх тохиолдол байдаг./

Тахарын албыг татан буулгасан нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ухралт болсон. Төрийн албан дахь авилга, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг олон нийтийн хандлага, хөдөлгөөн өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан шүүх, шүүгчийн аюулгүй байдал, бие махбодид халдах гэсэн оролдлогод хугацаа алдалгүй арга хэмжээ авах байдал хангалтгүй байна."

Судлаачдын зүгээс шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхийн тулд гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үндсэн чиг үүрэг бүхий Тахарын албыг татан буулгаж, чиг үүргийг хүн хүч, хүний нөөцийн хязгаарлагдмал чадамжтай цагдаагийн байгууллагад шилжүүлсэн нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тал дээр өмнөхөөс дордсон. Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийг цагдаагийн, эсхүл өөр бусад байгууллагад хавсруулснаас илүү үр нөлөөтэй шинэ бүтэц бий болгож, бие даасан, алба, бүрэлдэхүүнд хариуцуулах нь зүйтэй гэж үзсэн.

Дүгнэвэл:Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хэрэгжүүлж байгаа өнөөгийн нөхцөл байдал, судлаачдын хийсэн дүгнэлтээс харвал шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа хангалтгүй, хамгаалалтад ажиллах хүн хүч хүрэлцээгүй, шүүх хуралдааны танхимын 30 гаруй хувь нь огт хамгаалалтгүй байгаа нь шүүх, шүүгчийн аюулгүй байдал эрсдэлтэй нөхцөл байдалд байна гэж дүгнэхээр байна.

Мөн хүн хүч дутмагаас албан хаагчид ээлжгүй ажиллах, Хөдөлмөрийн тухай хууль зөрчигдөх тохиолдол гардаг. "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын хэрэгжилтийг хангах, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор албан хаагчдын орон тоог нэмэх шаардлагатай байна.

Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэгт хамаарах шүүгдэгч, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг авч үзвэл, нийт 42 хорих анги, байгууллагын хуяглан хүргэх ажиллагаанд холбогдох стандартын дагуу тоногдсон 50 тээврийн хэрэгслээр хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 973 хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс 3742 алба хаагчийн хүчээр 1162 удаагийн тээвэрлэлтээр 4118 хоригдогсдыг 145.312 км зам туулсан хуяглан хүргэх ажиллагаанд байршил тогтоогч төхөөрөмж ашиглан хяналт тавьж ажилласан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэсэн алба хаагчийн тоо 187-оор бага буюу 4.7 хувиар, хоригдлын тоо 1057-оор бага буюу 20.4 хувиар, туулсан зам 14773 км-ээр буюу 9.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хуяглан хүргэлтийн хэлтэс хорих 461 дүгээр анги дээр байрладаг, 7 машинтай үүрэг гүйцэтгэдэг. Тээвэрлэх хоригдлын тооноос хамааран хянагчийн тоог тогтоодог, 8 хүртэл хоигдлыг 1 офицер, 1 албан хаагч гэх мэт хуяглан харгалздаг. Тус байгууллагын зүгээс хоригдлыг хуяглан хүргэх явцад тээврийн хэрэгсэлд эвдрэл гэмтэл гарах тохиолдолд тухайн этгээд болон албан хаагчдын амь нас, эрүүл мэндэд аюул учрах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах нөхцөл байдал үүсэж болзошгүй байдгийг онцолж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, газар, хэлтсүүд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 207 дугаар зүйл, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, "Хорих ангийн харуул хамгаалалтын журам", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны н/07 дугаар тушаалаар батлагдсан "Хуяглан хүргэх ажлын заавар"-ын дагуу хоригдлыг хорих анги хооронд болон эмнэлэгт хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулж байна.

Мөн эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад тусгай сан ашиглах боломжгүй, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах АСАП санг ашигладаг, мэдээллийн тусгай сан ашиглах зөвшөөрөлгүй гэсэн бэрхшээлийг дурдаж байна.

Эдгээр нь албан хаагчдыг тусгайлсан сургалтаар сургах, албан хаагчид тодорхой хүрээ хязгаарт тусгай сан ашиглах эрхтэй байх, техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, байнгын бэлэн байдалд байлгах, нөөц тээврийн хэрэгсэлтэй байх гэх мэт шаардлагыг үүсгэж байна.

1.1.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллага, эрх зүйн орчин, үйл ажиллагааны хэрэгжилт

Эрх зүйн орчин. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Тагнуулын байгууллагын тухай хуульд зааснаар хэрэг, маргаанд холбогдсон этгээдээс тайлбар, мэдүүлэг авах эрх бүхий этгээд нь шүүгч, прокурор, цагдаа, авилгатай тэмцэх газрын болон тагнуулын ерөнхий газрын мөрдөгч /цаашид "тусгай субъект" гэх/ байна.

2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26.2, 27.2 дахь хэсэгт цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах алба нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар зааж, Прокурорын байгууллагын тухай /2002 он/ хуулиар Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албаны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн:

Прокурорын байгууллагын тухай хууль /2002 он/

10 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба

10.1.Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба /цаашид "Мөрдөн байцаах алба" гэх/ нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар харьяалуулсан хэрэгт мөрдөн байцаалт явуулна.

10.2.Мөрдөн байцаах албанд албаны дарга, дэд дарга, ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаагч ажиллана.

10.3.Улсын ерөнхий прокурор нь Мөрдөн байцаах албаны бүтэц, дүрмийг баталж, албаны дарга, дэд даргыг томилж, чөлөөлнө.

10.4.Мөрдөн байцаах алба нь захиргааны удирдлага, аж ахуй, санхүү, боловсон хүчний хувьд бие даасан байна."

2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгай субьектийн үйлдсэн эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах зохицуулалтыг дараах байдлаар тусгасан байна:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/:

2.3 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяалал

4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг шуурхай, бүрэн гүйцэд явуулахын тулд гэмт хэрэг илэрсэн болон оролцогч, гэрч, хохирогчийн олонх байгаа газарт, эсхүл дагнасан чиг үүрэгтэй алба, нэгжид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтоож болно."

4.1 дүгээр зүйл.Прокурорын бүрэн эрх

2.Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа дараахь эрхтэй:

2.3.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяалал тогтоох;

6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага

1.Тагнуулын байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:...

2.Авлигатай тэмцэх байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:...

3.Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

4.Тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно."

Дүгнэвэл:Хуулиар тогтоосон харьяаллаар тагнуул, авилгатай тэмцэх байгууллагын харьяаллын хэргээс бусад хэрэгт цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар зохицуулсан бөгөөд тусгай субъект болох тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг Улсын ерөнхий прокурор тогтоохоор заасан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тагнуул, цагдаа, авилгатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтоохоор заасны дагуу Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/73 дугаар тушаалаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг шинэчлэн тогтоож мөрдүүлж байна.

Дээрх тушаалаар баталсан Тусгай субъектэд хамааралтай гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд хяналт тавих харьяалал:

Хүснэгт 9.

Мөрдөн шалгах байгууллага	Харьяалан шалгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг	
Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба	3.1.	Авилгатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн энэ журмын 1.1, 1.3, 2.1-2.9 -с бусад гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг
	3.2.	Тагнуулын байгууллагын албан хаагчийн үйлдсэн энэ журмын 1.1-1.3, 2.1-2.5, 2.9 -д зааснаас бусад гэмт хэрэг
	3.3	Шүүгч, прокурорын үйлдсэн энэ журмын 1.1-1.3, 2.1-2.4, 2.9-д зааснаас бусад гэмт хэрэг
	3.5	Цагдаагийн байгууллагын албан хаагчийн үйлдсэн энэ журмын 1.1-1.5, 2.1-2.5, 2.9-д зааснаас бусад гэмт хэрэг

Дүгнэвэл: Авилгатай тэмцэх газар нь хуулиар харьяалуулснаас гадна авилгын хэргийг шалгах үед илэрсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6.Мөнгө угаах гэмт хэрэг болон цагдаагийн байгууллагын албан хаагчийн үйлдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9.хууль бусаар баривчлах, саатуулах, 13.12.хууль бусаар мөшгих, 21.9.мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэрэг, цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагчийн үйлдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12.Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгаж байна.

Тагнуулын ерөнхий газар нь хуулиар харьяалуулснаас гадна өөрсдөө илрүүлсэн хуульд заасан зарим гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс нь Улсын ерөнхий прокурорын харьяалал тогтоох журмын дагуу шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагч, авлигатай тэмцэх байгууллага болон тагнуулын байгууллагын албан хаагчийн үйлдсэн АТГ болон ТЕГ-т харьяалуулснаас бусад гэмт хэргийн гомдол, мэдээлэл, гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Практик хэрэгжилт.Улсын бага хурлын “Мөрдөн байцаах албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тухай” 1992 оны 36 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газрын 101 дүгээр тогтоолоор Улсын аюулгүй байдлыг хамгаалах ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Прокурорын байгууллагын мөрдөн байцаах албаны орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлж, Улсын мөрдөн байцаах газрыг байгуулж, бүтцэд нь цэрэг, цагдаагийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийг шалгах үүрэг бүхий “Цэргийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс”-ийг шинээр байгуулж, тус хэлтэс нь 1992-2002 он хүртэл цэрэг, цагдаагийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийг шалгаж байсан.

2002 онд Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг шинээр байгуулж, тус алба нь тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэргийг 2002-2014 он хүртэл шалгаж байсан.

Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгосгоор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба татан буугдаж, тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн албан тушаал, авилгын гэмт хэргийг мөрдөн шалгах харьяалал Авилгатай тэмцэх газарт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг цагдаа болон авилгатай тэмцэх газар үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ хэрэгжүүлэх болсон.

Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын бүтцэд "Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс"-ийг 2014 онд байгуулсан.

2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Цагдаагийн ерөнхий газрын даргын А/214 дүгээр тушаалаар тус хэлтэст

Тус хэлтэс дарга, тасгийн дарга, чиглэлийн ахлах мөрдөгч болон 10 ахлах мөрдөгч, 1 цагдаа, нийт 14 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй, 2 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий 5 орон тоотой Эрүүгийн цагдаагийн тасагтай.

Тус хэлтэс 2015-2024 онд нийт 1096 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, нийт 1031 хэргийг шалган шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 10.Хэрэгт шалгагдсан субъектээр авч үзвэл⁹:

цагдаа, дотоодын цэргийн албан хаагч	1052
шүүгч	14
прокурор	12
авилгатай тэмцэх газрын албан хаагч	12
тагнуулын байгууллагын албан хаагч	6

Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэст ирсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн 95 орчим хувь нь цагдаагийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэг, бусад 5 орчим хувь нь бусад субъекттэй холбогдох хэрэг байна.

2019-2024 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 817 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт 11.Шүүхэд шилжүүлсэн хэргийг зүйл ангиар нь ялгавал:

Зүйлчлэл	Хэргийн тоо, хувь
ЭХ-ийн 11.1-11.7 /Хүний биед хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулах, гэр бүлийн хүчирхийлэл/	130 хэрэг буюу нийт хэргийн 46,2 хувь
ЭХ-ийн 12.1 /Хүчиндэх/	23 буюу 8,1 хувь
ЭХ-ийн 17.3 /Залилах/	22 буюу 7,8 хувь
ЭХ-ийн 27.10 /Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих/	61 буюу 21,7 хувь
Бусад	45 буюу 16,2 хувь

⁹ "Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" хэлэлцүүлэг, ЦЕГ-ын МБА-ны дарга, П.Очбадрах, "Хүний эрхийн зөрчил, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ" илтгэл 14 дэх тал, 2024.10.30.

Мөрдөн шалгаж шүүхэд шилжүүлсэн нийт хэргийн дийлэнхийг хүний биед хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулах, гэр бүлийн хүчирхийлэлийн гэмт хэрэг эзэлж байна.

Цагдаагийн байгууллага 2014-2017 онд цагдаагийн албан хаагч холбогдсон эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 56 гомдол, мэдээллийг шалгаснаас 5-д нь эрүүгийн хэрэг үүсгэжээ.¹⁰

2020-2024 онд Эрүү шүүлт тулгах 15 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн бөгөөд зүйлчлэлээр нь авч үзвэл, эрүү шүүлт тулгах гэмт хэрэг 7, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулж эрүү шүүлт тулгасан 4, хүндэвтэр 1, хүнд гэмтэл санаатай учруулж эрүү шүүлт тулгасан 2, нотлох баримт хуурамчаар үйлдэж, эрүү шүүлт тулгасан 1 хэрэг байна.¹¹

Авилгатай тэмцэх газарт 2021 онд 103, 2022 онд 145 төрийн тусгай албан хаагч гэмт хэрэгт холбогдон шалгагдсан¹² бол 2023 онд төрийн тусгай албан хаагчид холбогдох 729 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, үүнээс 206 албан хаагчид холбогдох эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.¹³

2020-2023 онд Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн давхардсан тоогоор 22 мөрдөгч 47 удаа орон нутагт 234 хоног ажилласан байна. Орон нутгаас ирсэн гомдол, эрүүгийн хэрэг нэг бүрийг шалгах ажиллагааг томилолтоор байнга явахад тээврийн хэрэгсэл олгогддоггүй, томилолтын зардал ордоггүй зэрэг хүндрэл бэрхшээл байна.

Дүгнэвэл:Цагдаагийн албан хаагч хэрэгт өртөх магадлал илүү, хэргийн хувьд гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг гэмт хэрэг болон хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна. Цагдаагийн байгууллагын ажилтан хэрэг илрүүлэх буюу өөрийн албан ажлын зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд сүрдүүлэх, дарамтлах хэлбэрээр гэрч, хохирогчид нөлөөлсөн, авилгатай тэмцэх газрын албан хаагч эрүү шүүлт тулгасан гэсэн үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгт холбогдож шалгагдаж байсан байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулах тохиолдолд түүний бүтэц, хүний нөөц, харьяалан шалгах гэмт хэргийн зүйлчлэлийг зохистой тогтооход дээрх тоо баримт ач холбогдолтой гэж үзэж байна.

1.2. ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨЖ БАЙГАА ЭТГЭЭД

Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зохих хэмжээнд гүйцэтгэж байгаа боловч тэдгээр үйл ажиллагаа бодит байдал дээр хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж, дараах бүлгийн эрх ашигт нөлөөлж байна:

Хүснэгт 12. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг

№	Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Хамгаалуулагч /гэрч, хохирогч, шүүгч, шүүх г.м/	Хамгаалалтыг мэргэшсэн, хангалттай хүний нөөцтэй, бие даасан алба хэрэгжүүлэхгүй байгаа нь тухайн албаны мэргэших байдалд сөргөөр нөлөөлж, хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулах боломжтой. Жишээ нь:Сэлэнгэ аймагт болсон цагдаагийн албан хаагч хохирогчид халдсан хэрэг, цагдаагийн

¹⁰ “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” хэлэлцүүлэг, МБА-ны дарга, П.Очбадрах, “Хүний эрхийн зөрчил, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ” илтгэл 14 дэх тал, 2024.10.30.

¹¹ Мөн тэнд, Улсын Ерөнхий Прокурорын газар, Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинж, хэрэглээ илтгэл, 7,8-р тал.

¹² <https://cdn.greensoft.mn/uploads/users/3172/files/ATG-report-2023.pdf>, [ATG-report-2023.pdf](https://cdn.greensoft.mn/uploads/users/3172/files/ATG-report-2023.pdf)

¹³ https://cdn.greensoft.mn/uploads/users/3172/files/ATG%20report_2024%20ful%20revised.pdf, “Авилгатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2023” тайлан.

		хурандаа нарт холбогдох хэргийн шүүх хурлын дараа шүүгч нар халдсан өртсөн гэх мэт.
2	Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	Өөрийн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх хүн хүч, төсөв санхүүгийн хязгаарлагдмал нөөцтэй цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, тусгай субьектийг мөрдөн шалгах чиг үүргийг давхар хариуцуулсан нь эдгээр байгууллагад нэмэлт ачаалал үүсгэж, төсөв санхүү хүрэлцэхгүй байх, өөр чиг үүрэгтэй газар хэлтсийн албан хаагчдыг дайчлах, албан хаагчдын ачаалал нэмэгдсэний улмаас хөдөлмөрлөх эрхийн харилцаанд зөрчил үүсгэх зэрэг сөрөг үр дагавартай байна.
3	Төрийн бус байгууллага	Гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан байгууллагагүйгээс төрийн бус байгууллагын хамгаалах байранд гэрч, хохирогчийг хамгаалах, тэдгээр нь өөрсдийн зорилтот бүлгийн иргэдийг авах сонирхолтой байдгаас зөрчил үүсэх, төрийн бус байгууллагын ачаалал нэмэгдэх үр дагаврыг үүсгэдэг.
4	Засгийн газар/Төрийн алба	МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүйн улмаас Оролцогч улсын хувьд байнгын шүүмжлэл, анхааруулгад өртдөг. Бие даасан байгууллагагүй учраас дээрх үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, байгууллагыг хүн хүч, техник, тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг бэхжүүлэхэд ахиц гарахгүй байна. Төрийн үйлчилгээ мэргэшсэн, шуурхай байх зарчим алдагдах сөрөг үр дагавартай.
5	Эмнэлгийн байгууллага, бусад хамтрагч байгууллага	Хамгаалалтад оролцогч талуудын хооронд зарим асуудлаар тодорхойгүй байдал үүсгэж, ажлын ачаалал нэмж, үйл ажиллагаанд дарамт болдог. Гэрч, хохирогчид тусламж үзүүлэх явцад нууц алдагдах, эмнэлгийн өрөө, тасалгааны хүрэлцээгүй байдлаас шалтгаалан ачаалал, дарамт нэмдэг.
6	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч	Гэрч, хохирогчоос гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид хамгаалалтгүй үлдэж байгаа нь тэдний амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулдаг.
7	Тусгай субьект	Мөрдөн шалгах ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх боломжгүй байгаа нь мөрдөгч нөлөөнд автах, хүний эрх зөрчигдөх, шүүгдэгч ял завших боломжийг олгож байна.
8	Иргэд	Иргэдийн төрд, төрийн албан хаагчид, шүүхэд итгэх итгэл алдагдах сөрөг нөлөөтэй.

Дээрх нөлөөллийн улмаас иргэдийн эрх ашиг зөрчигдөх, шүүгдэгч ял завших, төр, иргэн, төрийн бус байгууллагад давхар зардал чирэгдэл үүсгэх, үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал алдагдах, хяналт хязгаарлагдах, иргэдийн төрийн албан хаагчид, шүүхэд итгэх итгэл алдагдах, хүнд суртал, чирэгдэл нэмэгдэх сөрөг үр нөлөөтэй байна.

Түүнчлэн хуульд тагнуулын болон цагдаагийн байгууллагын ажилтан гэж тодорхойлсноор дээрх албаны үйлчилгээний ажилтнууд зэрэг бүх ажилтныг хамруулж байгаа нь тусгай субьектийг мөрдөн шалгах байгууллагад ачаалал үүсгэдэг байна.

1.3. Асуудал үүсгэж байгаа учир шалтгаан, нөхцөл

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Монгол Улсын хэмжээнд гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой бэрхшээл, хүндрэлийг үүсгэж байгаа шалтгааныг багцлавал дараах байдалтай байна:

-Гэрч, хохирогчийг хамгаалах хараат бус бие даасан бүтцийг бүрдүүлээгүй, төрийн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх хүн хүч, төсөв санхүүгийн хязгаарлагдмал нөөц бүхий цагдаагийн байгууллагад дээрх үүргийг давхар хариуцуулсан нь уг албыг бэхжих боломжгүй болгосон.

-Хамгаалалтыг аюул, эрсдэл багатай зохион байгуулах туршлага дутмаг, хамгаалалтын үед хамгаалуулагч болон албан хаагчид учирч болох гадаад, дотоод эрсдэлийг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, магадлалыг тодорхойлох, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ авах чиг үүрэг хангалттай бэхжээгүй нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хангалтгүй хэрэгжих, гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах, шүүх тасалгаанд аюулгүй байдал алдагдах эрсдэл үүсгэж байна.

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх оролцогчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдээгүй. Хамгаалалтад авч байгаа субъектийн хүрээ цөөн, зөвхөн гэрч, хохирогч, шүүгчийг хамгаалалтад авснаар бусад оролцогч хамгаалалтгүй үлдэж байгаа нь тэдний амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулж байна.

-Хууль сахиулах байгууллагын албан хаагчид гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд харилцан бие биенээ мөрдөн шалгаж байгаа нь нөлөөнд автах, ял завших боломжийг олгох эрсдэлтэй.

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал алдагдаж, шударга ёс, хяналт хязгаарлагдах, иргэдийн эрх ашиг зөрчигдөх, шүүгдэгч ял завших, иргэдийн төрийн албан хаагчид, шүүхэд итгэх итгэл алдагдах зэрэг сөрөг үр дагавартай байна.

Дүгнэвэл:Манай улсын хувьд гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааны хараат бус байх олон улсын хүлээн зөвшөөрсөн зарчим алдагдсан.

Дээрх чиг үүргүүдийг төрийн тусгайлсан чиг үүрэгтэй өөр байгууллагад давхар хариуцуулсан нь үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж, төрийн үйлчилгээ шуурхай, мэргэшсэн, үр ашигтай байх зарчмыг алдагдуулсан.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Эрх зүйн зохицуулалтын хувьд гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах үндсийг тавьсан боловч практикт хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж байна.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна:

Зорилго:Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хараат бус бие даасан тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг бэхжүүлнэ. Үүнд:

1/Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах бие даасан алба байгуулж үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх;

2/Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хараат бус албыг байгуулж, хохирогчийн эрхийг хамгаалах.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын Дөрөв дэх хэсэгт заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу "Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хараат бус бие даасан албыг байгуулж,

үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, хохирогчийн эрхийг хамгаалах, хүний эрхийг хангах чиглэлээр хүлээсэн үүргээ биелүүлэх.” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харгалзан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 13. Зорилгод хүрэх байдал

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй. тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Асуудлын агуулга, мөн чанартай зөрчилдөх тул ухуулга, сурталчилгаа хийх боломжгүй. Зорилгод хүрэх боломжгүй.	Зардал гарна, үр дүнгүй.	Үр дүн сөрөг
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Асуудлын агуулга, мөн чанарт төдийлөн нөлөөлөх хүчин зүйл болж чадахгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Үйл ажиллагаанд зарцуулагдах төсөв, хөрөнгийг нэмэгдүүлж, чадавхижуулах чиглэлд тодорхой мөнгөн дэмжлэг үзүүлснээр үйл ажиллагааг дэмжих боловч зорилгыг бүрэн хангаж чадахгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Хүссэн үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Зохицуулах суурь харилцааны онцлогоос шалтгаалан дан ганц захиргааны шийдвэрээр зохицуулах боломжгүй. Зорилгодоо хүрэх боломжгүй.	Зардал гарна. Асуудлыг шийдвэрлэж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хүний эрхийг хангах, хамгаалах хараат бус, бие даасан тогтолцоо бүрдэж, үйл ажиллагаа нь бэхжинэ. Зорилго бүрэн хангагдана.	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй эерэг нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй

Дүгнэвэл:Өргөн хүрээнд сонгосон зохицуулалтын хувилбаруудыг Аргачлалын 5.7 дахь хэсэгт заасан шалгуурын дагуу ерөнхий байдлаар тандан судлах явцад 1-5 дахь хувилбар “асуудлыг шийдвэрлэж зорилгодоо хүрэх боломжгүй буюу үр дүнгүй” байна.

Иймд үр дүнгүй болох нь тогтоогдсон хувилбаруудаас татгалзаж, үр дүнтэй буюу цаашид үр нөлөөг нь тооцох шаардлагатай “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” 6 дахь хувилбарыг сонгож байна.

Мөн асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал нь Аргачлалын 5.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгох дараах нөхцөлийг мөн хангасан байна:

1/тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол;

2/Монгол Улсын олон улсын гэрээгээр Монгол Улс тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах талаар тусгайлан үүрэг хүлээсэн;

3/"Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол.

Иймд асуудлыг зөвхөн хууль тогтоомжийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх дүгнэлт гарч байна.

Энэ дүгнэлтийн дагуу дээрх асуудлыг зохицуулах хуулийн төслийн бүтэц, агуулга, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийг ерөнхий байдлаар тодорхойлж.

1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах замаар бие даасан алба байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, үүнтэй холбогдуулан хуулийн бусад зохицуулалтыг авч үзэж, шаардлагатай бол өөрчлөн найруулах, тухайлбал: хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг өргөжүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг хамруулах

2.Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах бие даасан албыг байгуулах тухай зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох хуульд тусгах.

Хуулийн төслийн дэлгэрэнгүй томъёоллыг хавсралт 3, 4-өөс үзнэ үү.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" зохицуулалтын хувилбарын үр нөлөөг мөн аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ийн хүснэгт 1,2,3,4-өөс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүний амьд явах, итгэл үнэмшилтэй байх, эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

Харин учирч болох эрсдэлийн түвшин, гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан Шаардлагатай тохиолдолд амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хүний амьд явах, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхээс бусад эрхэд хязгаарлалт тогтоож болно.

Иймд хүний эрхэд үзүүлэх нөлөөг үнэлэх категорийн зарим асуултад тухайлбал, "хүний эрхийн хязгаарлалт тавих эсэх" асуултанд "тийм" гэсэн хариулт сонгосон нь хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хязгаарлалт тогтоох зайлшгүй нөхцөлд хэрэгжих тул хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлнэ гэж дүгнэхгүй.

Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах бие даасан бүтцийг бий болгосноор төрийн чиг үүргийн хүрээ, хяналтыг өргөжүүлж, шүүгдэгч, яллагдагч, ялтныг

эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрсдлээс хамгаалах, төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх зэргээр хүний эрхийг хамгаалах, хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгоно.

4.2.Эдийн засагт үзүүлэх нөлөө

Сонгосон хувилбарыг хэрэгжүүлснээр төрийн албанд захиргааны шинэ чиг үүрэг бий болгож, шинэ байгууллага байгуулах бөгөөд бусад /ЦЕГ, АТГ, ТЕГ, ШШГЕГ/ төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдана.

Тодорхой бүс нутагт нэгж /салбар/ байгуулагдаж ажлын байрыг шинээр бий болгох, нөгөө талд ажлын байр багасгах нөлөө үзүүлнэ. Мөн шинээр үйл ажиллагааны болон захиргааны зардал үүснэ. Гэвч энэ нь өмнө нь тухайн чиг үүргийг хэрэгжүүлж байсан байгууллагуудын үйл ажиллагааны болон захиргааны зардлыг бууруулж, ачааллыг багасгана.

Эдийн засгийн хувьд одоо хэрэгжиж байгаа бүтэц, хүний нөөцийг холбогдох төсвийн хамт шилжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой тул төрийн байгууллагын захиргааны зардал, хүний нөөцийг хэмнэх чиглэлд улсын төсөвт тодорхой хэмнэлтийг бий болгох боловч үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд зайлшгүй тодорхой зардал гарна. Үр дүнд нь хэрэгжүүлэгч байгууллагын хувьд үйл явц, зардлын хуваарилалт зорилгодоо чиглэсэн, илүү тодорхой, үр дүнтэй, ил тод болно.

4.3.Нийгэмд үзүүлэх нөлөө

Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлнө. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээлд шинээр ажлын байр бий болох, нөгөө талд шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгоно.

Зохицуулалт нь эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд, гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх зэрэг нийгмийн тодорхой бүлэгт нөлөө үзүүлэхгүй.

Харин төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх замаар засаглалын харилцаанд оролцогчдод зохих хэмжээгээр нөлөөлнө. Гэвч иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөхгүй.

Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдал, гэмт хэргийн илрүүлэлт, гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Сонгосон зохицуулалтын хувилбар нь Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа тул олон улсын харилцаа талаас сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.4.Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Сонгосон хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус нөлөө үзүүлэхгүй. Агаар, зам тээвэр, түлш, эрчим хүч, ан амьтан, ургамал, усны нөөц, хөрсний бохирдол, газрын ашиглалт, байгалийн баялагт нөлөөлөхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжийн үзэл санаа, зарчим, утга агуулгад нийцэж байгаа байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна”, Арван зургадугаар зүйлийн 13-т “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 2-т “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь ...хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.” гэж заасан.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийн дагуу Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг баталсан бөгөөд гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой хэрэгжүүлэх арга

хэмжээний 26-д "108.126. Эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг айлган сүрдүүлэх, дарамтлах, эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх, гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий бие даасан, хөндлөнгийн хараат бус үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ тусгагдсан.

Мөн Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 3 дугаар илтгэлийг хэлэлцүүлсний мөрөөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтийн дунд хугацааны явцын тайлан /2024/-гийн 116.51, 116.53, 116.54-т эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэргийг мөрдөн шалгах хараат бус, бие даасан байгууллага байгуулахыг зөвлөсөн бөгөөд НҮБ-ын Хүний эрхийн механизмын Зөвлөмжийн нэгтгэл /2023 он/ -ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны зөвлөмжийн 508-д "Оролцогч улс нь эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал гаргагчдыг ял завшихаас сэргийлэх үүднээс үр дүнтэй, хараат бус мөрдөн шалгах механизм байгуулах хэрэгтэй байна.", мөн Хүний эрхийн зөвлөлийн эрүүдэн шүүхийн Тусгай илтгэгч "эрүүдэн шүүх асуудал цагдаагийн газар, цагдан хорих төвүүдэд голчлон тохиолдохоос гадна энэ талаар ирсэн гомдлыг хүлээн авч, мөрдөн шалгах үр дүнтэй механизмгүйгээс болж энэ төрлийн гэмт хэрэг ял завшиж байна" (1, 2, 4, 12,16 дугаар зүйл)" гэж тус тус дүгнэжээ.

Мөн Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хорооны зөвлөмж 611.26-д "2014 онд Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх тусгай мөрдөн байцаах албыг татан буулгаж, чиг үүргийг Авилгатай тэмцэх газарт шилжүүлсэнд ХОРОО санаа зовниж байна. Тухайн төрийн албан хаагчийн эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан гэх үйлдлийг өөр нэг төрийн албан хаагчаар мөрдүүлж байгаа одоогийн энэ бүтэц нь ижил түвшинд мөрдөн шалгах бие даасан байдал алдагдахад хүргэж, цаашлаад үр дүнтэй хяналтыг бий болгохгүй" гэжээ. 614. 29-т "Төрийн алба хаагчид, түүний дотор цагдаагийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг Улсын ерөнхий прокурорын газрын дотоод бүтцэд дахин бий болгохыг Оролцогч улсад зөвлөж байна. Бүх мөрдөн шалгалтыг хараат бусаар, алагчлалгүй, үр дүнтэй, мөрдөгч болон гэмт хэрэгтнүүдийн хооронд ямар нэг холбоо үүсэхээс сэргийлсэн байдлаар явуулахыг Оролцогч улс нягтлан шалгах ёстой." гэж тус тус зөвлөжээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасныг үндэслэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.4-т дараахь тохиолдолд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно:

5.4.1.тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол;

5.4.2.тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагатай болохыг Үндсэн хуульд онцлон заасан бол; гэж заасан.

"Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17/ Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ...-ийг хуулиар тогтоон хамгаална", 18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно. гэж заасан.

Иймд хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахын тулд түүний зарим эрхийг хязгаарлах шаардлага гарах тул уг асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Зохицуулалтын хувилбарыг зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч байгаа сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх шалгуураар дахин нягтлан үзээд хуулийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон бөгөөд харьцуулах хувилбар байхгүй болно.

Хууль батлан хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаад байгаа хүндрэлийг арилгах, сөрөг үр дагаврыг бууруулах, хяналт, үр дүнг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж олгож байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

6.1.Олон улсын эрх зүйн хэм хэмжээ:

6.1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах алба байгуулах чиглэлээр:

Гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын стандарт болох 1966 оны **"Иргэний болон улс төрийн эрхийн пакт"**. Гэрч, хохирогч болон шүүх ажиллагааны бусад оролцогчдыг хамгаалах олон улсын стандартыг өндөр түвшинд тодорхойлсон энэ Пактын 2 дугаар зүйлийн 3-т заасны дагуу гишүүн улс бүр Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах; эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах үүрэгтэй." гэж заажээ.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр гэрч, хохирогчийг хамгаалахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг авах үүргийг гишүүн улс хүлээсэн байдаг. Тухайлбал¹⁴:

- **Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм**-ийн 68 дугаар зүйлийн 1-д "шүүх хохирогч болон гэрчүүдийн хувийн амьдралын аюулгүй байдал, бие махбодийн болон сэтгэл санааны сайн сайхан байдал, нэр төр болон хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээг авна.";
- **Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц**-ийн 25 дугаар зүйлд "Оролцогч улс бүр гэмт хэргийн хохирогчийг тухайлбал, өшөө авах буюу сүрдүүлэх заналхийллээс хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх хүрээнд зохих арга хэмжээнүүдийг авна";
- **Авлигын эсрэг НҮБ-ын конвенц**¹⁵-ийн 32 дугаар зүйлийн 1-д "Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авна" гэж заажээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 1989/57 дугаар тогтоолоор баталсан дээрх тунхаглалыг хэрэгжүүлэх Зөвлөмжид гэмт хэрэгтэй холбоотой аливаа эрүүгийн байцаан шийтгэх болон бусад ажиллагааны явцад болон дараа нь гүтгэлэг, айлган сүрдүүлгээс хохирогчийг хамгаалах арга хэмжээг боловсруулахыг зөвлөсөн.

НҮБ-ын Конгрессоос 2000 онд баталсан **"Гэмт хэрэг ба шүүх эрх мэдэл: ХХI зууны хариу"** Венийн тунхаглалын 27-д "улс гүрнүүдэд өөрийн практикийг дүгнэн үзэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх, гэрчийг хамгаалах Төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх"-ийг чухалчилсан байна.¹⁶

¹⁴ Хохирогчийн эрхийг хамгаалах төв. "Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал" судалгааны тайлан 2010 он, 32-37 дахь тал

¹⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2005 он, №43, 855 дахь тал

¹⁶ Хохирогчийн эрхийг хамгаалах төв. "Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал" судалгааны тайлан 2010 он, 40 дахь тал,"

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дугаар тогтоолоор баталсан Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалын дагуу хохирогчийг өргөн утгаар авч үзсэн бөгөөд гэмт этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, саатуулагдсан, баривчлагдсан, шүүх хянан шийдвэрлэсэн эсэхээс, түүнчлэн хохирогч болон гэмт хэрэгтний хоорондын гэр бүлийн харилцаа, хамаатан, садангаас үл шалтгаалан хохирсон этгээд, түүний гэр бүлийн гишүүд, халамжид байгаа хүмүүс нь хохирогч байхаар заасан. Мөн ЭБША-нд оролцогч аливаа этгээд хэрэв түүнд хууль бусаар нөлөөлж байвал хохирогч гэж үзнэ. Тунхаглалын "хохирогч" нэр томъёонд гэрч мөн адил хамаарна.

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (UNODC-НҮГХМБТГ) болон Бүс нутаг дамнасан Гэмт хэрэг, Шударга ёсны Судалгааны Институт (UNICRI-БГШСИ)-ийн гаргасан Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг хэрэгжүүлэх мэргэжил арга зүйн удирдамж /2009/-ийн 32 дугаар зүйлийн 2-1-д "Оролцогч улс шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөхгүй ч гэмт хэрэгт буруутгах бичиг баримт зэрэг чухал нотолгоог өгөх буюу тодорхойлох этгээдийг хамруулах байдлаар өргөн хүрээнд хэрэгжүүлэх, "шинжээч" зэрэг мөрдөн байцаах ажиллагааны түршид буюу шүүхэд гэрч болох байдлаар хууль сахиулах байгууллага болон шүүхийн тусын тулд мэргэжлийн үр чадвараа ашиглаж буй аливаа этгээдийг энэ нэр томъёонд хамруулах боломжийг оролцогч улсын зүгээс тооцож үзэх нь чухал. Түүнчлэн тэднийг гэрчид үзүүлсэнтэй адил хүрээний хамгаалалтын арга хэмжээнд хамруулах нь чухал.

Мөн удирдамжийн 33 дугаар зүйлд заасан "мэдээлэгч" буюу гэмт үйлдлийн талаархи баримт нотолгоог шударга ёсны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй этгээдийг хамгаалалтад авах эсэхийг шийдвэрлэх, хэрэв хуулийн хамгаалалтад оруулах бол мэдээлэгч этгээдийн хэн болохыг тогтоох, түүнд ямар аюул занал учирч болох, түүнээс илүү мэдээлэл авч болох эсэх, тухайн этгээд гэрчлэх мэдээлэлтэй эсэх, санхүүгийн болон ажил мэргэжлийн хувьд мэдээлэгч ямар аюулд өртөж болох, түүнчлэн ямар нөхөн олговор буюу нөхөн төлбөр олгож болохыг тооцох талаар зөвлөсөн байна.

Дүгнэвэл: дээрх олон улсын баримт бичигт заасан стандарт хэм хэмжээг нэгтгэн үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх талаарх олон улсын дараахь жишгийг тогтоосон байна:

- эрүүгийн байцаан шийтгэх болон бусад ажиллагааны явцад болон дараа гүтгэлэг, айлган сүрдүүлэх, заналхийлэл, өс хонзон авах байдлаас хохирогчийг хамгаалах талаар зохих арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авах;
- гэрч, хохирогчийг хамгаалах хангалттай хөрөнгийг зарцуулдаг механизмыг бүрдүүлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх, гэрчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;
- хамгаалалтыг шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөхгүй ч гэмт хэрэгт буруутгах бичиг баримт зэрэг чухал нотолгоог өгөх буюу тодорхойлох этгээдийг хамруулах байдлаар өргөн хүрээнд хэрэгжүүлэх.

Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа хараат бус бие даасан байх талаар олон улсын хүний эрхийг хамгаалах Хороодын удаа дараагийн зөвлөмжөөр манай улс үүрэг хүлээсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан "НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний 26-д "108.126. Гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг айлган сүрдүүлэх, дарамтлах, эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх, гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий бие даасан, хараат бус үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ авахаар тусгагдсан нь Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа бодлогын чухал арга хэмжээ юм.

6.1.2.Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулах чиглэлээр:

Олон улсын байгууллагуудаас тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах үр дүнтэй, хараат бус тогтолцоо бүрдүүлэх талаар манай улсад удаа дараагийн зөвлөмжийг өгсөөр байна. Тухайлбал:

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн механизмын Зөвлөмжийн нэгтгэл /2023 он/, Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлж, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтийн дунд хугацааны явцын 2024 оны тайлан /116.3, 116.51, 116.53, 116.54/-д эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколд заасны дагуу эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэргийг мөрдөн шалгах бие даасан байгууллага байгуулах, эрүү шүүлтийн талаарх гомдлыг хараат бусаар, шуурхай мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэх, эрүү шүүлтийн хэргийг мөрдөн шалгах бие даасан, үр дүнтэй гомдлын механизм бий болгох;
- Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хорооны 611 дүгээр Зөвлөмжийн 26-д Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх тусгай мөрдөн байцаах албыг 2014 онд татан буулгаж, чиг үүргийг Авилгатай тэмцэх газарт шилжүүлж, тухайн төрийн албан хаагчийн эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан гэх үйлдлийг өөр нэг төрийн албан хаагчаар мөрдөн шалгуулж байгаа одоогийн энэ бүтэц нь ижил түвшинд мөрдөн шалгах бие даасан байдал алдагдахад хүргэж, цаашлаад үр дүнтэй хяналтыг бий болгохгүй;
- Хүний эрхийн дэд хорооны 614 дүгээр Зөвлөмжийн 29-д "төрийн алба хаагчид, түүний дотор цагдаагийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг дахин бий болгох, мөрдөн шалгалтыг хараат бусаар, алагчилалгүй, үр дүнтэй, мөрдөгч болон гэмт хэрэгтнүүдийн хооронд ямар нэг холбоо үүсэхээс сэргийлсэн байдлаар явуулахыг Оролцогч улс нягтлан шалгах ёстой" гэж дүгнэжээ.

НҮБ-ын олон улсын стандарт боловсруулах эрх бүхий байгууллагуудаас шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон хэрэгжүүлэхэд оролцдог байгууллагын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлсон нэлээд баримт бичгийг баталсан. Тухайлбал:

-НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 12 дугаар зүйлд "оролцогч улсууд өөрсдийн харьяа нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх үйлдэл үйлдэгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал мөрдөн шалгах ажиллагааг эрх бүхий байгууллагаараа шударга болон шуурхай явуулна", 13 дугаар зүйлд "оролцогч улс түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авах" гэж заасан. Өөрөөр хэлбэл, улс орнууд эрүүдэн шүүгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал хөндлөнгийн, хараат бус хянан шалгах ажиллагааг явуулах үүрэгтэй байна.

-НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дугаар тогтоолоор баталсан "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал"-д гэмт хэргийн хохирогчтой шударгаар харьцах, айлган сүрдүүлэх, ес хонзон авах зэргээс хамгаалах, гэмт хэргийн хохирогчдод хууль ёсны болон захиргааны хамгаалалтын механизмын хүртээмжтэй байдлыг хангах, шаардлагатай мэдээллээр хангагдах эрхээр хангах, нөхөн олговор, нийгмийн халамжид хамруулах зэрэг зарчмыг тогтоосон.

-НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дугаартай тогтоолоор баталсан "Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтны зан үйлийн кодекс", "Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтны зан үйлийн кодексыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд баримтлах удирдлага болгох зарчим"-аар хууль сахиулах байгууллагын албан тушаалтны зүгээс Хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг хүндэтгэн дээдлэх, хамгаалах, зохистой харилцааны жишгийг тогтоосон.

-Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад зааснаар оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг авах үүрэгтэй байна.

Дүгнэвэл:Улс орнууд эрүүдэн шүүгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал хөндлөнгийн, хараат бус хянан шалгах ажиллагааг явуулах үүрэгтэй байна. Аюулгүй байдал нь халдлага, заналхийлэлд өртөж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг хамгаалах үр дүнтэй механизмыг бүрдүүлэх асуудалд олон улсын байгууллагууд илүү анхаарч байна. Манай улсад эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан гэх үйлдлийг мөрдөн шалгах хараат бус бие даасан нэгжийг дахин бий болгох, гомдлыг хараат бусаар, шуурхай мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэхийг зөвлөсөн байна.

6.2.Гадаадын зарим орны туршлага

Гэрч, хохирогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчийг төрийн хамгаалалт авах хүрээ, хязгаар, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байдлын талаар зарим орны туршлагыг авч үзэе.

6.2.1.Гэрч, хохирогчийг хамгаалах алба

Хүснэгт 14

Улс	Хамгаалах байгууллага
АНУ	28 U.S.Code Chapter 37 - UNITED STATES MARSHALS SERVICE АНУ-ын Маршалын алба АНУ-ын Кодекс II хэсэг. 561-575 дугаар зүйл.¹⁷ АНУ-ын Маршалын алба Хууль зүйн яаманд харьяалагддаг. Тэргүүнийг Ерөнхийлөгч томилдог бөгөөд Сенат зөвшөөрсөн байх ёстой. Алба нь хуульд зааснаас гадна Хууль зүйн сайдаас өгсөн үүргийг хэрэгжүүлдэг. Маршал бүр 4 жилийн хугацаатай томилогддог. Маршал нь хууль сахиулах байгууллагад 4-өөс дээш жил ажилласан, мужийн болон орон нутгийн хууль сахиулах байгууллагын ажлыг уялдуулан хамтран ажиллах туршлагатай, коллежийн түвшний академик мэдлэгтэй, мужийн болон холбооны шүүхийн системд ажиллаж байсан, эсхүл шүүгч, гэрчийг хамгаалах туршлагатай байх шаардлагыг тавьдаг. 562-р зүйл.Маршалын сул орон тоо гарвал Хууль зүйн сайд нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно. Сенат зөвшөөрөөгүй бол өөр хүн дэвшүүлнэ. 563.Маршалууд, дэд маршал бусад албан хаагч тангараг өргөнө. 564.Маршалууд дэд маршал, даргын томилсон бусад адилтгах албан тушаалтнууд үүргээ гүйцэтгэхдээ тухайн мужийн Шерифтэй адил эрх эдэлнэ. 566.Эрх үүрэг. Маршалын алба нь шүүхийн аюулгүй байдлыг хангах /400-аад газар байршилтай 94 холбооны шүүх/, шүүгч, тангарагтан, шүүхийн ажилтан, шүүгдэгч, бусад оролцогчдын АБ-ыг хангаж, шүүх хуралдааны дэг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, шүүхийн шатнаас оргон зайлсан этгээдийг мөрдөн шалгах, эрэн сурвалжлах, баривчлах, албадан ирүүлэх, сураггүй алга болсон болон мөлжлөгт өртсөн хүүхдийг хамгаалах, шүүгчийн захирамжаар яллагдагчийг хорих, мужуудын шүүх хооронд, хорих байр хооронд болон гадаад улсад хүргэх тусгай тоноглогсон автобус, машин, онгоцоор хуяглан хүргэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах /шүүх хурлын өмнө болон явцад/, шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон этгээдийн хөрөнгийг шүүхийн шийдвэрээр хураан авч, дуудлага худалдаа зохион байгуулах, олсон орлогоос нь хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлөх, хууль сахиулах үйл ажиллагааг бэхжүүлэх, олон нийтийн хөтөлбөрийг санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэдэг. Гэмт хэрэг үйлдээд газар дээрээ баригдсан, эсхүл тэрхүү гэмт хэргийг үйлдсэн гэх хангалттай үндэслэл байвал шүүгчийн захирамжгүй баривчлах эрхтэй. Товч түүх:1966 оноос АНУ-ын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гэрч болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцдаг болсон. Эхний үед нууц орон сууцуудыг барьж, гэрчийг шүүхэд мэдүүлэг өгөх хүртэл нууц орон сууцанд хамгаалдаг байсан. Гэрчийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг үндсээр нь өөрчлөх шаардлагын дагуу 1970 онд Конгрессын баталсан "Зохион байгуулалттай гэмт хэргийг хянах тухай хууль"- ийн дагуу аюулд өртөж болзошгүй гэрчийг хамгаалахад зориулж шаардлагатай арга хэмжээ авах эрхийг Улсын

¹⁷ <http://www.law.cornell.edu/uscode/text/28/part-II> | U.S. Code | US Law | LII / Legal Information Institute

	Ерөнхий Прокурорт өгсөн бөгөөд зохион байгуулалттай болон хүнд гэмт хэргийн гэрчүүд болон тэдний гэр бүлийн гишүүдийг нүүлгэн шилжүүлэх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах эрхтэй болсон. Ерөнхий Прокурорын гаргасан жагсаалтаар гэрчийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөрт дараах гэмт хэргийн чухалд тооцогдох гэрчүүд хамрагдаж байна: ¹⁸. • Зохион байгуулалттай болон айлган сүрдүүлэх гэмт хэрэг /АНУ-ын Нэгтгэмэл Хуулийн 18-р титулын 1961-р зүйл/; • Хар тамхины төрлийн гэмт хэрэг /АНУ-ын Нэгтгэмэл хуулийн 21-р титул/; • Холбооны Эрүүгийн хуульд Хүнд гэж заасан гэмт хэрэг. /мэдүүлэг өгсний улмаас гэрч аюулд өртөж болох/; • Иргэний болон захиргааны хэргийн талаар мэдүүлэг өгсний улмаас гэрч аюулд өртөж болзошгүй тохиолдлууд Гэрч болон хохирогчийг хамгаалах тухай хууль¹⁹ 1982 онд Конгресс баталсан. Холбооны хэмжээнд гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар зохицуулсан бөгөөд гэрч, хохирогчийн нэр, хаягийг нууцлах, хохирогчийг айлган сүрдүүлгээс урьдчилан сэргийлэх, хохирогчид нөхөн төлбөр олгох, шүүх ажиллагааны талаар мэдээлэл авах эрхийг хуульчилсан. Гэмт явдалд хяналт тавих тухай хууль /1984/-иар хамгаалалтад авах хүмүүсийн хүрээг өргөжүүлж, гэрчээс гадна тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамруулсан. Гэмт хэргийн хохирогчийн тухай акт. 1984 онд Конгресс баталсан. Хохирогчид болон нөхөн төлбөрийн хөтөлбөрийг дэмжих зорилготой. Гэмт хэргийн хохирогчийн Холбооны сан байгуулах эрх зүйн үндсийг тавьсан.
Оросын Холбооны Улс	Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд гэрч хохирогч болон бусад этгээдийн төрийн хамгаалалтын тухай Холбооны хууль, Хохирогч, гэрч болон эрүүгийн шүүн таслах ажиллагааны бусад оролцогчийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, ОХУ-ын Засгийн газрын "Хохирогчийг хамгаалах тухай" тогтоол /2009/ хэрэгждэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны гэрч хохирогч болон бусад этгээдийн төрийн хамгаалалтын тухай Холбооны хуулийн 3 дугаар зүйлд зааснаар: 1/ аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ: биечилсэн хамгаалалт, эд хөрөнгийн хамгаалалт; холбооны тусгай хэрэгсэл олгох, мэдээллийн нууц байдлыг хангах, бичиг баримтыг солих, гадаад төрхийг өөрчлөх, нүүлгэн шилжүүлж байрлуулах; аюулгүй байранд түр байлгах, хяналтад байгаа, эсхүл ял эдлүүлэх газарт байгаа хамгаалуулагчийг өөр газарт шилжүүлэх. 2/ төрийн хамгаалалтыг хангах шийдвэр гаргах:ЭБША-ны явцад төрийн хамгаалалтаар хангах шийдвэрийг шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын дарга гаргана. Гэрч, хохирогч, эрүүгийн шүүн таслах ажиллагааны бусад оролцогчдын аюулгүй байдлын арга хэмжээ авах байгууллага: 1/Шүүх, прокурорын шатанд ОХУ-ын дотоод явдлын яам, Холбооны аюулгүй байдлын алба, ОХУ-ын гаалийн байгууллагууд, Хар тамхи, мансууруулах зүйлийн хэрэглээг хянах байгууллага /шүүгч, прокурорын шийдвэрээр тэдний байрлаж буй газраас хамааран/ 2/цэргийн албан хаагчийн аюулгүй байдлын арга хэмжээг тухайн цэргийн хэсгийн командлал, дээд командлалаас авна. 3/мөрдөн шалгах тусгай газарт, эсхүл ял эдлүүлэх газарт байгаа хамгаалуулагчийн аюулгүй байдлын арга хэмжээг ОХУ-ын Хууль зүйн яамны эрүүгийн шийдвэр биелүүлэх байгууллага авна.²⁰ 2008 оны Хууль сахиулах байгууллагын тухай холбооны хууль. ОХУ-ын ХЗЯ-ны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн холбооны алба²¹ /Федеральная Служба Судебных Приставов/ ОХУ-ын хэмжээнд 9 тойргийн 85 салбартай. Шүүхийн Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийг Ерөнхийлөгч томилдог. ОХУ-ын шүүх, арбитрын аюулгүй байдлыг хангах, хуралдааны дэг сахиулах, оролцогчийг эрэн сурвалжлах, албадан ирүүлэх, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг шүүхийн шийдвэрээр ОХУ-

¹⁸ "Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шатанд прокурор, цагдаа, гааль, тагнуулын байгууллагын харилцан уялдаа, түүний онцлог судалгааны тайлан", ХСИС, 22-29 дэх тал

¹⁹ Хохирогчийн эрхийг хамгаалах төв. "Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал" судалгааны тайлан 2010 он, 44 дахь тал.

²⁰ мөн тэнд 58, 63 дахь тал.

²¹ <https://legalddata.mn/b/731> Б.Батзориг. Шүүх засаглалын аюулгүй байдлыг хангаж байгаа гадаад орны туршлага 2020.8.11

	ын нутгаас албадан гаргах, шилжүүлэн өгөх, харьяаллын хэрэгт хэрэг бүртгэлт явуулах, захиргааны зөрчил хянан шийдвэрлэх, хураагдсан болон битүүмжилсэн хөрөнгийг үнэлэх, хадгалах, дуудлага худалдааг зохион байгуулах чиг үүрэгтэй.
Румын улс	Гэрчийг хамгаалах Үндэсний газар ажилладаг ²² . Уг газар нь Дотоод хэргийн яамны харьяанд, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах албаны дэргэд байдаг. Бүрэн эрх: Хөтөлбөрт заасан хамгаалалтын боломжит бүхий л арга хэмжээг авах; хамгаалагдсан гэрч болон бусад этгээд хоорондын холбоог тодорхойлох, аюултай нөхцөлд холбогдох баталгаа өгөх; гэрчийн хамгаалалтын асуудлыг шийдвэрлэх, тодорхойлох, зохистой ажиллагаа явуулах; олж авсан мэдээ, мэдээллийн нууцлалын талаар баталгаа гаргах; Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу ХЗЯ хохирогчтой шууд холбоо тогтоох эрхтэй. Дотоод хэргийн сайдын зөвшөөрснөөр төсвөө удирдана.
БНТурк улс	Гэрчийг хамгаалах тухай хууль. Гэрчийг хамгаалах хороог Дотоод хэргийн яам байгуулна. Хороо нь 11 гишүүнтэй /ХЗЯ-нд захиргааны чиг үүрэгтэй ажиллаж байгаа нэгдүгээр зэргийг шүүгчдээс 2, Шуугч, Прокурорын дээд хороо Анкарад ажиллаж байгаа нэгдүгээр зэргийн шүүгч, эсхүл прокуророос сонгогдсон 1, Батлан хамгаалах яаманд захиргааны чиг үүрэгтэй ажиллаж байгаа нэгдүгээр зэргийн цэргийн шүүгч нараас 1, Дотоод хэргийн яамны төв аппаратаас 1, Жандарма /цэргийн цагдаа/-ын командлалаас 1, Цэргийн хамгаалалтын командлалаас 1, Цагдаагийн ерөнхий газраас 3, Гааль болон гаалийн хамгаалалтын ерөнхий газраас 1 гэсэн бүрэлдэхүүнтэй томилдог байна. Хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд хороо сард нэг удаа, шаардлагатай үед даргын зарласнаар хуралдаж, олонхийн саналаар шийдвэр гаргана, Хорооны ажлын албыг Дотоод хэргийн яам гүйцэтгэдэг. Хорооны үйл ажиллагааг журмаар зохицуулахаар заасан.Хороо үйл ажиллагаагаа Дотоод хэргийн болон Хууль зүйн яаманд тайлагнана. Гадаадын харьяат гэрчийг хамгаалах асуудлаар Турк Улсын нэгдсэн орсон олон улсын болон хоёрт талт гэрээгээр зохицуулах бөгөөд гэрээгүй бол харилцан адил байх зарчимд нийцүүлэн Туркт хамгаалах асуудлыг Гадаад хэргийн яамны саналыг авснаар Дотоод хэргийн яам шийдвэрлэнэ. ²³
Бүгд Найрамдах Казахстан Улс	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийн төрийн хамгаалалтын тухай хууль 2000.06.05. ²⁴ Энэ хууль нь ЭБША-нд саад учруулах явдлыг таслан зогсоох зорилгоор ЭБША-ны оролцогчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, ойрын төрөл садангийн хүмүүсийн аюулгүй байдлыг хангах төрийн арга хэмжээний тогтолцоог тогтооно. Хамгаалагдаж буй этгээдийн аюулгүй байдлыг дараахь байгууллага хангана: Хэрэгжүүлэгч байгууллага: Үндэсний аюулгүй байдлын байгууллага, санхүүгийн цагдаа, хууль зүйн, дотоод хэргийн, цэргийн удирдлагын байгууллага болон гаалийн хүрээний ажил хэргийн төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч байгууллага хариуцна. Эдгээр байгууллагууд дараахь эрхтэй: Хамгаалагдаж буй этгээдэд процессын үйлдлээс бусад аюулгүй байдлын зайлшгүй шаардлагатай арга хэмжээг сонгох, тэдгээрийг хэрэглэх аргыг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд хэрэглэж буй аюулгүй байдлын арга хэмжээг өөрчлөх, нэмэх; Хамгаалагдаж буй этгээдээс хүсч буй аюулгүй байдлын арга хэмжээг хэрэглэх нөхцлийг сахих буюу тухайн арга хэмжээг хэрэглэхтэй холбоотой хууль ёсны захирамжийг биелүүлэхийг шаардах, аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэр гаргаж буй байгууллагад аюулгүй байдлын арга хэмжээг хэрэглэх, эсхүл түүнийг цуцлах талаар хандах, хуулиар тогтоосон журмаар шуурхай эрэн сурвалжлах арга хэмжээ явуулах. Аюулгүй байдлын арга хэмжээг хэрэглэх тухай шийдвэр гаргаж буй байгууллага: Энэ нь төрийн байгууллага, хувь хун, хуулийн этгээдээс хамгаалуулагчийн аюулгүй байдалд аюул занал учрах талаарх зайлшгүй шаардлагатай мэдээллийг авах, шаардах, аюулгүй байдлыг хэрэгжүүлж буй байгууллагад даалгавар өгөх, процессын үйл ажиллагаа явуулах эрхтэй байгууллага юм. Хуулийн хэрэгжилтэд Улсын Ерөнхий прокурор, бусад прокурор хяналт тавина.
БНХАУ	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 62-р зүйл. Гэрчийн мэдүүлгийн улмаас хувь хүнд аюул тулгарвал хамгаалалтын арга хэмжээ авахаар тусгасан. Гэрчийг хамгаалах бие даасан байгууллага байхгүй. Төрийн болон шүүхийн байгууллагууд гүйцэтгэдэг. Гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан хөтөлбөр хэрэгждэггүй. Хамгаалалт нь ихэвчлэн тухайн нөхцөл байдалд нийцсэн, хариу арга хэмжээ авах хэлбэртэй байдаг. Нүүлгэн шилжүүлэх, баримт бичиг солих арга хэрэглэдэггүй.

²² Хохирогчийн эрхийг хамгаалах төв. "Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал" судалгааны тайлан 2010 он, 58 дахь тал.

²³ мөн тэнд 59 дэх тал

²⁴ https://kodeksy-kz.com/ka/0_gosudarstvennoj_zawite_list.htm

	Цагдаагийн газрын Олон нийтийн аюулгүй байдлын товчоод гэрч хохирогчид хязгаарлагдмал хамгаалалт үзүүлж болно. Шүүхүүд хурлыг хаалттай явуулах, дуу дүрс өөрчлөх зэрэг арга хэмжээ авдаг. Ардын шүүхийн цагдаа нь шүүхийн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, оролцогчийг хамгаалах ажиллагаа хэрэгжүүлдэг. Мэргэшсэн тусгай албаар гүйцэтгүүлснээр хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндэс болдог гэж үз дэг байна. Ардын шүүхийн цагдаа нь цаазын ял гүйцэтгэдгээрээ бусад орноос онцлог байна. ²⁵
--	---

Дүгнэвэл: Улс бүр өөрийн орны эрх зүйн тогтолцоо, бодит боломждоо тулгуурлан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн байдал улс бүрийн тухайд өөр өөрийн онцлогтой байна: АНУ-ын Маршалын алба хамгийн хүчирхэг бие даасан алба болон бэхжсэн. Тус алба Хууль зүйн яаманд харьяалагддаг. Тэргүүнийг хууль зүйн сайдын санал болгосноор ерөнхийлөгч томилдог. Онцлог нь Хууль зүйн сайд нь Ерөнхий прокурор байдаг.

Румынд Дотоод хэргийн яамны харьяанд, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах албаны дэргэд Гэрчийг хамгаалах Үндэсний газар ажилладаг. Турк-д Дотоод хэргийн яам нь Гэрчийг хамгаалах 11 гишүүнтэй Хороо /хууль зүйн яам, батлан хамгаалах яам, дотоод явдлын яам, шүүх, прокурорын дээд хороо, цэргийн цагдаагийн командлал, цагдаагийн ерөнхий газар, гааль-/г байгуулж, үйл ажиллагаагаа Дотоод хэргийн болон Хууль зүйн яаманд тайлагнана. Хорооны ажлын албыг Дотоод хэргийн яам гүйцэтгэдэг байна. ОХУ-д хууль зүйн яамны Эрүүгийн шийдвэр биелүү лэх байгууллага, Дотоод хэргийн яам, цэргийн удирдлагын байгууллага болон гаалийн байгууллага, Казахстанд прокурорын байгууллага хяналт тавьдаг, Үндэсний аюулгүй байдлын байгууллага, Санхүүгийн цагдаа, хууль зүй, дотоод хэргийн цэргийн удирдлагын байгууллага, гаалийн байгууллага аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

6.2.2.Хамгаалалт үйлчлэх субъектээр авч үзвэл:

Хүснэгт 15

Улс	Хамгаалалтад хамрагдах этгээд ²⁶
АНУ	Бүх гэмт хэргийн гэрч, хохирогч, тэдгээрийн гэр бул, ойр дотны хүмүүсийг хамааруулан ойлгодог. Хучингийн болон хүнийг хүчээр алга болгох, хулгайлах зэрэг бие махбод, сэтгэл санааны ноцтой хохирол учруулдаг гэмт хэргийн хохирогчийг илүү анхаардаг.
ХБНГУ	Гэрчийг хамгаалах тухай хуулиар бүх гэрчид үйлчилнэ. Гэрч нь хохирогч мөн уу гэдэгт биш, харин гэрчид хамгаалалт хэрэгтэй байна уу гэдэг философи дээр тулгуурлана.
ОХУ	Дараах этгээд хамгаалалтад хамрагдана: • Хохирогч; • Сэжигтэн; • Иргэний яллагч; • Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, ялтан, цагаатгагдсан этгээд, түүнчлэн хэрэгсэхгүй болсон хэргийг мөрдөн байцаах ажиллагаанд буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид; • Шинжээч, мэргэжилтэн, • орчуулагч, • хөндлөнгийн гэрч, • эрүүгийн шуун таслах ажиллагаанд хэл шинжлэл, сэтгэл судлаачаар оролцогч; • Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч; • Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн иргэний яллагчийн төлөөлөгч, хууль ёсны төлөөлөгч

²⁵ <http://gongbao.court.gov.cn/details/9cb05785bb151f791c1634ed0d1b0b.html>

²⁶ Хохирогчийн эрхийг хамгаалах төв. "Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал" судалгааны тайлан 2010 он, 51-55 дахь тал.

	- Эрүүгийн хэргийн талаар мэдээлсэн мэдээлэгч, гэрч, эсвэл гэмт хэргийн хохирогч болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд оролцсон бусад этгээдүүдэд төрийн хамгаалалтын арга хэрэгслийг хэрэглэж болно. - төрөл садан, ойрын танилыг учирч болох халдлагаас төрийн хамгаалалтаар хамгаална.
Румын улс	Гэрч: - Засан хүмүүжүүлэх тухай хуулийн дагуу хунд гэмт хэргийг илрүүлэх, хунд гэмт хэрэгтэй холбоотойгоор ноцтой хохирол учруулахаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх мэдээлэл бүхий этгээд. - процесст албан тушаалын байдлаар холбоогүй бөгөөд мэдээлэл болон тоо баримт нь хунд гэмт хэргийг илрүүлэх, түүнтэй холбоотойгоор ноцтой хохирол учруулахад саад хийхэд дэмжлэг үзүүлэх мэдээлэл өгсөн этгээд. Энэ төрөлд бусад гэмт хэрэгт гэм буруутай этгээд хамаарна. - шийдвэр гүйцэтгэх этгээд болон хунд гэмт хэрэгтэй холбоотойгоор учирч болох ноцтой хохирол учруулахад саад хийхэд дэмжлэг үзүүлсэн мэдээлэл бүхий этгээд, гэр бүлийн гишүүн болон дотно хүн - гэрчийн гэр бүлийн гишүүн гэдэг нь түүний эхнэр/нөхөр, эцэг эх, хүүхэд, дотно хун гэдэгт гэрчтэй сэтгэл санааны хувьд дотно холбогдсон этгээдийг ойлгоно. Хохирогч: - хүн амины гэмт хэрэг, санаатайгаар хүний амь насыг хохироосон гэмт хэрэг, хунд ноцтой хүн амины гэмт хэрэг; - гэр бүлийн гишүүний эрүүл мэндэд халдсан болон бусад байдлаар хүч хэрэглэсэн гэмт хэрэг; - хүний бие махбодид хунд гэмтэл учруулсан, хохирогчийн биед санаатайгаар хунд гэмтэл учруулсан гэмт хэрэг; - хүчин, насанд хүрээгүй этгээдтэй санаатайгаар бэлгийн харьцаанд орсон, ёс бусаар болон зүй бусаар бэлгийн харьцаанд орсон гэмт хэрэг; - насанд хүрээгүй этгээдэд дур мэдэн эмчилгээ хийсэн гэмт хэрэг; - хүн худалдаалах гэмт хэрэг.
Турк Улс	Гэрчийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай гэмт хэргүүдийг ГХТХ-ийн 3 дугаар зүйлд зохицуулсан байна. - насаар нь хорих, 10 ба түүнээс дээш жил хорих ялтай гэмт хэргийн гэрч - зохион байгуулалттай гэмт хэргийн 2 ба дүүнээс дээш жил хорих ялтай гэмт хэргийн гэрч - тероррист булгийн үйл ажиллагааны хүрээнд үйлдсэн гэмт хэргийн гэрч - эрүүгийн шүүх ажиллагаанд гэрчээр мэдүүлэг өгч байгаа этгээд, - тэдгээрийн сүйт бүсгүй болон залуу, гэр бул салсан байсан ч эхнэр, нөхөр, цусан болон ургийн холбооны дээд, доод 2 дахь үеийн хамаатан садан болон өргөмөл хүүхэд, тэдэнтэй холбоотой болон ойр харилцаатай байгаа хүмүүс хамгаалалтад хамаарагддаг байна.
Тайвань Улс	Дараах гэмт хэргийн гэрч, хохирогч: - Эрүүгийн хуулийн тодорхой төрлийн гэмт хэргийн; - Хүүхэд, залуучуудыг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх актын зарим зүйлд заасан гэмт хэргийн; - Хүн худалдаалах гэмт хэргийн; - Эрүүл мэнд болон бие махбодийн хувьд хохирсон болон талууд хууль бус арга хэрэглэсний улмаас хохирол хүлээсэн тал;

	- Ашиг хонжоо олох зорилгоор хуурч мэхлэх, хүч хэрэглэх, эсвэл гэр бүлийн гишүүдээс үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч²⁷. - Эдгээрийн гэр бүлийн гишүүд
БНСУ	Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах хуулийн 3 дугаар зүйлийн дагуу хамгаалалтад хамрагдах этгээдэд хохирогчоос гадна түүний эхнэр нөхөр, гэр бүл, хамаатан садан хамрагдана. Тус улсын хуулиар гэмт хэрэгтний гэм буруутай гэдгийг тогтоохын тулд гэрч болон нотолгоо байхыг шаарддаг. Гэрч болон нотолгоогүй бол сэжигтэн жинхэнэ гэмт хэрэгтэн байсан ч яллах боломжгүй. Гэрчийг хэргийн газар, гэмт хэргийн талаар үнэнийг мэдэх гэрч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хам хэрэгтэн гэж ангилж үздэг.
БНХАУ	Хамгаалалтад хамрагдах этгээд: - Гэрч; - Хохирогч /иргэн, компани, аж ахуй нэгж байж болно/; - Хохирогчийн гэр бүлийн гишүүн; - Хохирогчтой дотно харилцаатай байсан ойрын төрөл садан. - Хохирогчийн асрамжинд байсан насанд хүрээгүй этгээд; Хохирогчийн асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй этгээд.
Бүгд Найрамдах Казахстан Улс	Казахстан улсын ЭБШХ болон ЭБША-нд оролцож буй этгээдийн төрийн хамгаалалтын тухай хуулийн дагуу төрийн хамгаалалтад дараах этгээд байна²⁸: - шүүгч; - прокурор; - иргэдийн төлөөлөгч - мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, - шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагаа явуулж буй этгээд /тийм байгууллагад тусалж буй иргэн, хувийн ялагч/; - өмгөөлөгч; - шинжээч, мэргэжилтэн; орчуулагч; - шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч; - хохирогч; - гэрч; хөндлөнгийн гэрч; - сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, мөн эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа дуусгавар болсон буюу шүүхээс цагаатгагдсан этгээд; - төлөөлөгч, хууль ёсны төлөөлөгч; - иргэний нэхэмжлэгч, хариуцагч; - эдгээрийн гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх буюу илрүүлэхэд туслалцаа үзүүлэх этгээдэд эрүүгийн хуулиар хоригдосон хүч хэрэглэх буюу бусад үйлдлийг хийх бодитой аюул бий болсон үед эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө хэрэглэж болно.

Дүгнэвэл: Олон улсын стандарт, гадаад улсуудын эрх зүйн зохицуулалт, практикийг судалж үзэхэд олон улсын түвшинд Төрийн хамгаалалт нь зөвхөн аюулгүй байдал нь халдлага, заналхийлэлд өртөж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдод иэхэнхдээ хамаарч байна.

Судлагдсан улс орнуудын туршлагаас харахад хамгаалалтад авах этгээдийг нэг бүрчлэн нэрлэн заасан, эсхүл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг, эсхүл гэмт хэргийн төрлөөс хамааран, эсхүл үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээнээс хамааран хамгаалалтад авахаар зохицуулжээ. ОХУ, Казахстан улсын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бүх этгээдийг хамгаалалтад авдаг байна. Гэрчийн гэр бүлийн гишүүдийг хамгаалалтад хамааруулдаг бөгөөд Турк улсын хувьд нэлээд өргөн хүрээнд авч сүйт бүсгүй/залуу, салсан эхнэр/нөхөр, цусан болон ургийн

²⁸ https://kodeksy-kz.com/ka/0_gosudarstvennoj_zawite_list.htm

холбооны дээд, доод 2 дахь үеийн хамаатан садан болон өргөмөл хүүхэд, тэдэнтэй холбоотой болон ойр харилцаатай байгаа хүмүүсийг хамгаалдаг байна.

6.2.3.Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлж буй олон улсын болон гадаадын зарим орны зохицуулалт, туршлага

Бие даасан цагдаагийн Хяналтын байгууллага (Independent Police Oversight Body буюу "ИПОВ")²⁹

Эрүүдэн шүүхийн эсрэг санаачилга (СТИ) нь НҮБ-ын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC)-тай хамтран 2024 онд гаргасан Police Resource Toolkit-ийн 8 дугаар бүлэг "Хараат бус мөрдөн шалгах ажиллагаа, хяналтын механизм" хэсэгт ИПОВ-ыг байгуулахад дараах асуудлыг анхаарахыг зөвлөжээ:

- ИПОВ-ын эрх зүйн байдлыг хуулиар тогтоож, түүний бүрэн эрхийг бусад хууль сахиулах байгууллагаас онцлог, тусдаа болохыг заах хэрэгтэй.
- ИПОВ-ын хараат бус байдлыг хангахад санхүүжилтын асуудал чухал үүрэгтэй. Хангалттай хэмжээний төсөвтэй, цалинтай байх нь хараат бус байдлыг хангана.
- цагдаагийн байгууллагаас тусдаа байртай байх, зөвхөн зөвшөөрөгдсөн хүн нэвтрэх боломжтой байх, иргэдэд цагдаагаас хараат бусаар ажилладаг ойлголтыг өгөх /гэрч, хохирогч нар цагдаагийн байр руу орох дургүй байдаг/
- Дарга нь Засгийн газрын 1 бүтцэд ажиллана. Гэхдээ Парламент, эсхүл түүнтэй ижил байгууллагад тайлагнана. Энэ нь Засгийн газрын нөлөөнөөс ангид байлгана. Энэ үзэл баримтлал Өмнөд Африкийн Хараат бус цагдаагийн хяналтын Захирлын (South Africa's Independent Police Investigative Directorate) Үндсэн хуулийн хамгаалалт болж орсон. Бусад улсын хувьд жишээ нь Ямаик улсад "ямар нэг байгууллага, албан тушаалтны удирдлага, хяналтад хамаарахгүй" гэж хуульд тусгагдсан.
- ИПОВ-ын бие даасан байдлыг хангахын тулд ИПОВ-ын даргаар өмнө нь цагдаагийн алба хашиж байсан хүмүүсээс томилохгүй байх шаардлагыг оруулах нь зүйтэй.
- ИПОВ-ийн мөрдөн байцаагчид цагдаа болон бусад хууль сахиулах байгууллагын ажилтантай ижил бүрэн эрхтэй, цалин нь ижил, эсхүл өндөр байх ёстой. Мөн тусгай тэмдэг хэрэглэдэг, ялгагдахуйц өөр дүрэмт хувцастай байх ёстой.
- ИПОВ-ийн мөрдөн байцаагчид баривчлах, цагдан хорих бүрэн эрхтэй, шүүхэд эрэн сурвалжлуулах, холбоо харилцааны хуудас авах, баримт материалыг авах хүсэлт гаргах эрхтэй байна.

ИПОВ нь цагдаагийн ажилтны үйлдсэн хүн амины гэмт хэрэг, хүнд гэмтэл болон эрүүдэн шүүх, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг. Зарим улсад цагдаагийн хяналтад байхдаа сураггүй алга болсон, хууль зүйн захиргааны эсрэг үйлдсэн гэмт хэргийг мөн хамаардаг. Дарга нь нийтийн чухал ашиг сонирхол хөндөгдөнө гэж үзвэл мөрдөн шалгах харьяаллыг тогтоох эрхтэй байдаг.³⁰ Албан үүргээ биелүүлээгүй үедээ буюу чөлөөт үед үйлдсэн гэмт хэргийг хянан шалгадаггүй. Гэхдээ цагдаагийн ажилтны үүрэг болон гарсан зөрчил хооронд холбоо хамаарал байвал ИПОВ шалгадаг байна.

Мөн дээрх эх сурвалжид дараах орнуудын тусгай мөрдөн шалгах нэгжийн онцлогийг дурджээ³¹:

- **Канадын Онтарио: Тусгай шалгалтын нэгж (Special Investigations Unit, SIU)** Энэ байгууллага нь хуулиар бүрэн эрх олгож, түүний хараат бус байдлыг хангахаас гадна бүрэн эрхийн цар хүрээ, хэмжээг тогтоож өгсөн. Цагдаагийн үйлдсэн хүн амины хэрэг, хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэг, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шалгадаг бөгөөд эрүүгийн мөрдөн

²⁹ Эрүүдэн шүүхийн эсрэг санаачилга (СТИ) нь НҮБ-ын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC)-тай хамтран 2024 онд гаргасан Police Resource Toolkit-ийн 8 дугаар бүлэг "Хараат бус мөрдөн шалгах ажиллагаа, хяналтын механизм". Police resource toolkit, Chapter 8, Convention against torture initiative, 2024

³⁰ Хойд Ирландын 1998 оны Цагдаагийн тухай хуулийн 55.6-д Хойд Ирландын Цагдаагийн омбудсман "нийтийн ашиг сонирхлын тулд шаардлагатай гэж үзвэл" мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх бүрэн эрхийг олгосон.

³¹ Police resource toolkit, Chapter 8, Convention against torture initiative, 2024

шалгах ажиллагааг явуулдаг. Бусад орныхоос ялгаатай нь захирал нь эрүүгийн хариуцлага тооцох шийдвэрийг гаргадаг бөгөөд прокурорын үйлчилгээ үзүүлдэггүй.

- **Хойд Ирланд: Цагдаагийн омбудсман (Police Ombudsman of Northern Ireland)** Хойд Ирландын Цагдаагийн Албанд харьяалалтайгаас гадна, PONI нь Белфастын Боомтын Цагдаа, Белфастын Олон Улсын Нисэх Онгоцны Буудлын Цагдаа, Батлан Хамгаалах Яамны Цагдаа болон Үндэсний Гэмт Хэрэгтэй Тэмцэх Агентлагтай холбоотой хэргийн мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг. Тус алба нь 24 цагийн турш долоо хоногийн бүх өдөр ажиллах шуурхай хариу үзүүлэх системтэй бөгөөд цагдаагийн албанд мэдэгдэл хүргүүлэх зааварчилгаа өгдөг.
- **Кени: Цагдааг хянан шалгах бие даасан байгууллага (Independent Policing Oversight Authority, IPOA)** Кени улсад болсон сонгуулийн халдлага болсны дараа Мөрдөн байцаах комисс (Commission of Inquiry)-ийн зөвлөснөөх IPOA-г байгуулсан. Комисс нь удирдах зөвлөлтэй бөгөөд захирал үйл ажиллагааг явуулдаг. Удирдах зөвлөл нь мөрдөн шалгах ажиллагааны төгсгөлд торгох, эсвэл сахилгын арга хэмжээ авах зэрэг зөвлөмж өгөх асуудалд хамтын шийдвэр гаргадаг.
- **Өмнөд Африк: Цагдааг мөрдөн шалгах бие даасан газар (Independent Police Investigative Directorate, IPID)** Үндсэн хуулиар цагдаагийн ямар нэгэн хууль бус үйлдлийг шалгах мөрдөн шалгах байгууллага байх хэрэгцээг бататгасан. IPID-н даргыг парламентын 2/3-ын шийдвэрээр чөлөөлнө.
- **Ямаик улс: Бие даасан шалгалтын хороо (Independent Commission of Investigations, INDECOM)** Энэ байгууллага нь ажлаа хийж байх үедээ болон хийгээгүй байх үедээ үйлдсэн албан тушаалтны бүх хэргийг шалгадаг. Энэхүү байгууллага байгуулагдсанаар цагдаагийн албан тушаалтан оролцсон хүний амь нас хохирсон хэрэг 25 хувиар буурсан байна.

Өмнөд Африк, Ямаик, Израйл зэрэг улсын IPOB нь хэд хэдэн бүсэд байршилтай байдаг бөгөөд онлайнаар гомдол хүлээн авдаг вебсайтаар байдаг байна.

Америкийн Нэгдсэн Улс. АНУ-д хууль сахиулах байгууллагын албан хаагчдын гаргасан зөрчил болон үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий хэд хэдэн байгууллага байна.

- Хууль зүйн Яам (Department of Justice) – нь иргэний эрхийн зөрчлүүд болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн зөрчлүүдийг мөрдөн шалгадаг.
- Холбооны мөрдөх товчоо (FBI) - Олон нийтийн албан тушаалтны авлига, иргэний эрхийн зөрчлүүд болон эрүүгийн хэргийг мөрдөн шалгадаг.
- Ерөнхий Прокурорын Газар (State Attorney General's Office)- Ихэнх мужуудад шүүгч, прокурор зэрэг улс төрийн албан тушаалтнуудын зөрчлүүдийг шалгадаг тусдаа албатай байдаг.
- Цагдаагийн Хяналтын Зөвлөл - Олон хотод цагдаа нарын зөрчлүүдийг шалгах болон иргэний гомдлуудыг хянадаг бие даасан зөвлөл байдаг.
- Америкийн Иргэний Эрхийн Холбоо (ACLU) - Иргэний эрхийг хамгаалдаг бөгөөд цагдаа, шүүхийн зөрчлүүдийг шалгах, мэдээлэхэд голчлон ажилладаг.
- Үндэсний Цагдаагийн Хариуцлагын Төсөл (NPAP) – Цагдаагийн алба хаагчдын үйлдсэн зөрчлүүдийн хохирогчдыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- Прокурорын шударга байдлын төв (The Center for Prosecutor Integrity) - Прокурорын тогтолцоон дахь хариуцлага, ил тод байдлыг дэмжих чиглэлээр ажилладаг.
- Хууль сахиулах үйл ажиллагаанд иргэний хяналтын үндэсний нийгэмлэг (NACOLE) - Хууль сахиулах ажиллагаанд иргэний хяналтыг дэмжиж, хариуцлагын сайн туршлагыг сурталчилдаг.

Хууль зүйн яамны дэргэдэх Ерөнхий байцаагчийн албаны Мөрдөн шалгах хэлтэс (Investigation Division of Office of the Inspector General)³² нь цагдаагийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтан, шүүгч, прокурор, хууль сахиулах байгууллагын албан хаагчдад холбогдох хүч хэрэглэсэн, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан, хэлс хэргээр баривчлагдсан, шүүгдэгчид бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсан, санаатайгаар эмнэлгийн тусламж үзүүлэхээс зайлсхийсэн, бэлгийн дарамт үзүүлсэн, гэмт хэргийг таслан зогсоохоос зайлсхийсэн, гэрч,

³² Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, “Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллын талаарх харьцуулсан судалгаа”, 2024.10.15, 12 дахь тал

хохирогчийг мэдүүлэг өгөхөд саад учруулсан, мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн, баримт нотолгоог хуурамчаар үйлдсэн гэх мэт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгадаг.

Бүтцийн хувьд захиргааны болон мөрдөн шалгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэлтэс, гомдол, мэдээлэл хүлээн авах хэлтэс, зүүн, баруун, өмнөд, дорнод зэрэг бүсийн төлөөлөгчийн газрууд, кибер мөрдлөгийн хэлтэс, залилан мэхлэлтийг илрүүлэх хэлтэстэй.

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд, төрийн өндөр албан тушаалтантай холбоотой хэргийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурорын томилсон тусгай төлөөлөгч шалгадаг. Тусгай төлөөлөгч нь өөрийн эрх мэдлийн хүрээнд худал мэдүүлэг өгөх, үнэн мөнийг гуйвуулах, баримт нотолгоог устгах, гэрчийг айлган сүрдүүлэх зэрэг гэмт хэргийг мөрдөх, ял оноох эрхтэй.

Шүүгчийн буруутай үйл ажиллагаа болон эрх мэдлээ урвуулан ашигласан бол тухайн иргэний гомдол нотлох баримтыг үндэслэн Тусгай төлөөлөгч хянаад ерөнхий прокурорт танилцуулж, тусгай чиглэл авдаг.

АНУ-ын Хууль зүйн яамнаас 1999 онд баталсан Холбооны улсын эрх зүйн актуудын код (code of federal regulations)-ын 28 дугаар хэсгийн 6-р бүлгийн 600.2-т зааснаар Тусгай төлөөлөгч нь хуульч мэргэжилтэй, нөлөөнд автахгүй, аль нэг талыг баримтлан шийдвэр гаргахгүй, мөрдлөгийг мэргэжлийн, шуурхай, нарийвчилсан байдлаар явуулах чадвартай байна. Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийг ажлаас чөлөөлөх, шийтгэл оногдуулах эрхтэй. Хууль зүйн сайд нь Ерөнхий прокурор байдаг.

Бүгд Найрамдах Армени Улс. 2007 оны Мөрдөн шалгах Тусгай алба³³. Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль (Закон о специальной следственной службе)-иар зохицуулдаг төрийн тусгай алба. Албаны даргыг Улсын ерөнхий прокурорын саналаар Улсын ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. Бусад алба тушаалтныг тусгай албаны дарга томилж, чөлөөлнө. Дарга нь үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавина. Албаны ажилтны эсрэг эрүүгийн хэрэг үүсгэн шалгах харьяаллыг Улсын Ерөнхий прокурор тогтооно.

Албаны зорилго нь гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тодорхойлох, эрүүгийн хариуцлагаас зайлсхийсэн болон сураггүй алга болсон этгээдийг эрэн сурвалжлах, тогтоох, гэрч, цогцос, гэмт хэргийн мөр, эд зүйл, эд мөрийн баримт, материалыг илрүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай мэдээллийг олж авах, хууль бусаар гааль болон хил нэвтрүүлэхийг илрүүлэх, таслан зогсоох, татварын хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх, ил болгох, хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, төрийн тусгай хамгаалалтад байгаа ажилтны аюулгүй байдлыг хангах, нууцад хамаарах мэдээлэлд нэвтрэх, зөвшөөрөх, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд иргэншил, улс төрийн орогнол, оршин суух статус олгох тухай дүгнэлт гаргах, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулах.

Тусгай алба нь 1/авилга, зохион байгуулалттай гэмт хэрэг, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс, 2/эрүүдэн шүүх болон хүний эсрэг гэмт хэргийг мөрдөх хэлтэс, 3/нийтлэг шинжтэй гэмт хэргийг мөрдөх хэлтэстэй.

Тусгай алба нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон төрийн тусгай албаны ажилтан албан тушаалаа урвуулан ашиглах, эсхүл биеэр үйлдсэн гэмт хэрэг, мөн сонгуулийн үйл явцтай холбоотой эрүүгийн гэмт хэргийг урьдчилан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулна.

Хамрах албан тушаалтан:Ерөнхийлөгч, түүний ажлын албаны дарга, Ерөнхий сайд, шадар сайд, парламентын гишүүд, үндсэн хуулийн шүүхийн тэргүүн, гишүүн, шүүгч, сайд, дэд сайд, ажлын албаны дарга, яамд, агентлагийн дарга, орлогч, мужийн захирагч, орлогч, нийслэлийн захирагч, орлогч, төрийн

³³ Парламентийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, “Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллын талаарх харьцуулсан судалгаа” 2024.10.15. 18 дахь тал

хянан шалгах палатын зөвлөлийн дарга, гишүүд, төв банк, Зохицуулах хороод, сонгуулийн хороо, үндэсний статистикийн хорооны дарга, гишүүд, орлогч.

Төрийн тусгай алба: Прокурор, цагдаагийн албан хаагч /цэргийн цагдаа орохгүй/, үндэсний аюулгүй байдлын алба хаагч /хилийн цэрэг, зэвсэгт хүчин орохгүй/, батлан хамгаалах салбар дахь төрөөс бүрэн эрх олгосон байгууллагад ажилладаг мөрдөгч, гааль, татвар, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх алба хаагч, эрүүгийн хэргийн гүйцэтгэх алба, авран хамгаалах албаны алба хаагч зэрэг.

Бүгд Найрамдах Солонгос Улс. Солонгосын цагдаагийн газрын мөрдөн байцаах товчоо (KPIB) - Цагдаагийн алба хаагчдын үйлдсэн ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэг бүхий цагдаагийн байгууллагад харьяалагддаг тусгай алба. БНСУ-д Прокурорын байгууллага нь ХЗЯ-нд, Цагдаагийн байгууллага нь Дотоод хэргийн яаманд харьяалагддаг.

БНСУ-д шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийн мөрдөн шалгах эрх бүхий 2 байгууллага байна.³⁴ Үүнд:

Дээд прокурорын газрын харьяа Мөрдөн байцаах алба: Улсын дээд прокурорын газрын бүтцэд авлигын болон зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий Прокурорын тусгай мөрдөн байцаах алба ажилладаг. Ерөнхий прокурорт шууд харьяалагддаг. Босоо удирдлагын тогтолцоотой, прокурорын мөрдөн байцаах ажиллагааг явуулдаг. Тусгай мөрдөх албаны нэгж нь дүүргийн прокурорын газарт ахлах прокурор, прокурор, тусгай төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй ажилладаг. Дүүргийн прокуророос шилжүүлсэн болон өөрт харьяалуулсан гэмт хэргийг мөрдөн шалгадаг. 1/Олны анхааралд өртсөн авлигын томоохон хэрэг: сайд, засаг дарга нар, үндэсний ассамблейн гишүүдийн хэргийг шалгана. 2/үндэстэн дамнасан корпорацын болон санхүүгийн гэмт хэрэг: томоохон компани, төрийн байгууллагатай холбоотой залилан мэхлэх, хөрөнгө шамшигдуулах зэрэг санхүүгийн том хэргүүд, 3/үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах ба нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг: тагнуул хийх, нууц мэдээл задруулсан, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах дахь авилгын хэрэг, 4/үндэсний баялгийг гадагш гаргах, 5/санхүүгийн болон үнэт цаастай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгадаг.

Өндөр албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах алба: 2021 онд байгуулагдсан. Авлигын болон өндөр албан тушаалтны гэмт хэрэгтэй тэмцэх хараат бус, бие даасан, тусгай байгууллага. Даргыг Ерөнхийлөгч шууд томилдог. Даргад нэр дэвшигчийг тодруулах хороо 7 гишүүнтэй /ХЗсайд, Шүүхийн удирдлагын газрын сайд, Хуульчдын холбооны ерөнхийлөгч, эрх баригч 2 нам, сөрөг хүчний 2 нам/ хамгийн өндөр оноотой 2 хүнээс ерөнхийлөгч томилно. Дарга, дэд дарга, прокурорууд-25 /7 жил ажилласан/, мөрдөн байцаагч -40. Эрх хэмжээ нь: өндөр албан тушаалтнуудын холбогдсон гэмт хэргийг мөрдөн шалгах прокурорын хяналтаас тусдаа бие даан мөрдөх эрхтэй. Бүх төрлийн авилга, шүүх, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын гэмт хэргийг шалгах. Бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч албан тушаалтныг шалгах эрхтэй: ерөнхийлөгч, түүний гэр бүлийн гишүүд, үндэсний ассамблейн гишүүд, шүүгч, прокурор, сайд, цэрэг, цагдаагийн дээд албан тушаалтнууд. Хэргийн харьяалал. Авилга албан тушаалын, эрх мэдлээ урвуулан ашигласан, хууль бус санхүүгийн гүйлгээ, хандив, прокурор, мөрдөгч, шүүгч зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчийн гэмт хэрэг. Цагдаа, прокурор бусад хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах боловч бие даан шийдвэр гаргана. Энэ нь БНСУ-ын хууль сахиулах тогтолцоонд прокурорын байгууллагын хэт төвлөрсөн эрх мэдлийг саармагжуулах, төвийг сахисан шинэ хяналтын байгууллагыг бий болгож, авилгын эсрэг хяналтыг сайжруулах зорилготой байна.

Казакстан Улсад Улсын Ерөнхий Прокурорын газар нь хууль сахиулах үйл ажиллагааны хууль ёсны байдалд хяналт тавьдаг бөгөөд прокурор, цагдаагийн ажилтнуудтай холбоотой хууль бус үйлдлүүдийг шалгадаг, Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний товчоо- Авлига, төрийн албан тушаалтнуудтай холбоотой хэргүүдээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Дотоод хэргийн яамны Дотоод аюулгүй байдлын хэлтэс – цагдаагийн алба хаагчдын хууль бус

³⁴ Мөн тэнд 12 дахь тал

үйлдэл, гэмт хэргийг шалгадаг. **Канад Улсад** Бритиш Колумбын Бие даасан мөрдөн байцаах алба (ИЮ) - Цагдаагийн ажилтнуудын холбогдсон хүнд гэмтэл, хүн амины хэргийг шалгадаг, Онтариогийн Тусгай мөрдөн байцаах алба (SIU) - Цагдаа нартай холбоотой ноцтой гэмтэл, хүн амины хэргийг шалгадаг бие даасан агентлаг, **Норвеги Улсад** Норвегийн цагдаагийн газрын мөрдөн байцаах товчоо (Spesialenheten) - Цагдаагийн ажилтнуудын гаргасан гомдол, гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд, ёс бус үйлдлийн талаарх гомдлыг шалгадаг бие даасан агентлаг, **Дани Улсад** Цагдаагийн асуудал эрхэлсэн тусгай алба (Specialenheden for Politiet) - Данийн үндэсний цагдаагийн газрын харьяа цагдаагийн алба хаагчдын үйлдсэн ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах тусгай алба ажилладаг бол **Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад** Цагдаагийн хариуцлагын бие даасан алба (IOPC) - Англи, Уэльсийн цагдаа нарын хууль бус үйлдлийн талаарх гомдол мэдээллийг шалгадаг, Шүүхийн үйл ажиллагааны мөрдөн байцаалтын алба (JCIO) - Англи, Уэльсийн шүүгчдийн эсрэг ирсэн гомдлыг шалгадаг, Эрхэм дээдсийн цагдаа, гал түймэр, аврах албаны хяналтын газар (HMICFRS) - Цагдаагийн хүчнийг шалгаж, мэдээлдэг бөгөөд хууль бус үйлдлийг илрүүлдэг, Парламентын болон Эрүүл мэндийн албаны Омбудсман - Төрийн үйлчилгээ, цагдаа, шүүхийн үйлчилгээтэй холбоотой гомдлыг шалгадаг, Хуулийн омбудсмен - Хууль зүйн үйлчилгээ үзүүлэгчийн талаарх гомдол, прокурорын зөрчилтэй холбоотой асуудлыг шалгадаг байгууллагууд ажилладаг байна.

Дүгнэвэл: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах албыг хууль сахиулах бусад байгууллагаас тусад нь бие даалган байгуулах нь хэт төвлөрсөн эрх мэдлийг саармагжуулах, төвийг сахисан шинэ хяналтыг бий болгоход чиглэсэн байна. Хамаарах субъектийн хувьд цагдаагийн албан хаагч, төрийн тусгай албан хаагч, төрийн өндөр албан тушаалтнуудыг хамруулсан байна. ОУБ-аас өгсөн зөвлөмжөөс харвал байгууллагын эрх зүйн байдлыг хуулиар тогтоох, бүрэн эрхийг бусад хууль сахиулах байгууллагаас онцлог, тусдаа болохыг заах, хангалттай хэмжээний төсөвтэй, цалинтай байх, цагдаагийн байгууллагаас тусдаа байртай байх, дарга нь Засгийн газрын бүтцэд ажилладаг боловч Парламент, эсхүл түүнтэй ижил байгууллагад тайлагнах, даргаар өмнө нь цагдаагийн алба хашиж байсан хүмүүсээс томилохгүй байх, мөрдөгчид нь цагдаа болон бусад хууль сахиулах байгууллагын ажилтантай ижил бүрэн эрхтэй, цалин нь ижил, эсхүл өндөр байх, тусгай тэмдэг хэрэглэдэг, ялгагдахуйц өөр дүрэмт хувцастай байх шаардлагыг тавьжээ.

---oOo---

ДҮГНЭЛТ

Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулах асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарыг тодорхойлох зорилгоор энэхүү тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13.3, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах алба байгуулах асуудалтай холбогдуулан гэрч, хохирогчоос гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бусад этгээдийг хамгаалалтад авах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг мөн судалгааны хүрээнд авч үзлээ.

1/Гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан байгууллага байгуулах асуудлаар:

Монгол Улс 2013 онд Тахарын албаны тухай хуулийг баталж, гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх анхны бие даасан бүтэц ажиллах эрх зүйн үндэс бүрдүүлж, Тахарын албыг байгуулсан боловч хуулийг 2016 онд хүчингүй болгосноор уг алба татан буугдаж, түүний чиг үүрэг цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, авилгатай тэмцэх газар, тагнуулын байгууллагын үндсэн чиг үүрэг дээр нэмэлт байдлаар хэрэгжихээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулан шилжүүлсэн байна.

Өнөөдрийн байдлаар гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах, шүүхээс оргон зайлсан тохиолдолд тэдгээрийг эрэн сурвалжлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих байр ба шүүх хооронд хуяглан хүргэх чиг үүргийг цагдаагийн байгууллага, ялтныг хуяглан хүргэх, эрэн сурвалжлах, ялтан шилжүүлэх чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар тус бүр харьяалан шалгаж буй хэргийн шаардлагатай гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалахаар хуульд заасан боловч дээрх хоёр байгууллага одоог хүртэл тусгайлсан нэгж, бүтэцгүй, Авлигатай тэмцэх газар нь Цагдаагийн ерөнхий газартай байгуулсан гэрээний үндсэн дээр өөрсдийн харьяалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг цагдаагийн байгууллагаар хамгаалуулж байна.

Цагдаагийн байгууллага нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг давхар хэрэгжүүлэх нь хамгаалуулагчид эрсдэл үүсэх, чиг үүргийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх, үйл ажиллагааг хүртээмжтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж, алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

Түүнчлэн гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хүн хүч, төсөв санхүүгийн хязгаарлагдмал нөөц бүхий цагдаагийн байгууллагад давхар хариуцуулж, холбогдох зардлыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зардлаар шийдвэрлэж ирсэн нь гэрч, хохирогчийг хамгаалах алба бэхжих, алба хаагч тухайн чиглэлээр мэргэших боломжийг хязгаарлаж гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоог үр дүнгүй болгож байна.

Иймд хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллагыг цагдаагийн байгууллагаас тусад нь бие даасан байдлаар олон улсын түршлагыг харгалзан өөрийн орны эрх зүйн тогтолцоо, онцлог, бодит боломждоо тулгуурлан тогтоох нь зүйтэй байна.

2/Шүүн таслах ажиллагаанд оролцогч бусад этгээдийн хамгаалалтад авах асуудлаар:

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зорилго нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалалтад авахаар анх тодорхойлогдсон боловч уг хуульд заасан гэрч, хохирогчоор тогтоогдоогүй этгээд болох хүний эрх хамгаалагч, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, мөн гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх зэргээр туслалцаа үзүүлсэн хүн-мэдээлэгчийг хамгаалалтад авахаар тусгажээ. Ийнхүү эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралгүй этгээдүүдийг хуульд хамааруулсан нь нийгмийн хэрэгцээ шаардлагаас үүссэн бөгөөд цаашид уг хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх шаардлагыг үүсгэж байна.

Судлагдсан улс орны туршлагаас харахад хамгаалалтад авах этгээдийг нэг бүрчлэн нэрлэн заасан, эсхүл гэмт хэргийн төрлөөс хамааран, эсхүл үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээнээс хамааран хамгаалалтад авахаар зохицуулжээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх нэг гол хүчин зүйл нь гэрч, хохирогчоос гадна шүүх хуралдаанд оролцогч бусад этгээд хамгаалагдсан байх явдал юм.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бүх этгээдийг хамгаалалтад авах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

3/Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулах асуудлаар:

Манай улс анх Засгийн газрын 1992 оны 101 тоот тогтоолоор Улсын мөрдөн байцаах газрыг байгуулж, бүтцэд нь цэрэг, цагдаагийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийг шалгах үүрэг бүхий хэлтсийг байгуулж байсан бөгөөд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27.2 дахь хэсэгт "Прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах алба нь цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна" гэж заасны дагуу Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг шинээр байгуулсан боловч 2014 онд татан буулгаж, чиг үүргийг авилгатай тэмцэх болон цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын бүтцэд Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс ажиллаж байна.

Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан харъяалал тогтоох журмын дагуу шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагч, авлигатай тэмцэх байгууллага болон тагнуулын байгууллагын албан хаагчийн үйлдсэн хэрэгт Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тус тус өөрсдийн харьяаллын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Хуулиар тогтоосон харьяаллаар тагнуул, авилгатай тэмцэх байгууллагын харьяаллын хэргээс бусад хэрэгт цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар зохицуулсан бөгөөд тусгай субъект болох тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг Улсын ерөнхий прокурор тогтоохоор заасан байна.

Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын албан хаагчид харилцан бие биенээ шалгах зохицуулалттай байгаа нь нөлөөнд автах, хэрэг шударгаар шийдвэрлэгдэхэд эргэлзээтэй байх, эрх мэдлийн төвлөрлийг бий болгох, цагдаагийн албан хаагчийг цагдаагийн алба нь шалгаж байгаа нь ял завших боломжийг олгох эрсдэлтэй, цагдааг цагдаа нь шалгадаг гэсэн хэл аманд байнга өртдөг. /Судалгаанаас үзвэл цагдаагийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэг нийт хэргийн 95 орчим хувийг эзэлж байна./

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал алдагдаж, шударга ёс, хяналт хязгаарлагдах, иргэдийн эрх ашиг зөрчигдөх, шүүгдэгч ял завших, иргэдийн төрийн албан хаагчид, шүүхэд итгэх итгэл алдагдах зэрэг сөрөг үр нөлөөтэй байна.

Төрийн албан хаагчийн эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан үйлдлийг мөрдөн шалгаж байгаа одоогийн бүтэц нь олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон бие даасан, хараат бус байх шаардлагад нийцээгүй, мөрдөн шалгах ажиллагааны бие даасан байдал алдагдахад хүргэж, үр дүнтэй хяналтыг бий болгохгүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах үр дүнтэй, хараат бус тогтолцоо бүрдүүлэх, тухайлбал: төрийн албан хаагчийн, ялангуяа цагдаагийн албан хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, бие даасан байгууллагыг байгуулах, мөрдөн шалгалтыг хараат бусаар, алагчлалгүй, үр дүнтэй, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх талаар олон улсын байгууллагын зөвлөмжүүдэд мөн дурдсан байна

Манай улсын хувьд гэрч, хохирогчийг хамгаалах, тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааны хараат бус байх олон улсын хүлээн зөвшөөрсөн зарчим алдагдсан.

Судалгааны үр дүнд гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах үр нөлөөтэй шинэ бүтэц бий болгож, чиг үүргийг бие даасан, алба, бүрэлдэхүүнд хариуцуулах шаардлагатай гэсэн нөхцөл байдлын дүгнэлт гарч байна.

Дүгнэвэл: Асуудлыг тодорхойлохдоо дээрх хоёр чиг үүргийг тус бүрд нь авч үзэж, тус бүрийн эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдал, практик хэрэгжилт, олон улсын туршлага зэргийг судалж, аргачлалын 5.7 дахь хэсэгт заасан шалгуурын дагуу өргөн хүрээнд сонгосон зохицуулалтын хувилбаруудыг гаргаж, үр нөлөөг үнэлсний үндсэн дээр тухайн харилцааны онцлогтой холбоотойгоор “хуулийн төсөл боловсруулах” замаар зорилгодоо хүрэх нь хамгийн үр ашигтай хувилбар гэж үзсэн бөгөөд асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал нь аргачлалын 5.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгох нөхцөлийг мөн хангасан тул асуудлыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх нэгдсэн дүгнэлтэд хүрч байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Даалгаварт заасан асуудлыг судлаад хуулийн төсөл боловсруулах замаар асуудлыг шийдвэрлэх нэгдсэн дүгнэлт гарсан тул судлаачийн зүгээс дараах зөвлөмжийг санал болгож байна:

1/Гэрч, хохирогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий бие даасан алба байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх

Бие даасан алба байгуулах асуудлыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар, эсхүл уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах замаар, эсхүл бие даасан анхдагч хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой байгаагаас дараах үндэслэлээр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахаар сонголоо.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд зөвхөн “алба” байгуулах асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах нь гэрч хохирогчийг хамгаалах бие даасан албатай болох зорилгыг хангах боловч судалгааны явцад авагдсан баримт, мэдээлэл, тайлан, судалгааны материалууд, судлаачдын өгсөн дүгнэлт, зөвлөмжүүд, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, туршлага зэргээс үзэхэд уг хуулийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох чиглэлээр зарим өөрчлөлтийг оруулах, төрөөс хүний эрхийг хангах, төрийн үйлчилгээ үр ашигтай байх бодлого, зарчимд нийцүүлэн уг хуулиар зохицуулж байгаа харилцааг бүхэлд нь авч үзэж хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд оруулах энэ удаагийн өөрчлөлт нь хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн, тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны агуулгад багагүй өөрчлөлт гарч байгаа, мөн уг хуулийн 50-иас дээш хувьд өөрчлөлт орохоор байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийг шинэчлэн найруулах шаардлагыг хангаж байна.

2/Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий бие даасан алба байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх

Судалгааны дүгнэлт болон олон улсын зөвлөмжөөр тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах албыг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий бусад албанаас тусад нь бие даасан байдлаар байгуулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.

Харин уг алба төрийн ямар субъектийн эрх хэмжээнд хамаарах асуудал дээр тандан судалгааны хүрээнд боловсруулсан хуулийн төслийн эхний хувилбарыг танилцуулах үед оролцогчид ихээхэн анхаарал хандуулсан бөгөөд эрх бүхий байгууллагуудын төлөөллүүд өөр өөр байр суурьтай байгаа нь ажиглагдсан.

Манай орны хувьд тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах албыг Улсын ерөнхий прокурорын эрх хэмжээний хүрээнд Улсын ерөнхий прокурорын дэргэд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрх хэмжээний хүрээнд цагдаагийн албаны бүтцэд хэрэгжүүлж байсан туршлагатай.

Энэ нь тухайн албаны бие даасан, хараат бус байх, үр дүнтэй хяналтыг бий болгох тал дээр учир дутагдалтай бөгөөд эрх мэдлийн төвлөрлийг бий болгосон гэж дүгнэгдсэн.

Иймд улс орны эрх зүйн зохицуулалт, бодит нөхцөл байдал, асуудлын мөн чанарыг анхаарч үзэх нь зүйтэй байна.

Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг нь хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагаас чиг үүрэг, үйл ажиллагааны хувьд ялгаатай боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах зорилгын нэг бүрэлдэхүүн хэсэгт зүй ёсоор тооцогдох юм.

Гэрч, хохирогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бусад этгээдийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах үндсэн зорилготой бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх Засгийн газрын бүрэн эрхэд хамаарч байна.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцож байгаа тусгай субъект болох шүүгч, прокурор болон авилгатай тэмцэх газар, тагнуул, цагдаагийн байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий албыг манай орны нөхцөлд гэрч, хохирогчийг хамгаалах байгууллагын дэргэд байгуулах боломжтой гэсэн хувилбараар боловсруулсан хуулийн төслийг судлаачийн зүгээс санал болгож байна.

Санал болгож байгаа хуулийн төслөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах зорилгыг тавьж хуулийн нэрийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай гэж өөрчилсөн болно.

Энэхүү хувилбар нь манай орны нөхцөлд эрх зүйн болон бодит байдлын хувьд хамгийн боломжит хувилбар бөгөөд цаашид төсвийн хүндрэл, хүний нөөц, чиг үүргийн уялдаа холбоо, давхардлыг арилгаж, зохих тогтолцоо бүрдэж, төлөвшсөнөөр эрх зүйн орчныг тухайн нөхцөл байдалд тулгуурлан өөрчлөх боломжтой юм.

3/Хууль батлахтай холбогдуулан зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авах

Сонгосон хувилбарыг хэрэгжүүлснээр шинээр төрийн байгууллага байгуулах бөгөөд эдийн засгийн хувьд одоо хэрэгжиж байгаа бүтэц, хүний нөөцийг холбогдох төсвийн хамт шилжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой тул зардлыг тодорхой хэмжээгээр бууруулж, улсын төсөвт өгөх ачаалал харьцангуй бага, захиргааны зардал, хүний нөөцийн зардлын хувьд тодорхой хэмнэлтийг бий болгоно.

Гэвч үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд тодорхой зардал гарах боловч хариуцсан төрийн байгууллагын хувьд үйл явц, зардлын хуваарилалт зорилгодоо чиглэсэн, илүү үр ашигтай болно.

Орон нутагт салбарууд байгуулагдаж ажлын байрыг шинээр бий болгох, нөгөө талд ажлын байр багасгах нөлөө үзүүлнэ. Мөн шинээр үйл ажиллагааны болон захиргааны зардал үүснэ. Гэвч энэ нь өмнө нь тухайн чиг үүргийг хэрэгжүүлж байсан байгууллагуудын үйл ажиллагааны болон захиргааны зардлыг бууруулж, ачааллыг багасгана.

Хуулийн дагуу шинэ байгууллага байгуулахад төсөв, санхүүгийн зохих хэмжээний зардал гарах боловч асуудлыг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй эерэг нөлөө үзүүлж, хүний эрхийг хамгаалах хараат бус, бие даасан тогтолцоо бүрдэж, үйл ажиллагаа нь бэхжиж, төрийн үйлчилгээ үр ашигтай байх зарчим хангагдах юм.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын тайлан, зөвлөмжийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.

Энэхүү дүгнэлтийн хамт хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагаж гарах хуулиудын төслүүдийг боловсруулан хавсралтаар хүргүүлэв.

Хуулийн төслийг зөвхөн зөвлөмжид дурдсан хүрээгээр хязгаарлалгүй бүхэлд нь авч үзэж шинэчлэн найруулсан болно. Хуулийг дагаж гарах 16 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, 1 УИХ-ын тогтоолын төсөл боловсруулав.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хавсралт 2-оос, хуулийн төслийг хавсралт 3-аас, дагаж гарах хууль тогтоомжийн төслийг хавсралт 4-өөс үзнэ үү.

---o0o---

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

1/“Хохирогчийн эрхийн судалгааны төв”ТББ, “Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал” судалгааны тайлан, 2010 он;

2/Хууль сахиулахын их сургууль, “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шатанд прокурор, цагдаа, гааль, тагнуулын байгууллагын харилцан уялдаа, түүний онцлог” судалгааны тайлан, 2013 он;

3/ОХУ-ын “Эрүүгийн шүүн таслах ажиллагаан дахь гэрч, хохирогч болон бусад этгээдийн төрийн хамгаалалтын тухай” Холбооны хууль;

4/ Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа 2022 он;

5/Хууль зүйн Үндэсний хүрээлэн. “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлан;

6/ News.mn, “Тахарыг үлдээх таван үндэслэл”, Холбоос: <https://news.mn/r/742689/>;

7/Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, холбоос: <https://legaldata.mn/b/1243/>;

8/ “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бүс, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” хэлэлцүүлэг, ЦЕГ-ын МБА-ны дарга, П.Очбадрах, “Хүний эрхийн зөрчил, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ” илтгэл;

9/<https://legaldata.mn/b/731> Б.Батзориг.Шүүх засаглалын аюулгүй байдлыг хангаж байгаа гадаад орны туршлага 2020.8.11;

10/ Парламентийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, “Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллын талаарх харьцуулсан судалгаа”;

11/Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хувийн хэрэг;

12/Тахарын албаны тухай хуулийн хувийн хэрэг.

13/ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Шүүхийн аюулгүй байдлыг хангах хэлтэс, Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтсийн 2016-2024 оны үйл ажиллагааны тайлан.

14/<http://legalinfo.mn>

15/www.usmarshals.gov

16/www.consultant.ru

17/ <http://gongbao.court.gov.cn/details/9cb05785bb151f791c1634ed0d1b0b.html>;

18/ <https://cdn.greensoft.mn/uploads/users/3172/files/ATG-report-2023.pdf>, [ATG-report-2023.pdf](#);

19/https://cdn.greensoft.mn/uploads/users/3172/files/ATG%20report_2024%20ful%20revised.pdf;

Хууль тогтоомжийн жагсаалт:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль
- Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002 он
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
- Прокурорын байгууллагын тухай хууль 2002 он
- Прокурорын тухай хууль 2017 он
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
- Тахарын албаны тухай хууль 2013 он
- Авилгын эсрэг хууль 2006 он
- Гүйцэтгэх ажлын тухай хууль 1997 он
- Цагдаагийн албаны тухай хууль 2013 он
- Цагдаагийн албаны тухай хууль 2017 он
- Монгол Улсын шүүхийн тухай хууль 2021 он
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Төрийн албаны тухай хууль

- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль г.м.

---oOo---

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 1

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	
3.Эрх агуулагч Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	

олон улсын гэрээ, Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг агуулж байгаа бөгөөд эрхээ хэрэгжүүлэхийг шаардах эрх бүхий этгээдийг ойлгоно.	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	
4.Үүрэг хүлээгч Үүрэг хүлээгч гэдэгт хүний эрхийг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг хүлээсэн этгээд, анхдагч үүрэг хүлээсэн этгээд бол төрийг ойлгоно.	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 2

Үзүүлэх үр нөлөө		Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
		Тийм	Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	

	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	

8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө		Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

Хүснэгт 4

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр		Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	

3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	

Аргачлалын 6.3-т заасны дагуу үр нөлөөний үнэлгээний асуултуудад ерөнхий байдлаар “Тийм”, “Үгүй” гэж хариуллаа.

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

О.АЛТАНГЭРЭЛ

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага 1.1.Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 2-т “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь ...хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө гэж тус тус тогтоосон.

Монгол улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлд заасан “Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах”, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1985 онд баталсан “Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчмын тухай” тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”, мөн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 13 дугаар зүйлд заасан “Оролцогч улс түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авах” үүргийг тус тус манай улс хүлээж байна.

Түүнчлэн НҮБ-ын Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1985 онд баталсан Шүүхийн бие даасан байдлын талаарх үндсэн зарчмын 2-т “Шүүх аливаа хэргийг хэний ч нөлөөнд авталгүйгээр, сэтгэл хөдлөл, дарамт шахалт, сүрдүүлэггүйгээр шийдвэрлэх.”-ийг, 7-д “Гишүүн улсын үүрэг нь шүүх эрх мэдлийг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэрэгслээр хангах” шаардлагатайг тодорхойлсон.

Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.4.1-д “Салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлнэ.” гэж, 7.3.9-д “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, ...хэрэгжүүлнэ.” гэж тус тус зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 357 дугаар тогтоолоор баталсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний 1-8 дугаар зөвлөмжийн дагуу эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, хараат бусаар мөрдөн шалгах бие даасан нэгжийг байгуулах, бүтэц, орон тоо, төсвийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн яамд, мөн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолын 1.4.б-д эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулахыг Засгийн газарт тус тус даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.14-т “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргах” гэж, 4.1.1.14-т “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээ авна.” гэж тус тус төлөвлөсөн.

1.2. Практик шаардлага

Нийгмийн аюулын шинжээрээ ноцтой хор уршиг, хохирол учруулах, зохион байгуулалттай гэмт хэрэг улам боловсронгуй болж буй энэ цаг мөчид хэргийг шударгаар шалгах, шийдвэрлэх эрх зүйн баталгааг тодорхойлох, аюулгүй байдал нь халдлага, заналхийлэлд өртөж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд албан үүргийн хувиар болон эрх зүйн байдлын хүрээнд оролцогчдыг хамгаалах үр дүнтэй механизмыг бүрдүүлэх нь зөвхөн манай улсын төдийгүй олон улсын анхаарлыг татсан асуудал болсоор байна.

Монгол Улс анх 2014 онд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, яллагдагч, гэрчийг шүүх хуралдаанд албадан ирүүлэх, ялтан шилжүүлэх, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий бие даасан албыг байгуулсан боловч 2016 онд Улсын Их Хурлаас Тахарын албаны тухай хуулийг хүчингүй болгосноор уг чиг үүргийг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлсэн.

Өнөөдөр цагдаагийн байгууллага гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх, оргон зайлсан яллагдагчийг эрэн сурвалжлах ажиллагааг, харин ялтныг хуяглан хүргэх, эрэн сурвалжлах, ялтан шилжүүлэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу улсын хэмжээнд Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар харьяалан шалгаж буй хэргийн шаардлагатай гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалахаар зохицуулсан боловч дээрх хоёр байгууллага одоог хүртэл тусгайлсан алба байгуулаагүй, Авлигатай тэмцэх газар нь

Цагдаагийн ерөнхий газартай байгуулсан гэрээний үндсэн дээр өөрсдийн хамгаалалтад авах гэрч, хохирогчийг хамгаалуулж байна.

Цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд зохион байгуулалтын хувьд хэлтсийн түвшинд дээрх чиг үүргийг гүйцэтгэж байгаа боловч жил тутам өсч байгаа гэмт хэргийн гаралт, эрүүгийн нөхцөл байдлын улмаас арга хэмжээг хүртээмжтэй, аюулгүй хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байгааг дараах тоон мэдээллээс дүгнэж болохоор байна. Тухайлбал:

Монгол Улсын хэмжээнд 2016 онд 27167 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2023 онд 35574 болж өссөн. Энэ нь хамгаалах шаардлагатай гэрч, хохирогчийн тоог өсөхөд шууд нөлөөлж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээгээр 2016 онд 33 тохиолдлоор 42 хүнийг, 2024 онд 116 хүнийг хамгаалсан бөгөөд 2016-2024 онд нийт 1134 иргэнд 1118 хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Шүүхийн байранд шалган нэвтрүүлэх ажиллагаа 2016 онд 185081 байсан бол 2023 онд 394271 удаа, шүүх хуралдааны дэг журам сахиулах чиглэлээр 2016 онд 51769 ажиллагаа хийсэн бол 2023 онд 457684 болж 9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2016 онд тахарын алба 800 гаруй хүний орон тоотой ажиллаж байсан бол 2024 онд цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тахарын албаны чиг үүргийн хүрээнд 417 алба хаагч ажиллаж байна.

Нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг давхар хэрэгжүүлэх нь зарим хүндрэлийг үүсгэж байна. Тухайлбал:

-үйл ажиллагаа, төсөв санхүүгийн хувьд бие даасан бус байгаа нь хамгаалалтын арга хэмжээг нууцлалын аюулгүй байдал хангасан, шуурхай, хүртээмжтэй хэрэгжүүлэх шаардлагад нийцдэггүй, хүний нөөцийн хүрэлцээгүй байдал нь гэрч, хохирогчийг хамгаалалт, шүүхэд аюулгүй байдал алдагдах нөхцлийг үүсгэж байгаагын зэрэгцээ алба хаагчдын хувьд хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан эрх нь зөрчигдөх шалтгаан болж байна.

-хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангахад заналхийлэгч этгээд, түүний үйлдлийг тал бүрээс нь, бүрэн тодорхойлох шаардлагатай боловч эрх зүйн орчны зохицуулалтгүйн улмаас хүндрэл үүсдэг, хамгаалалтын арга хэмжээнд оролцох үүрэг бүхий байгууллагуудын чиг үүрэг, оролцооны талаарх зохицуулалт тодорхойгүй байгаагаас ажлын уялдаа холбоо, хамтран ажиллах хэлбэр ойлгомжгүй байдаг.

-гэрч, хохирогчийг аюулгүй газарт байрлуулах хамгаалах байргүйгээс төрийн бус байгууллагын байранд түр байрлуулдаг, тэдгээр нь мөн зорилтот бүлгийн иргэдийг авах шаардлага тавьдаг нь хүндрэл үүсгэдэг.

-хамгаалалтын арга хэмжээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, шүүгдэгч, ялтан оргон зайлсан тохиолдолд арга хэмжээг авах чадамж бүхий мэргэшсэн тусгай алба, албан хаагчтай байх шаардлага үүсэж байна.

Мөн гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах бие даасан хараат бус бүтцийг бүрдүүлээгүй, цагдаагийн албаны бүтцэд байгаа нь зарим судлаачдын болон олон улсын байгууллагын зүгээс шүүмжлэлд өртсөөр байна.

Иймд гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог системээр нь эргэн харж, цаашид уг тогтолцоог зохих ёсоор олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Гэрч хохирогчийг хамгаалах тухай батлагдсанаас хойш 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд эдгээрээс 1 нь бие даасан, 4 нь бусад хууль батлагдсантай холбогдуулан оруулсан нэмэлт, өөрчлөлт бөгөөд уг хуулийн 28 зүйлийн 22 зүйлд нь буюу хуулийн 78 хувьд нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд: “25.1.1.өмнө нь тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон, 25.1.2.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна.” гэж заасны дагуу 2013 онд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулж, хуулийн нэрийг хуулиар зохицуулах харилцааны ерөнхий агуулгаар “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж өөрчилнө.

1.2.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба байгуулах асуудлаар

Аливаа хүн хэн байхаас үл хамаарч эрүү шүүлт болон хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрх нь Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын эрх зүйн дагуу ямарч нөхцөлд хязгаарлаж үл болох онцгой эрх юм. Эрүүдэн шүүх гэмт хэргийг тодорхой эрх мэдэл бүхий этгээдийн зүгээс үйлддэг тул энэ төрлийн гомдол мэдээллийг хараат бусаар шуурхай мөрдөн шалгаж шийдвэрлэх нь эрүү шүүлтээс ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй.

Гэрч, хохирогчид зөвхөн хэрэгт шалгагдаж буй талаас нөлөөлөх, халдах, дарамтлах үйлдэл ирдэггүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох эрх бүхий этгээдүүдийн зүгээс ч мөн тэдэнд нөлөөлж хэргийн шийдвэрлэлтэд хууль бусаар нөлөөлөх үйлдэл гардаг.

Манай улс анх Засгийн газрын 1992 оны 101 тоот тогтоолоор Улсын мөрдөн байцаах газрыг байгуулж, бүтцэд нь цэрэг, цагдаагийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийг шалгах үүрэг бүхий хэлтсийг байгуулсан. Улмаар 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27.2 дахь хэсэгт “Прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах алба нь цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна” гэж заасны дагуу Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг шинээр байгуулсан боловч 2014 онд татан буулгаж, чиг үүргийг авилгатай тэмцэх болон цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтоохоор хуульчилсан боловч мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд харилцан бие биенээ шалгах зохицуулалттай байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг ашиг сонирхолын зөрчилгүй шалгагдаж, шударгаар шийдвэрлэгдэх нөхцлийг бүрдүүлсэн зохицуулалт болсон гэж дүгнэх боломжгүй юм.

Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 3-р илтгэлийг хэлэлцүүлсний мөрөөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 50 дугаар чуулганаас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр ирүүлсэн зөвлөмжийн дийлэнх нь хууль тогтоомжийн хүрээнд эрүү шүүлтийн талаарх гомдлыг хараат бусаар, шуурхай мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэхийг онцгойлон зөвлөсөн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2001-2025 оны хооронд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх нийт 24 удаагийн илтгэлийг гаргасан бөгөөд тэдгээрээс 9 удаагийн илтгэлд эрүүдэн шүүлтийн асуудлыг хөндсөн байна. Тус комиссын 2019 оны 18 дугаар илтгэлийн дагуу Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар өгсөн саналын 15-д “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан байгууллагыг нэн даруй байгуулах”-ыг заасан боловч одоогоор холбогдох байгууллагыг байгуулаагүй байна.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс шийдвэр гарган оролцож буй шүүгч, прокурор болон авилгатай тэмцэх газар, тагнуул, цагдаагийн байгууллагын алба хаагч нарын үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий албыг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах албаны дэргэд байгуулахаар хуулийн төсөлд тусгана.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий алба нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах албанаас чиг үүрэг, үйл ажиллагааны хувьд ялгаатай боловч тусгай субьектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг аюулгүй явуулах үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэ нь мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагуудаас хараат бусаар ашиг сонирхлын зөрчилгүйгээр, шударгаар мөрдөн шалгах, илрүүлэх боломжийг бүрдүүлэх, хүний халдашгүй чөлөөтэй байх туйлын эрх хангагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа аюулгүй хэвийн явагдах, хэрэг шударгаар шийдвэрлэгдэх байдалд дэвшил гаргах зохицуулалт болно гэж үзэж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд оруулах энэ удаагийн шинэчлэл нь хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн, тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны агуулгад багагүй өөрчлөлт гарч байгаа, мөн уг хуулийн 50-иас дээш хувьд өөрчлөлт орохоор байгаа тул хуулийг шинэчлэн найруулах бөгөөд хуулийн нэрийг өргөн утгаар нь Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах өргөн агуулгаар нь нэрлэх нь зүйтэй байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэ хуулиар хүний эрхийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрч, хохирогч, шүүгч, прокурор гэх мэт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг хамгаалах, шүүхийн байгууллагын аюулгүй байдлыг хангах, хэрэгтнийг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтан, холбогдогчийг эрэн сурвалжлах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохын зэрэгцээ дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, албан хаагчийн эрх зүйн байдлыг

тогтоохоос гадна дэргэдээ тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөх албатай байх зохицуулалтыг тусгана.

Хуулийн төсөл дараахь агуулгатай байна:

1/төслийн нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилт, нэр томьёоны тодорхойлолт, үйл ажиллагааны зарчим, зэрэг хуулийн ерөнхий зохицуулалтыг тусгана.

2/Хамгаалалтын арга хэмжээ, түүний төрөл, хамгаалуулах эрх бүхий этгээд, хамгаалуулагчийн эрх, үүрэг, хамгаалалт хэрэгжүүлэх шийдвэр гаргах журам, дүгнэлт гарагх журам, аюулын эрсдлийн түвшин, түүнийг үнэлэх, хамгаалалтыг хэрэгжүүлэх, цуцлах, хяналтын хэрэг бүрдүүлэх, хамгаалалтын арга хэмжээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар зэрэг хамгаалалтын арга хэмжээний хэрэгжүүлэх процессыг журамлана.

3/шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагаа, шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны дэг сахиулах, гэрч, зохигч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, хуяглан хүргэх тусгай ажилтан, түүнийг гүйцэтгэх үүргийг нарийвчлан заана.

4/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын алба, тогтолцоо, чиг үүрэг, бүтэц, аюулгүй байдлын төв байгууллагын чиг үүргийг тодорхойлно.

5/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны алба хаагчийн эрх зүйн байдал, албан тушаалд тавигдах шаардлага, албаны тангараг, албаны дарга, дэд даргыг томилох, чөлөөлөх, огцруулах, даргын бүрэн эрх, алба хаагчийг томилох, алба хаагчийн эрх, үүрэг, дүрэмт хувцас, таних тэмдэг, ажиллах баталгаа, нөхөн олговор, тэтгэмж зэрэг албан хаагчдын эрх зүйн байдалтай холбогдох зохицуулалтыг тусгана.

6/тусгай субъект буюу шүүгч, прокурор, цагдаа, авилгатай тэмцэх байгууллага, тагнуулын байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах бүтэц, үйл ажиллагааны бие даасан байдлыг тусгайлан зохицуулна.

7/Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд тавих хяналт, үйл ажиллагаанд гомдол гаргах, албаны мэдээллийн сан зэрэг бусад зохицуулалтыг тусгана.

8/Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг хамгаалалтад авах нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүх ажиллагааг аюулгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангахад чухал ач холбогдолтой.

Хамгаалалтад авах субъектийн хүрээ өргөжиж, хүний эрхийг өргөн хүрээнд хамгаалах боломж бүрдэнэ.

Хүний эрхийг хангасан гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ.

Хүний эрхийг хамгаалах чиглэлээр олон улсын сайн туршлага нэвтэрч, энэ чиглэлээр гадаад, дотоодын байгууллагын олон талт хамтын ажиллагаа өргөжнө.

Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах бие даасан, хараат бус тогтолцоо бүрдснээр хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, эрх чөлөөг баталгаажуулах, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд ахиц гарна.

Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн болон олон улсын байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмжийн биелэлт хангагдана.

Хуулийн төслийн дагуу байгуулагдах шинэ бүтцийг байгуулах, бэхжүүлэхэд хүний нөөцийн болон төсөв, санхүүгийн нэлээд зардал гарах боловч одоо хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны зардал, бүтэц, орон тоо, алба хаагчдыг шилжүүлэх замаар шийдвэрлэснээр зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан 2013 онд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах бөгөөд хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотой зарим хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах зорилгоор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах албаны эрх зүйн үндэс, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж

2.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль болон тэдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."хамгаалуулагч" гэж энэ хуульд заасны дагуу эрх бүхий этгээдийн шийдвэрээр аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалтад авсан хүнийг;

3.1.2."хамгаалалтын арга хэмжээ" гэж энэ хуулийн 19.1-д заасан хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэмжээг;

3.1.3."шүүх хуралдааны дэг сахиулах" гэж шүүх хуралдааныг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхийг;

3.1.4."хуяглан харгалзах" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр харуул хамгаалалтыг гүйцэтгэх ажиллагааг;

3.1.5."хуяглан хүргэх" гэж яллагдагч, шүүгдэгч, ялтныг нэг объектоос нөгөө объектод харуул хамгаалалтын хяналт дор явганаар болон тээврийн хэрэгсэл ашиглаж хүргэхийг;

3.1.6."эрэн сурвалжлах" гэж оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтан, шүүхээс даалгасан хэргийн оролцогч, зохигчийг олж тогтоож, харьяалах байгууллагад хүргэх үйл ажиллагааг;

3.1.7. "албадан ирүүлэх" гэж шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн бусад оролцогчийг албадан ирүүлэх ажиллагааг.

3.1.8."тусгай субъект" гэж шүүгч, прокурор болон цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх, шүүх шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг;

3.1.9."хүний эрх хамгаалагч" гэж Хүний эрх хамгаалагчийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;

3.1.10."мэдээлэгч" гэж гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүнийг;

3.1.11."эрх бүхий албан тушаалтан" гэж хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх санал гаргах мөрдөгч, прокурор, шийдвэр гаргах шүүгчийг;

3.1.12."хяналтын хэрэг" гэж хамгаалалтын арга хэмжээний явцад бүрдүүлсэн баримт бичгийн бүрдлийг;

3.1.13."хамаарал бүхий этгээд гэж" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасан этгээдийг;

3.1.14."гэр бүлийн гишүүн" гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан хүнийг;

3.1.15."шүүхийн аюулгүй байдал" гэж шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, шүүхийн харуул хамгаалалт, барилга байгууламж, түүний орчны аюулгүй байдлыг;

3.1.16."шүүхийн барилга, байгууламж" гэж бүх шатны шүүхийн байр, шүүх хуралдаан хийх шүүхийн байрнаас бусад газар, шүүхийн тусгай архивын байрыг.

4 дүгээр бүлэг.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим

4.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

4.1.2.хууль дээдлэх;

4.1.3.шуурхай байх;

- 4.1.4.оновчтой, үр ашигтай байх;
- 4.1.5.нууцлалыг хамгаалах;
- 4.1.6.хараат бус, бие даасан байх;
- 4.1.7.хамтран ажиллах;
- 4.1.8.харилцан хариуцлагатай байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ, ТУСЛАЛЦАА

5 дугаар зүйл.Хамгаалалт

5.1.Энэ хуульд заасан хамгаалалт нь хамгаалалтын арга хэмжээ болон туслалцаанаас бүрдэнэ.

6 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээний төрөл

6.1.Хамгаалалтын арга хэмжээ дараах төрөлтэй байна:

- 6.1.1.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;
- 6.1.2.сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

7 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:

- 7.1.1.урьдчилан сануулах;
- 7.1.2.тодорхой үйлдл ийг хязгаарлах;
- 7.1.3.биечилсэн хамгаалалт;
- 7.1.4.мэдээллийн нууцлалыг хангах;
- 7.1.5.нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;
- 7.1.6.аюулгүй газарт түр байрлуулах;
- 7.1.7.нүүлгэн шилжүүлэх;
- 7.1.8.баримт бичгийг солих;
- 7.1.9.гадаад төрхийг өөрчлөх.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг аюулын эрсдлийн үнэлгээг үндэслэн дангаар болон хамтатган хэрэглэж болно.

8 дугаар зүйл.Урьдчилан сануулах

8.1.Хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд халдахаар заналхийлбэл тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

8.2.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед мөрдөгч, прокурорын хяналтын үед прокурор, хэрэг шүүхэд шилжсэн тохиолдолд шүүгч тус тус урьдчилан сануулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.3.Эрх бүхий албан тушаалтан урьдчилан сануулах арга хэмжээг хэрэгжүүлсэн тухай хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагад мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл.Тодорхой үйлдлийг хязгаарлах

9.1.Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хамгаалуулагчтай уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.

9.2.Хэргийн нөхцөл байдал, аюулын эрсдлийн үнэлгээнээс хамаарч хамгаалуулагчид хамгаалалтын арга хэмжээнд эрсдэл учруулж болохуйц тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээг авч болно.

9.3.Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авахуулсан этгээдээр гарын үсэг зуруулж, түүнд хяналт тавина.

9.4.Энэ хуулийн 9.3-т заасан гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд энэ тухай тэмдэглэлд тусгаж, шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.

9.5.Энэ хуулийн 9.3-т заасны дагуу гарын үсэг зурахаас татгалзсан, хязгаарласан үйлдлийг үйлдсэн нь хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх, түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.6.Хамгаалуулагч нь тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ зөрчигдсөн аливаа үйлдлийг хамгаалагч талд мэдэгдэх бөгөөд бусад этгээдийг гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэхэд өдөөн хатгах, турхирах байдал үүсгэхгүй байх үүрэгтэй.

9.7.Хамгаалуулагч энэ хуулийн 9.6-д заасан үүргээ санаатайгаар зөрчсөн нь хамгаалалтын арга хэмжээг цуцлах үндэслэл болно.

10 дугаар зүйл.Биечилсэн хамгаалалт

10.1.Хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.

10.3.Биечилсэн хамгаалалтын үед хамгаалагч нь хамгаалуулагчийг биечлэн дагаж хамгаалах бөгөөд арга хэмжээг тодорхой хугацаанд дараах хэлбэрээр зохион байгуулна:

10.3.1.тодорхой чиглэл, орчинд хамгаалуулагч хөдөлгөөн үйлдэх үед илээр;

10.3.2.бусад этгээдэд мэдэгдэхгүйгээр хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа газар, орчин, хөдөлгөөн үйлдэх чиглэлд далд хэлбэрээр.

10.4.Биечилсэн хамгаалалтыг эрсдэлийн түвшин, хамрах хүрээ, хүч хэрэгсэл, нөхцөл байдлаас шалтгаалан дараах зэрэглэлээр тогтооно:

10.4.1.энэ хуулийн 25.1.1-д заасан аюулын эрсдэлийн өндөр түвшин тогтоогдсон үед 24 цагаар нэгдүгээр зэргийн хамгаалалтыг;

10.4.2.энэ хуулийн 25.1.2-т заасан аюулын эрсдэлийн дунд түвшин тогтоогдсон үед хоёрдугаар зэрэглэлийн хамгаалалтыг 24 цагаар, эсхүл тодорхой хугацаанд;

10.4.3.энэ хуулийн 25.1.3-т заасан аюулын эрсдэлийн бага түвшин тогтоогдсон үед гуравдугаар зэрэглэлийн хамгаалалтыг тодорхой хугацаанд.

10.5.Энэ хуулийн 25.1.1-д заасан түвшин тогтоогдсон тохиолдолд хамгаалуулагчийг шууд хамгаалалтад авч, шүүхэд нэн даруй мэдэгдэнэ.

10.6.Хамгаалагч нь биечилсэн хамгаалалтын үед хамгаалуулагчийн байнга болон түр оршин суудаг объектэд гадны хүн нэвтрүүлэх, тэдэнтэй уулзуулах, хувийн харилцаа тогтоох, хувийн мэдээллийг бусдад дамжуулахыг хориглоно.

11 дүгээр зүйл.Мэдээллийн нууцлалыг хангах

11.1.Хамгаалуулагчийн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан мэдээллийн нууцлал, мэдээлэлд өөрчлөлт оруулах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг мэдээлэл хариуцагч хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

11.2.Хамгаалуулагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, боловсролын байгууллага дахь иргэний мэдээлэл, харилцах утасны дугаар, цахим хаяг болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах, шаардлагатай бол тэдгээрийг өөрчлөх, зохиомол нэр өгөх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран авна.

11.3.Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн хамгаалуулагчийн болон хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээлэлтэй холбоотой цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах техник, технологийн арга хэмжээг авч, холбогдох баримт бичгийг хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллагын нууцын архивт шилжүүлнэ.

11.4.Хамгаалуулагчийн нууцалбал зохих мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд танилцуулж болно.

11.5.Хамгаалуулагчид өгсөн зохиомол нэрийг зөвхөн мөрдөн шалгах ажиллагааны үед хэрэглэнэ.

12 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах

12.1.Хамгаалуулагчийг хувийн хамгаалалтын нэг бүрийн тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

12.2.Хамгаалуулагчийн биед болон орон байранд дараах тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслийг байрлуулж болно:

- 12.2.1.дохиолол хамгаалалтын;
- 12.2.2.галын аюулгүй байдлын;
- 12.2.3.дүрсийн хяналтын;
- 12.2.4.байршил тогтоох;
- 12.2.5.цахим болон биометрик мэдээлэл таних төхөөрөмж;
- 12.2.6.хутга, сумнаас хамгаалах хантааз;
- 12.2.7.гар утас;

- 12.2.8.богино долгионы гар станц;
- 12.2.9.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12.1.3, 12.1.4-т заасан хэрэгсэл;
- 12.2.10.шаардлагатай бусад.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан тусгай техник хэрэгслийг олгохоос өмнө түүнийг ашиглах зааварчилгааг хамгаалуулагчид биечлэн болон бичгээр өгч, ашиглалтад хяналт тавина.

12.4.Хамгаалуулагч нь нэг бүрийн тусгай техник хэрэгслийг биедээ авч явах эрхтэй.

12.5.Хамгаалуулагч нь тусгай техник хэрэгслийг өөрийн буруугаас эвдсэн, гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн төлнө.

13 дугаар зүйл.Аюулгүй газарт түр байрлуулах

13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 19.1-д заасан насанд хүрсэн хамгаалуулагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хамгаалуулагчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

13.2.Аюулгүй газарт түр байрлуулах хамгаалах байр нь дараах төрөлтэй байна:

13.2.1.хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагын тусгай болон ердийн хамгаалах байр;

13.2.2.энэ хуулийн 13.2.1-д зааснаас бусад төрийн болон төрийн бус байгууллагын гэрээний үндсэн дээр ашиглах хамгаалах байр.

13.3.Тусгай хамгаалах байр байгуулах, ашиглах журмыг хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагын дарга батална.

13.4.Хамгаалуулагчийн зөвшөөрөл, эрсдэлийн түвшинг харгалзан эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр төрийн болон төрийн бус байгууллагын хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төв болон бусад байрыг хамгаалах байрны зориулалтаар ашиглаж болно. Мөн аюулгүй байдал, гарах зардлыг сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хамгаалуулагчийн орон байрыг хамгаалах байрны зориулалтаар ашиглаж болно.

13.5.Насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хамгаалуулагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч түр хамгаалах байранд хамт байх боломжгүй тохиолдолд тэдний зөвшөөрлийг бичгээр авсны үндсэн дээр хамгаалуулагчийг дангаар байрлуулж болно.

13.6.Хамгаалалтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэгч нь хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагын хүсэлтээр үйл ажиллагааны чиглэлийн дагуу хамгаалуулагчийг нутаг дэвсгэрийн харъяалал харгалзахгүйгээр хүлээн авна.

13.7.Энэ хуулийн 25.1.1-д заасан эрсдэлийн өндөр түвшин тогтоогдсон хамгаалуулагчийг зөвхөн тусгай хамгаалах байранд, эрсдэлийн дунд болон бага түвшин тогтоогдсон бол ердийн хамгаалах байранд байрлуулна.

13.8.Нэг гэмт хэргийн гэрч, хохирогчийг түр хамгаалах байранд хамтад нь байрлуулахыг хориглоно.

13.9.Энэ хуулийн 13.4-т заасан тохиолдолд хамгаалуулагчийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон өмгөөлөгчтэйгээ уулзах уулзалтыг хамгаалах байрнаас гадуур зохион байгуулна.

13.10.Насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хамгаалуулагчийн суралцах нөхцөл боломжийг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага хангана.

13.11.Хамгаалах байр болон үйлчилгээ нь хувь хүний ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх бөгөөд нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана.

13.12.Хамгаалах байрны үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

13.13.Хамгаалах болон тусгай хамгаалах байрны байршил, холбогдох бусад мэдээлэл нь төрийн болон албаны нууцад хамаарах бөгөөд байранд ажиллах алба хаагч ажил, үүргээ гүйцэтгэх хугацаанд болон тухайн ажлаас чөлөөлөгдсөн буюу өөрчлөгдсөн /халагдсан/-ий дараа хамгаалах байрны байршил, хамгаалуулагчийн талаарх мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх тухай бичгээр баталгаа гаргана.

13.14.Ердийн болон тусгай хамгаалах байрны нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгаалуулагчаас нууц хадгалах баталгааг бичгээр авна.

14 дүгээр зүйл.Нүүлгэн шилжүүлэх

14.1.Хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан хамгаалалтын арга хэмжээ Монгол Улсын нутаг дэвсгэрт авагдсан тохиолдолд хамгаалуулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагуудад мэдэгдэл хүргүүлнэ.

14.3.Мэдэгдлийг хүлээн авсан төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

14.4.Хамгаалуулагчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүний ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

14.5.Нүүлгэн шилжүүлэх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15 дугаар зүйл.Баримт бичгийг солих

15.1.Шаардлагатай тохиолдолд хамгаалуулагчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичгийг солино.

15.2. Хамгаалуулагчийн баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд дараах баримт бичгийн өөрчлөлт хамаарна:

15.2.1.иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, бүх төрлийн боловсролын болон мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, сертификат, зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг;

15.2.2.эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад баримт бичиг;

15.2.3.хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ;

15.2.4.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

15.2.төрийн байгууллагын төрөлжсөн сангийн бусад мэдээлэл, баримт бичиг.

15.3.Хамгаалуулагч овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчлөх тохиолдолд урьд өмнө гүйцэтгээгүй байгаа үүргийнхээ талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй ба ийнхүү мэдэгдээгүйгээс үүсэх үр дагаврыг төр хариуцахгүй.

15.4.Солигдсон баримт бичгийг хамгаалалтыг хэрэгжүүлэгч байгууллагын хяналтан дор хамтран хэрэгжүүлэгч байгууллага Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу хадгалж, хамгаалах бөгөөд баримт бичгийг солих нөхцөл байдал арилсан тохиолдолд солигдсон баримт бичгийг сэргээж, өөрчлөлт оруулах асуудлыг энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

15.5.Солигдсон баримт бичгийг холбогдох хуулийн дагуу архивын хадгаламжийн нэгж үүсгэн бүртгэж, хадгалж, хамгаална.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасан баримт бичигтэй эрх олгогдсон албан тушаалтан танилцана.

16 дугаар зүйл.Гадаад төрхийг өөрчлөх

16.1.Хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалалтын өөр арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно.

16.2.Хамгаалуулагчийн гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх /үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх линз хэрэглүүлэх гэх мэт/ хамгаалалтын арга хэмжээ авч болно.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг насанд хүрээгүй хамгаалуулагчид хэрэглэхгүй.

16.4.Энэ хуулийн 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хуульд зааснаас бусад зорилгоор хэрэгжүүлэхийг хориглоно.

16.5.Хамгаалалтын арга хэмжээг тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ба гадаад улсын мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

16.6.Хамгаалуулагчид хамгаалалтыг хэрэгжүүлэх боломжтой мэргэжлийн байгууллага, мэргэжилтний талаарх мэдээллийг танилцуулах бөгөөд хамгаалуулагч өөрөө сонгоно.

16.7.Энэ хуулийн 16.6-д заасны дагуу сонгосон хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, мэс заслын ажлыг гүйцэтгүүлнэ.

16.8.Энэ хуулийн 16.7-д заасан гэрээний талууд нууцлалыг хадгална.

16.9.Хамгаалуулагчийн гадаад төрх өөрчлөгдсөн талаарх мэдээллийг гэрэл зураг бүхий бүртгэлийн мэдээллийн системд оруулж, холбогдох баримт бичгийг шинээр олгох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

16.10.Гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжүүлсний улмаас хамгаалуулагчийн эрүүл мэндэд сөрөг үр дагавар үүссэн тохиолдолд холбогдох эмчилгээ, нөхөн сэргээлтийн зардлыг төр хариуцаж, зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

17 дугаар зүйл. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

17.1.Хамгаалуулагчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

17.2.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна:

17.2.1.хамгаалалтад авсан аль ч үед шаардлагатай бол сэтгэл зүйчийг байлцуулах;

17.2.2.хамгаалуулагчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.3.шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.4.шүүх хуралдааны танхимд хамгаалуулагчтай сэтгэл зүйчийг хамт байлцуулах;

17.2.5.шаардлагатай бусад арга хэмжээ.

17.3.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээтэй хамт хэрэгжүүлж болно.

17.4.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагын сэтгэл зүйч, эсхүл сэтгэл зүйчийн баг хэрэгжүүлнэ.

17.5.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг хамгаалуулагчийн аюулын эрсдэлийн түвшин, сэтгэл зүйн байдал, сэтгэл гутрал, айдас, түгшүүрийн түвшнийг харгалзан зохион байгуулна.

17.6.Сэтгэл зүйч хамгаалуулагчид мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдал болон шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц байдлын талаар урьдчилан танилцуулахдаа гэрч, хохирогчийн нас, сэтгэхүй, ойлгож ухаарах түвшинд тохируулан ойлгомжтой хэлбэрээр зураг, комик, дуу, дүрсний бичлэг зэргийг ашиглаж болно.

17.7.Хамгаалуулагч аюулын эрсдэлийн дунд болон өндөр түвшинтэй, сэтгэл зүйн сорилын дүнгээр сэтгэл гутрал, санаа зовнил, айдас түгшүүрийн түвшин өндөр, сэтгэл зүйн цочролд орсон, өмнө нь өөрийгөө гэмтээх, амиа хорлох оролдлого хийж байсан тохиолдолд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэх, өөрчлөх арга хэмжээ авна.

17.8.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх алба хаагч дараах сэтгэл зүйн туслалцаа, сэтгэл заслын үйл ажиллагаа явуулна:

17.8.1.хамгаалуулагчийн сэтгэл зүйн байдлыг судлан оношлох;

17.8.2.хамгаалуулагчид сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах анхан шатны болон сэтгэл зүйн мэдээлэл өгөх;

17.8.3.хамгаалуулагчид стресс, бухимдлыг тайлах, тайвшрах, айдас, түгшүүрийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх, сэтгэл заслын үр дүнтэй арга техникүүдийг заах;

17.8.4.хамгаалуулагчийн өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;

17.8.5.эмзэг, айлган сүрдүүлэлт, заналхийлэлд өртсөн хамгаалуулагчид хүчирхийллийн нөхцөл байдлыг шийдвэрлэх, зайлсхийх, хувийн аюулгүй байдлаа хамгаалах мэдээллээр хангах, өөрөө өөрийгөө хамгаалахад нь туслах;

17.8.6.хамгаалуулагчийн сэтгэл гутрал, гэмтлийн дараах стресс, эмгэг, айдас, түгшүүр, санаа зовнилыг бууруулах, сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах сэтгэл заслын арга техникүүдийг ашиглан ганцаарчилсан сэтгэл засал хийх;

17.8.7.хамгаалуулагчийн сэтгэл санаанд гэмт халдлага, заналхийлэл, хүчирхийлэл, осол, гэмтлийн үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах;

17.8.8.мөрдөн шалгах болон шүүх ажиллагаатай холбоотой сэтгэлийн хямралыг бууруулах арга хэмжээ авах;

17.8.9.сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх явцад гарсан асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, удирдлагад танилцуулах.

17.9.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

17.9.1.шашин болон улс төрийн үзэл номлолыг сурталчлах, албадан тулгах;

17.9.2.ашгийн буюу төлбөртэй үйл ажиллагаа үзүүлэх;

18 дугаар зүйл.Хамгаалуулагчид үзүүлэх туслалцаа

18.1.Хамгаалуулагчид дараах туслалцаа үзүүлж болно:

18.1.1.хууль зүйн туслалцаа;

18.1.2.сэтгэл зүйн туслалцаа;

18.1.3.эрүүл мэндийн туслалцаа.

18.1.4.нийгмийн бусад туслалцаа.

18.2.Хамгаалуулагчид энэ хуулийн 18.1.1, 18.1.2-т заасан туслалцаа болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ.

18.3.Сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 17.4-т заасан сэтгэл зүйч, сэтгэл зүйчийн баг үзүүлнэ.

18.4.Энэ хуулийн 18.1.3-т заасан туслалцааг өмчийн хэлбэрээс үл хамааран бүх шатны эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

18.5.Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

18.6.Энэ хуулийн 18.1.4-т заасан туслалцаа үзүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

Тайлбар:Энэ хуульд заасан "нийгмийн бусад туслалцаа" гэж хамгаалуулагчийн амьдралын зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, хувцас, шаардлагатай бусад ахуйн хэрэгцээ болон насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хамгаалуулагчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн төрөөс үзүүлж байгаа тусламж үйлчилгээг ойлгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХАМГААЛУУЛАГЧ, ХАМГААЛУУЛАХ ЭРХ ҮҮСЭХ, ХАМГААЛАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

19 дугаар зүйл.Хамгаалуулах эрх бүхий этгээд

19.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад албан үүргээ хэрэгжүүлж байгаа дараах төрийн албан хаагч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчоор болон бусад хэлбэрээр оролцож байгаа дараах хүн /цаашид “хамгаалуулагч” гэх/-ийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр аюулгүй байдлын хамгаалалтад авна:

- 19.1.1.гэрч, хөндлөнгийн гэрч;
- 19.1.2.хохирогч;
- 19.1.3.зохигч, гуравдагч этгээд;
- 19.1.4.нэхэмжлэгч, хариуцагч;
- 19.1.5.яллагдагч, шүүгдэгч;
- 19.1.6.шүүгч;
- 19.1.7.прокурор;
- 19.1.8.мөрдөгч;
- 19.1.9.иргэдийн төлөөлөгч;
- 19.1.10.шинжээч, мэргэжилтэн;
- 19.1.11.өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч;
- 19.1.12.орчуулагч, хэлмэрч;
- 19.1.13.энэ хуулийн 3.1.10-т заасан мэдээлэгч;
- 19.1.14.шүүх хуралдааны нарийн бичгийн дарга.

19.2.Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 19.1-д заасан хамгаалуулагчийн гэр бүлийн гишүүн, хамаарал бүхий этгээдийг хамгаалалтад авч болно.

19.3.Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл аюул заналхийлэл арилах хүртэл хугацаанд авна.

19.4.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрч, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.1-д заасан хүний эрх хамгаалагчийг эрх бүхий этгээдийн хүсэлтээр энэ хуулийн хамгаалалтад авч болно.

20 дугаар зүйл.Хамгаалуулах эрх үүсэх

20.1.Энэ хуулийн 19.1-д заасан хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ.

21 дүгээр зүйл.Хамгаалуулагчийн эрх

21.1.Хамгаалуулагч хамгаалалтын арга хэмжээний явцад дараах эрхийг эдэлнэ:

21.1.1.хамгаалалтын арга хэмжээний аль ч шатанд хамгаалалттай холбогдох хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх;

21.1.2.хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл авах;

21.1.3.энэ хуулийн 18.1-д заасан туслалцаа авах;

21.1.4.хувийн мэдээллээ хамгаалуулах, хувийн өмч болон ажлын байраа хадгалуулах;

21.1.4.хуульд заасан бусад эрх.

21.2.Хамгаалуулагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагчийн амьд явах, итгэл үнэмшилтэй байх, эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхээс бусад эрхийг хязгаарлаж болно.

22 дугаар зүйл.Хамгаалуулагчийн үүрэг

22.1.Хамгаалуулагч дараах үүргийг хүлээнэ:

22.1.1.хууль, журам, дүрэм, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагаас өгсөн зааварчилга, зөвлөмж, шаардлагыг биелүүлэх;

22.1.2.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;

22.1.3.хамгаалуулагч, түүний гэр бүлийн гишүүн, хамаарал бүхий этгээд нь хамгаалалтын арга хэмжээний талаарх нууцлалыг хадгалах, бусдад задруулахгүй байх баталгаа гаргах;

22.1.4.хамгаалалтад авахаас өмнөх гүйцэтгээгүй үүргийнхээ талаар мэдэгдэх;

22.1.5.хөдөлгөөн үйлдэх чиглэлийг хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллагад тухай бүр урьдчилан мэдэгдэх;

22.1.6.өөрийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх.

22.2.Хамгаалуулагч энэ хуулийн 22.1-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүссэн эрсдлийг төр хариуцахгүй.

23 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах журам

23.1.Энэ хуулийн 7.1.1-д заасан урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээ авах шийдвэрийг шүүгч, прокурор, мөрдөгч гаргана.

23.2.Энэ хуулийн 7.1.2-7.1.9-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх саналыг хамгаалуулагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр, эсхүл тэдгээрийн хүсэлтгүйгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгч, прокурорын хяналтын шатанд прокурор, шүүхэд хэрэг хэлэлцэх шатанд шүүгч бие даан гаргана.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасны дагуу мөрдөгч, прокурор, шүүгчийн бие даан гаргасан саналын дагуу хамгаалалтын арга хэмжээг авах тохиолдолд хамгаалуулагч, түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөл, эсхүл саналыг авсан байна.

23.4.Хүний эрх хамгаалагчийг хамгаалах саналыг Хүний эрх хамгаалах хорооны эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр мөрдөгч гаргана.

23.5.Мөрдөгч, прокурор, шүүгч /цаашид “эрх бүхий албан тушаалтан” гэх/ хамгаалуулагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул, заналхийллийн нөхцөл байдлыг үнэлэсний үндсэн дээр хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх тухай саналыг дараах баримт бичгийн хамт хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагад нэн даруй хүргүүлнэ:

23.5.1.хамгаалуулагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, хамгаалуулагчийн иргэний үнэмлэхийн хуулбар;

23.5.2.хэргийн танилцуулга;

23.5.3.өмнө нь хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээний үр дүн;

23.5.4.хамгаалуулагч болон түүнд заналхийлэгч этгээдийн талаарх мэдээлэл;

23.5.5.хамгаалуулагчийн өмнөх гүйцэтгээгүй үүрэг;

23.5.6.шаардлагатай бусад.

23.6.Хамгаалалт хэрэгжүүлэх байгууллага шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 23.1-д зааснаас бусад мэдээллийг санал гаргасан албан тушаалтнаас шаардах эрхтэй бөгөөд бичиг баримтыг гаргаж өгөөгүй нь саналыг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

23.7.Хамгаалалт хэрэгжүүлэх байгууллага энэ хуулийн 23.5-д заасан саналыг хүлээн авч бодит аюулын эрсдлийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын 3 хоногийн дотор дараах шийдвэрийг гаргана:

23.7.1.хамгаалалтын арга хэмжээ авах тухай дүгнэлт гаргах;

23.7.2.хамгаалалтын арга хэмжээ авахаас татгалзах.

23.8.Энэ хуулийн 23.7.1-д заасан дүгнэлтэд хамгаалуулагчид учирсан, эсхүл учирч болзошгүй аюулын эрсдлийн түвшин, авах хамгаалалтын арга хэмжээ, зэрэглэл, шаардагдах хүн, хүч хэрэгсэл, хэрэгжүүлэх хугацааг заасан байна.

23.9.Хамгаалалт хэрэгжүүлэх байгууллага нь энэ хуулийн 23.7.1-д заасан дүгнэлтийг мөрдөгчийн саналын дагуу гаргасан бол мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд, прокурорын саналын дагуу гаргасан бол хяналтын харьяаллын шүүхэд даруй хүргүүлж баталгаажуулах ба дүгнэлтийн хуулбарыг санал гаргасан албан тушаалтанд хүргүүлнэ.

23.10.Энэ хуулийн 23.9-д заасан шүүх дүгнэлтийг хүлээн авч баталгаажуулна.

23.11.Хамгаалалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд хамгаалалтыг шууд хэрэгжүүлэх бөгөөд дүгнэлтийг хамгаалалтад авснаас хойш 24 цагийн дотор харьяалах шүүхэд хүргүүлж нөхөн баталгаажуулалт хийлгэнэ.

23.12.Энэ хуулийн 23.7.2-т заасан шийдвэр гаргасан тохиолдолд шийдвэрийг үндэслэлийн хамт санал гаргасан албан тушаалтанд хүргүүлнэ.

23.13.Энэ хуулийн 23.12-т заасан шийдвэрийг санал гаргасан албан тушаалтанд хүргүүлсэн нь хамгаалуулагчид шинээр аюулын эрсдэл үүсэхэд хамгаалалтын арга хэмжээ авахаас татгалзах үндэслэл болохгүй.

23.14.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан арга хэмжээ нь аюулгүй байдлын онцгой арга хэмжээ бөгөөд хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэн хамгаалах боломжгүй нөхцөлд хэрэглэнэ.

23.15.Энэ хуулийн 23.14-т заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх тохиолдолд хамгаалуулагчид хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлснээс үүсэж болох үр дагаврыг тайлбарлан, зөвшөөрлийн бичигт гарын үсэг зуруулна.

23.16.Энэ хуулийн 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг эрүүл мэндийн холбогдох зөвшөөрөлтэй эмнэлгийн байгууллага хэрэгжүүлэх бөгөөд хамгаалуулагчийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамруулж, эрүүл мэндийн харшлах шалтгаан байгаа эсэх талаарх дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

24 дүгээр зүйл.Хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх дүгнэлт гаргахад харгалзан үзэх нөхцөл

24.1.Энэ хуулийн 23.7-д заасан дүгнэлт гаргахдаа дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

24.1.1.бодит аюул, заналхийлсэн үйлдэл, эс үйлдэхүй тогтоогдсон эсэх;

24.1.2.хамгаалуулагчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;

24.1.3.хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;

24.1.4.хамгаалуулагчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;

24.1.5.нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшин;

24.1.6.хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;

24.1.7.хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн;

24.1.8.бусад хамгаалалтын арга хэмжээний үр дүн;

24.1.9.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх болон хэрэгжүүлээгүйгээс хамгаалуулагч болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн харилцаанд гарах үр дагавар, нөлөөлөл;

24.1.10.бусад нөхцөл.

24.2.Энэ хуулийн 17.4-т заасан сэтгэл зүйчийн баг нь шаардлагатай тохиолдолд хамгаалуулагчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор сэтгэл зүйн сорил авч, хамгаалалтын арга хэмжээг сонгох зөвлөмж гаргана.

25 дугаар зүйл.Аюулын эрсдлийн түвшин, түүнийг үнэлэх

25.1.Энэ хуулийн 24.1.5-д заасан аюулын эрсдэлийн түвшинг дараах байдлаар ангилна.

25.1.1.хамгаалуулагчийн амь насанд бодитой заналхийлсэн, бие махбодид гэмтэл учруулсан, тарчлаасан, байнгын дарамтад байлгасан, гэмт хэрэг үйлдэхийг тулган шаардсан, айлган сүрдүүлсэн, дарамт шахалт үзүүлсэн, дагаж мөрдсөн бол эрсдэлийн түвшин өндөр;

25.1.2.хамгаалуулагчийн эд хөрөнгөд халдсан, заналхийлсэн, цахим сүлжээ, холбооны хэрэгсэл ашиглан ятгасан, нөлөөлсөн, мөнгө, эд зүйл, албан тушаал амалсан бол эрсдэлийн түвшин дунд;

25.1.3.хамгаалуулагчтай уулзах, харилцаа тогтоохыг оролдсон бол эрсдэлийн түвшин бага.

25.2.Нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшинг гэмт хэргийн ангилал, төрөл, хэлбэрээс хамаарч үнэлэх бөгөөд үнэлэх аргачлал, үнэлгээний маягтын загварыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.3.Бага насны буюу 0-6 насны хамгаалуулагч, хамаарал бүхий этгээдийн эрсдлийг үнэлэхгүйгээр шууд хамгаалалтад авна.

25.4.Насанд хүрээгүй буюу 7-14 насны хамгаалуулагч, хамаарал бүхий этгээдийн аюулын эрсдэлийг үнэлэхдээ хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг байлцуулна.

25.5.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад тодорхой давтамжтайгаар хамгаалуулагчийн аюулын эрсдэлийг үнэлэх, сэтгэл зүйн сорил авах ажлыг гүйцэтгэнэ.

26 дугаар зүйл. Хамгаалалтын арга хэмжээг цуцлах

26.1.Хамгаалалт хэрэгжүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны албан тушаалтны шийдвэрээр хамгаалалтыг цуцална.

26.2.Хамгаалалт хэрэгжүүлж байгаа байгууллага дараах үндэслэлээр хамгаалалтын арга хэмжээг зогсоох дүгнэлт гаргаж, хамгаалалт хэрэгжүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтанд хүргүүлнэ:

26.2.1.хамгаалуулагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал;

26.2.2.хамгаалуулагчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нөхцөл байдал арилсан, учирч болзошгүй аюул арилсан нь нөхцөл байдал, аюулын эрсдлийн үнэлгээгээр тогтоогдсон;

26.2.3.хамгаалуулагч нь хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн;

26.6.4.хамгаалуулагч нь заналхийлэгч этгээдэд хамгаалалтын талаар нцууцалбал зохих мэдээллийг зориудаар өгсөн;

26.2.5.хамгаалуулагч хамгаалалтаас гарах зорилгоор санаатайгаар өөрийгөө бэртээж гэмтээсэн, амиа хорлох оролдлого хийсэн;

26.2.6.хамгаалуулагч нас барсан.

26.3.Энэ хуулийн 26.2-т заасны дагуу гарсан дүгнэлтийг үндэслэн шүүх хамгаалалтыг цуцлах шийдвэр гаргана.

26.4.Хамгаалалтын арга хэмжээг цуцлах шийдвэр гаргахад энэ хуулийн 24.1-д заасан нөхцөлийг харгалзан үзнэ.

26.5.Хамгаалалтыг цуцалсан тохиолдолд хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагаас хамгаалалт хэрэгжүүлсэн ажлын тайланг санал гаргасан албан тушаалтанд хүргүүлж, гарсан зардлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд тооцох ба энэ хуулийн 14.2.3, 14.2.4-т заасан тохиолдолд гэм буруутай этгээдээр төлүүлнэ.

27 дугаар зүйл.Хяналтын хэрэг бүрдүүлэх

27.1.Хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх дүгнэлт гарснаас хойш хамгаалалттай холбоотой бүхий л үйл ажиллагааг хяналтын хэрэг нээн баримтжуулна.

27.2.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашиглах маягтын загварыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27.3.Хяналтын хэрэгтэй хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нэгжийн дарга, чиглэл хариуцсан ахлах албан тушаалтан, хамгаалалт хэрэгжүүлэгч төв байгууллагын дарга танилцах эрхтэй.

27.4.Хяналтын хэргийг хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх эрх бүхий алба хаагч хадгалах бөгөөд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг цуцлах шийдвэрийг хүлээн авснаас хойш хэргийн бүрдлийг хангаж, архивын нэгж үүсгэн, ажлын 5 хоногийн дотор тухайн нэгжийн нууцын ажилтанд хүлээлгэн өгнө.

28 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх

28.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамгаалалт хариуцсан алба хаагч, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг сэтгэл зүйч хариуцан хэрэгжүүлнэ.

28.2.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай шийдвэрийг хамгаалуулагчид танилцуулж, гарын үсэг зуруулна.

28.3.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх талаар эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээн авсан хамгаалалт хариуцсан алба хаагч нь шийдвэрийг хамгаалалтын мэдээллийн систем /цаашид “хамгаалалтын сан” гэх/-д нэн даруй бүртгэж, хяналтын хэргийн дугаар авна. Бусад мэдээллийг ажлын 3 хоногийн дотор санд бүртгэнэ.

28.4.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээтэй хамтатган хэрэгжүүлэх тохиолдолд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний шийдвэрээр хяналтын хэргийн дугаарыг авна.

28.5.Хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх алба хаагч нь хамгаалалтын сангаас авсан дугаарыг батлагдсан маягтад тэмдэглэн, хяналтын хэрэгт хавсаргана.

28.6.Хамгаалалтын арга хэмжээний хэлбэрийг өөрчлөх, хамтатган хэрэглэх шийдвэр гарсан тохиолдолд хяналтын хэргийн дугаар өөрчлөгдөхгүй.

28.7.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх алба хаагч нь шаардлагатай тохиолдолд хамгаалалтад авсан хамгаалуулагчид энэ хуулийн 18.1-д заасан туслалцаа үзүүлэх ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

28.8.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хамгаалуулагчийг сэтгэл зүйн хямралаас урьдчилан сэргийлэх зорилгоор аюулгүй газарт түр байрлуулан шаардлагатай тусламж, зөвлөмж, зааварчилгаар хангана.

28.9.Энэ хуулийн 7.1.6-7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хамгаалуулагчийг өмнө ажиллаж байсантай ижил хэмжээний цалин хөлс бүхий ажлын байраар хангана.

28.10.Хамгаалуулагчийг энэ хуулийн 23.9-д заасан ажлын байраар хангах боломжгүй бол өмнө авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний нөхөн олговрыг хамгаалалтад байх хугацаанд олгоно.

28.11.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашиглах гэрээ, маягтын загварыг хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагын дарга батална.

28.12.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь хамгаалуулагч болон хамтран хэрэгжүүлэх байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.13.Насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хамгаалуулагчийг хамгаалах гэрээг түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулна.

28.14.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.15.Хамгаалалтын арга хэмжээний нуулалыг хамгаалуулагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, энэ тухай мэдсэн, оролцсон бусад иргэн, албан тушаалтан бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

28.16.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмыг баримтална.

28.17.Энэ хуулийн 7.1.4, 7.1.8-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бол тагнуул, хүний хувийн мэдээлэл хариуцагч байгууллага нь тухайн мэдээлэл агуулсан төрөлжсөн санд нэвтрэх, хандах эрхийг хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагад тодорхой хугацаанд олгож, хамтран ажиллана.

28.9.Хамгаалалт хариуцсан алба хаагч нь хамгаалуулалтыг хэрэгжүүлэх явцад өөрт нь болон хамгаалуулагчид учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулсан байна.

29 дүгээр зүйл.Хамгаалалтын арга хэмжээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар

29.1.Арга хэмжээ авагдсан этгээд /заналхийлэгч/ нь хамгаалалтын арга хэмжээг зөрчсөн тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий алба хаагч нь шийдвэр гаргасан албан тушаалтанд мэдэгдэх, таслан сэргийлэх арга хэмжээ болон хамгаалалтын арга хэмжээний хэлбэрийг өөрчлөх, хамтатган хэрэгжүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан шийдвэрийг гарах хүртэл хамгаалуулагчийг аюулгүй газарт байрлуулах хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

29.2.Арга хэмжээ авагдсан этгээд /заналхийлэгч/-ийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгуулах саналыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

30 дугаар зүйл.Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам

30.1.Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийн хамгаалалтын арга хэмжээг хамгаалалт хэрэгжүүлэх байгууллага хорих байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан хамгаалалтын арга хэмжээний үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авна:

30.2.1.гэрч, хохирогчийг бусад хоригдлоос тусгаарлах;

30.2.2.шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийг хорих ангид эрхэлж байсан ажил хөдөлмөр, олон нийтийн арга хэмжээнд оролцуулахгүй байх;

30.2.3.гэрч, хохирогчийн байршлыг өөрчлөх;

30.2.4.бусад.

30.3.Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ХЭВИЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ

31 дүгээр зүйл.Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах ажиллагаа

31.1.Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна:

31.1.1.шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах;

31.1.2.шүүх хуралдааны дэг сахиулах;

31.1.3.шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах;

31.1.4.яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах;

31.1.5.шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, хохирогч, зохигч, хэргийн бусад оролцогчийг албадан ирүүлэх;

31.1.6.оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах.

32 дугаар зүйл.Шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах

32.1.Шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь шүүн таслах хэвийн ажиллагааг хангахын тулд халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц ажиллагаа байна.

32.2.Бүх шатны шүүхийн байр, шүүх хуралдаан хийх шүүхийн байрнаас бусад газар, шүүхийн тусгай архивын байрны аюулгүй байдлыг хангана.

32.3.Шүүхийн байрны аюулгүй байдлыг хамгаалах талаар дараах арга хэмжээ авна:

32.3.1.шүүхийн байранд нэвтрүүлэх хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлийг шалгах, бүртгэх;

32.3.2.эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон дүрэм, шалган нэвтрүүлэх журмыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

32.3.3.гамшиг, аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгахад дэмжлэг үзүүлэх;

32.3.4.хууль бусаар нэвтэрсэн этгээдийг саатуулах, цагдаагийн байгууллагад хүргэх;

32.3.5.хорлон сүйтгэх, террорист ажиллагаа үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх.

32.4.Аюулгүй байдлыг хангах байгууллага нь шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдал, хамгаалалтыг хариуцах, шүүхийн байранд иргэдийг нэвтрүүлэх хөдөлгөөнд нь хяналт тавих үүрэг бүхий тусгай ажилтанг томилон ажиллуулна.

32.5.Шүүхийн барилга байгууламж болон түүний гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гэнэтийн халдлага гарах, шүүгч, гэрч, хохирогчийн амь биед халдах, барьцаалах, шүүхийн байр руу дайрах, бүслэх, үйл ажиллагааг тасалдуулахыг оролдох, галдан шатаах, шүүхийн байрны орчимд замын хөдөлгөөн хаах зэрэг иргэд, байгууллагын зүгээс учруулж буй аливаа хууль бус үйлдлийн улмаас шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй, мөн үйл ажиллагаанд нь саад учруулсан буюу учруулахаар оролдсон онцгой нөхцөл үүссэн тохиолдолд учрах эрсдэл, аюулыг зайлуулах, түүний хохирлыг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

32.6.Шүүхийн барилга байгууламжийг хамгаалах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын үүрэг гүйцэтгэхтэй холбоотой шаардлагатай мэдээллийг шүүхийн тамгын газраас гаргуулан авна.

32.7.Шүүхийн барилга байгууламжийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын байр, орчин нөхцөлийг Шүүхийн тамгын газар бүрдүүлнэ.

32.8.Хамгаалалтын бүс, түүний аюулгүй байдлыг хангах ажлыг аюулгүй байдлыг хангах байгууллага нь Шүүхийн тамгын газартай хамтран зохион байгуулна.

32.9.Шүүхийн байранд шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, аюулгүй байдлыг хангахад шаардагдах техник хэрэгсэл /галын болон хамгаалалтын дохиолол, харилцаа холбооны хэрэгсэл, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, хяналтын камер, металл илрүүлэгч хаалга, гар металл илрүүлэгч, ачаа тээш шалгах рентген төхөөрөмж, согтуурлын зэрэг тогтоох багаж /драгер/, ачаа тээш түр хадгалах хайрцаг, үүрэн утасны сүлжээ сарниулагч г.м/-ээр хангах ажлыг хамгаалалт хэрэгжүүлэх байгууллагын саналыг үндэслэн шүүхийн төсөвт тусгуулж, зохион байгуулах чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцна.

33 дугаар зүйл.Шүүх хуралдааны дэг сахиулах

33.1.Шүүхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүх хуралдааны танхимд эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

33.2.Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцож байгаа бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор аюулгүй байдлыг хангах байгууллагаас тусгай ажилтныг томилон ажиллуулна.

33.3.Шүүх хуралдааны хэвийн ажиллагааг хангах явцад аюултай, гэнэтийн нөхцөл байдал үүсвэл энэ хуулийн 33.2-т заасан тусгай ажилтан шүүх хуралдааныг түр хугацаагаар завсарлуулахаар шүүх хуралдаан даргалагчид үндэслэл бүхий санал тавьж шийдвэрлүүлнэ.

33.4.Аюулгүй байдлыг хангах байгууллага шүүх хуралдааны явцад үүсч болох эрсдэлтэй нөхцөл байдалд дүгнэлт хийж цаашид хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид үндэслэл бүхий санал хүргүүлж болно.

33.5.Шүүх хуралдааны дэг сахиулах нарийвчилсан журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.

34 дугаар зүйл.Гэрч, зохигч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх ажиллагаа

34.1.Гэрч, зохигч, яллагдагч, шүүгдэгч, хэргийн бусад оролцогчийг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн дагуу шүүхэд албадан ирүүлнэ.

34.2.Шүүхэд албадан ирүүлэх ажиллагааны зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

35 дугаар зүйл.Яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах

35.1.Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн бусад оролцогчийг хуяглан хүргэх ажиллагааг дараах тохиолдолд зохион байгуулна:

35.1.1.цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хүргэх;

35.1.2.ялтныг хорих ангиас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас хорих ангид хүргэх;

35.1.3.цагдан хорих байр хооронд, хорих байр хооронд нүүлгэн шилжүүлэх;

35.1.4.цагдан хорих байрыг нүүлгэн шилжүүлэх;

35.1.5.ялтан шилжүүлэх.

35.2.Шаардлагатай гэж үзвэл яллагдагч, ялтныг хуяглан хүргэх хугацаанд үзэгдэх орчинг хязгаарлаж болно.

35.3.Хуяглан хүргэх ажиллагааг тусгай тоноглогсон автомашинаар, шаардлагатай үед галт тэрэг, нисэх онгоцоор тээвэрлэн хүргэнэ.

35.4.Яллагдагч, шүүгдэгч, ялтныг галт тэрэг, нисэх онгоцоор хуяглан хүргэхдээ хүлээн авах байгууллагын удирдлагад урьдчилан мэдэгдэнэ.

35.5.Цагдан хоригдож байгаа яллагдагч, шүүгдэгч нь эрүүл мэндийн шалтгаанаар цагдан хорих байраас гадуур эмчлүүлэх шаардлагатай тохиолдолд хуяглан хүргэнэ.

36 дугаар зүйл.Хуяглан хүргэх болон хуяглан харгалзахад хориглох зүйл

36.1.Хуяглан хүргэх болон хуяглан харгалзахад дараах зүйлийг хориглоно:

36.1.1. албан хэрэгцээнд эзэмшиж байгаа галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, болон хуяглан хүргэх, хянан харгалзах үүргийг бусдад шилжүүлэх;

36.1.2.хуяглан хүргэх болон хуяглан харгалзаж байгаа этгээдийг хяналтгүй орхих, гаднын хүнтэй уулзуулах;

36.1.3.хуяглан хүргэж байгаа тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд гаднын хүн, ачаа тээвэрлэх;

36.1.4.зориулалтын бус, техникийн аюулгүй байдал хангагдаагүй тээврийн хэрэгсэл ашиглах;

36.1.5.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүргэх чиглэл, байршлыг өөрчлөх;

36.1.6.яллагдагч, шүүгдэгч, ялтанд зурвас, захиа, холбооны хэрэгсэл, эд зүйлс дамжуулах;

36.1.7.хуяглан хүргэх ажиллагааны нууцлалыг задруулах;

36.1.8.хуульд заасан бусад.

37 дугаар зүйл.Ялтан шилжүүлэх

37.1.Ялтныг гадаад улсад шилжүүлэх, гадаад улсаас шилжүүлэн авах ажиллагаанд нисэх онгоц, галт тэрэг, тусгай тоноглогсон автомашин ашиглана.

38 дугаар зүйл.Хоригдлыг хорих байр хооронд нүүлгэн шилжүүлэх, цагдан хорих байр, хорих ангийг нүүлгэн шилжүүлэх ажиллагааны үед яллагдагч, ялтныг хуяглан хүргэх

38.1.Хоригдлыг хорих байр хооронд нүүлгэн шилжүүлэх, цагдан хорих байрыг нүүлгэн шилжүүлэх, хорих ангийг өөрчлөн байгуулах, татан буулгах болон байгалийн гамшиг учирсан үед нүүлгэн шилжүүлэхэд хорих байгууллагын хүсэлтээр яллагдагч, ялтныг хуяглан хүргэх ажиллагаанд аюулгүй байдлыг хангах алба дэмжлэг үзүүлж болно.

38.3.Хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх ажиллагааны журмыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

39 дүгээр зүйл.Оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах

39.1.Шүүхийн шийдвэр, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, иргэний хариуцагч, хорих байгууллагаас оргосон ялтныг эрэн сурвалжлах ажиллагааг аюулгүй байдлыг хангах байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

39.2.Эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулах үед нийслэл, аймаг, сум, дүүргийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хотын захирагч, цагдаа, хорих, батлан хамгаалах, хил хамгаалах алба зэрэг байгууллагаас хүн хүч, зэвсэг, автомашин, шатахуун, техник хэрэгсэл, түр байрлах байр шаардан гаргуулах, эсхүл дайчлан ашиглаж болно.

39.3.Аюулгүй байдлыг хангах байгууллагын алба хаагч эрэн сурвалжлах ажиллагааны үед боомт, хилийн зурвас, гааль, төрийн тусгай хамгаалалтын бүсэд нэвтрэн ажиллах эрхтэй.

39.4.Ялтан оргон зайлсан тохиолдолд тухайн хорих байгууллага аюулгүй байдлыг хангах байгууллагад нэн даруй мэдэгдэж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.

40 дүгээр зүйл.Хорих байгууллагад онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах

40.1.Хорих байгууллагад бусдыг барьцаалах, өмч хөрөнгө эвдэж сүйтгэх, галдан шатаах зэрэг нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн нөхцөлд аюулгүй байдлыг хангах байгууллага хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор хорих байгууллагатай хамтран ажиллана.

41 дүгээр зүйл.Хуяглан хүргэх тусгай ажилтан, түүний гүйцэтгэх үүрэг

41.1.Яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх үүргийг хуяглан хүргэх тусгай ажилтан гүйцэтгэнэ.

41.2.Хуяглан хүргэх ажиллагааг ердийн журмаар болон хүч нэмэгдүүлэн гүйцэтгэнэ.

41.3.Нийтэд аюул учруулах магадлал багатай яллагдагч, шүүгдэгч, ялтныг ердийн журмаар хуяглан хүргэнэ.

41.4.Шаардлагатай гэж үзвэл яллагдагч, шүүгдэгч, ялтныг хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэнэ.

41.5.Хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэх ажиллагааны журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.

41.5.Хуяглан хүргэх болон хуяглан харгалзах албан хэрэгцээнд зориулж тусгай ажилтанд галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгслийг олгож, ашиглалтад хяналт тавина.

41.6.Яллагдагч, шүүгдэгч, ялтан оргох, оргохоор завдах, эсхүл алба хаагчийн биед халдсан үед алба хаагч биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэглэнэ.

41.7.Хуяглан хүргэх ажиллагаанд албаны нохой ашиглаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБАНЫ ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРЭГ

42 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын алба

42.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах алба /цаашид “Аюулгүй байдлын алба” гэх/ нь энэ хуульд заасан хамгаалуулах эрх бүхий этгээдийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн тусгай алба мөн.

42.2.Аюулгүй байдлын алба нь нэгдмэл удирдлагатай, бие даасан байх бөгөөд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус байх, нууцыг чанд сахих зарчмыг баримтална.

42.3.Аливаа албан тушаалтан, хүн, хуулийн этгээд Аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

42.4.Аюулгүй байдлын албыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

42.5.Аюулгүй байдлын алба бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална.

42.6.Аюулгүй байдлын алба тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

42.7.Аюулгүй байдлын алба улсын төсвөөс санхүүжих бөгөөд төсөв нь түүний хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай хүрэлцэхүйц байна.

42.8.Аюулгүй байдлын албаны төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.

42.9.Аюулгүй байдлын албаны дэргэд энэ хуулийн 65.1-д заасан Тусгай мөрдөх товчоо ажиллана.

42.10.Тусгай мөрдөх товчооны үйл ажиллагаа хараат бус байх бөгөөд аливаа албан тушаалтан, хүн, хуулийн этгээд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

42.11.Тусгай мөрдөх товчооны төсөв нь энэ хуулийн 42.6-д заасан төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

42.12.Аюулгүй байдлын алба нь аюулгүй байдлын төв байгууллага, тойргийн журмаар зохион байгуулагдсан тойргийн аюулгүй байдлын албад /цаашид “тойргийн аюулгүй байдлын алба”/-аас бүрдэнэ.

42.13.Тойргийн аюулгүй байдлын албыг түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзан байгуулна.

42.14.Тойргийн аюулгүй байдлын албаны байршлыг энэ хуулийн 42.6-д заасан шалгуур үзүүлэлтийг харгалзан хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргатай зөвшилцөн байгуулна.

43 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны чиг үүрэг, бүтэц

43.1.Аюулгүй байдлын алба дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 43.1.1.энэ хуулийн 19.1-д заасан этгээдийг хамгаалах;
- 43.1.2.шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах;
- 43.1.3.зохигч, яллагдагч, шүүгдэгч, ялтныг албадан ирүүлэх;
- 43.1.4.яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах;
- 43.1.5.оргосон яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах;
- 43.1.6.ялтан шилжүүлэх;
- 43.1.8.хуульд заасан бусад чиг үүрэг.

43.2.Аюулгүй байдлын алба энэ хуулийн 43.1.1-д заасан хамгаалах чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхтэй:

43.2.1.энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
43.2.2.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, өөрчлөх, цуцлах тухай дүгнэлт гаргах;
43.2.3.хамгаалуулагчид хуульд заасан туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах;
43.2.4.хамгаалалтын үйл ажиллагааны нууцлалыг хангах;
43.2.5.хуульд заасан шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

43.2.6.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах;

43.2.7.дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих.

43.3.Аюулгүй байдлын алба шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

43.3.1.шүүхийн барилга байгууламжийн харуул хамгаалалтыг хэрэгжүүлэх, шүүх хуралдааны дэг сахиулах;

43.3.2.шүүгч, шүүх хуралдаанд оролцогчдод заналхийлэх, халдахаар бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах;

43.3.3.гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалах, цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгөх, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;

43.3.4.шүүхийн байр, хамгаалалтын бүсэд нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах;

43.3.5.шүүхийн байр, хамгаалалтын бүсэд гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн үед хорио цээрийн дэглэмийг сахиулах, амь нас, эрүүл мэнд нь онц аюултай нөхцөлд байгаа хүнд тусламж үзүүлэх.

43.3.6.оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах, албадан ирүүлэх

43.3.7.сэжигтэн, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх.

43.4.Энэ хуулийн 43.3.4, 43.3.5-д заасан тохиолдолд тухайн шүүхийн тамгын газар, цагдаа, онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллана.

43.5.Аюулгүй байдлын алба шаардлагатай тохиолдолд шүүн таслах ажиллагааны явцад хөрөнгө битүүмжлэх, шүүхэд ирсэн нотлох баримтыг хадгалах, хамгаалах, хуулиар шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулахаар заасан зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

43.6.Аюулгүй байдлын алба дараах тохиолдолд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулна:

43.6.1.шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах;
43.6.2.оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах;
43.6.3.энэ хуульд заасан хамгаалуулагч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх.

43.7.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах төв байгууллага /цаашид “Аюулгүй байдлын төв байгууллага” гэх/ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

43.8.Аюулгүй байдлын төв байгууллага нь хамгаалалт хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, мэдээлэл нэгтгэн боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, захиргааны удирдлага, дотоод хяналт, аюулгүй байдлыг хангах үндсэн бүтэцтэй байна.

43.9.Энэ хуулийн 43.8-т заасан дотоод хяналт, аюулгүй байдлын нэгжийг бусад чиг үүрэг хариуцсан нэгжээс бие даалган байгуулах бөгөөд нэгжийн алба хаагчийг тус нэгжийн даргад мэдэгдэхгүйгээр томилох, өөрчлөх, чөлөөлөхийг хориглоно.

43.10.Аюулгүй байдлын төв байгууллагын дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажиллана.

43.11.Аюулгүй байдлын төв байгууллага дэргэдээ сургалтын түшиц газар, өөрийн үйл ажиллагааны чиглэлээр шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий нэгжтэй байж болно.

43.12.Аюулгүй байдлын төв байгууллага нь хамгаалалт хэрэгжүүлэх, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, оргон зайлсан сэжигтэн болон прокурор, шүүхээс даалгасан хүн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах үндсэн чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх ажил явуулах албатай байна.

43.13.Аюулгүй байдлын төв болон тойргийн аюулгүй байдлын албаны орон тооны дээд хязгаарыг Засгийн газар, зохион байгуулалтын бүтцийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

43.14.Аюулгүй байдлын төв байгууллага нь дарга, тэргүүн дэд дарга, дэд даргатай байна.

43.15.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах нэгжийг, тэргүүн дэд дарга нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэг бүхий нэгжийг хариуцан удирдана.

43.16.Дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан нэгжийн дарга нь дэд дарга байна.

43.17.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга албаны үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, үр дүнг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө, тэргүүн дэд дарга, дэд дарга нь хариуцсан чиг үүргийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, төв байгууллагын даргын өмнө хариуцна.

44 дүгээр зүйл.Аюулгүй байдлын төв байгууллагын чиг үүрэг

44.1.Аюулгүй байдлын төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

44.1.1.үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, заавар, зөвлөмж боловсруулах, биелэлтийг хангах;

44.1.2.албаны үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

44.1.3.албаны чиг үүргийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, тойргийн аюулгүй байдлын албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

44.1.4.албаны барилга байгууламж, автомашин, зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, хувцас, бусад хангамжийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;

44.1.5. алба хаагчийг зэвсэг техник, нэг бүрийн тусгай хэрэгсэл, хувцас, бусад хэрэгслээр хангах;

44.1.6.алба хаагчийг мэргэшүүлэх, сурган дадлагажуулах, техникийн туслалцаа авах чиглэлээр гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

44.1.7.алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

44.1.8.дотоод, гадаадын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;

44.1.9.хуульд заасан бусад чиг үүрэг.

44.2.Аюулгүй байдлын төв байгууллага нь нутаг дэвсгэр хариуцсан тойргийн албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

45 дугаар зүйл. Аюулгүй байдлын албаны алба хаагч

45.1.Аюулгүй байдлын албаны алба хаагч нь тусгай ажилтан /цаашид “тусгай ажилтан” гэх/, албаны дэргэдэх Тусгай мөрдөх товчооны алба хаагч нь тусгай мөрдөгч /цаашид “тусгай мөрдөгч” гэх/ байна.

45.2.Аюулгүй байдлын албаны алба хаагч зэрэг дэвтэй байх бөгөөд түүнийг олгох журмыг Засгийн газар батална.

45.3.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга нь тэргүүн комиссар, тэргүүн дэд дарга нь тэргүүн шадар комиссар, дэд дарга, тойргийн албаны дарга нь эрхэлсэн комиссар, нэгжийн дарга нь шадар комиссар, ахлах ажилтан нь ахлах комиссар, ажилтан нь комиссар зэрэг дэвтэй байна.

45.4.Энэ хуулийн 45.3-т зааснаас бусад алба хаагч нь туслах комиссар зэрэг дэвтэй байна.

45.5.Тэргүүн комиссар, тэргүүн шадар комиссар, эрхэлсэн комиссар зэрэг дэвийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, бусад зэрэг дэвийг Тэргүүн комиссар олгоно.

45.6.Аюулгүй байдлын албанд ажиллаж байгаа үйлчилгээний ажилтны эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

46 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны албан тушаалд тавигдах шаардлага

46.1.Аюулгүй байдлын албаны албаны албан тушаалд мэргэжлийн болон зохих нөхцөл, шалгуурыг хангасан, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй иргэнийг томилно.

46.2.Албан тушаалд тавих тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, төрийн тусгай албанд болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрдэнэ.

46.3.Энэ хуулийн 46.2-д заасан тусгай шаардлага, шалгуур үзүүлэлтийг аюулгүй байдлын төв байгууллагын дарга тогтооно.

47 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны тангараг

47.1.Аюулгүй байдлын албаны алба хаагч томилогдмогц "Аюулгүй байдлын албаны тусгай ажилтан би хууль дээдлэн, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хуулиар хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ батлан тангараглая. Тангарагаа зөрчвөл хуулийн хариуцлага хүлээнэ." гэж тангараг өргөнө.

47.2.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн тангараг өргөх журмыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

48 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа

48.1.Аюулгүй байдлын төв байгууллагын даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилно.

48.2.Аюулгүй байдлыг хангах төв байгууллагын тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 6 жилийн хугацаагаар томилно.

48.3.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргад нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

48.3.1.аюулгүй байдлын төв байгууллагын даргад нэр дэвшигч нь төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, мэргэжлийн ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;

48.3.2.аюулгүй байдлыг хангах төв байгууллагын тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргад нэр дэвшигч нь төрийн албанд 10-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, хариуцсан чиглэлээр дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;

48.4.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргыг нэг удаа улируулан томилж болно.

48.5.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны дарга нөхөн томилогдвол түүний бүрэн эрхийн хугацаа томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 48.1, 48.2-т заасан бүрэн эрхийн үлдсэн хугацааг дуустал үргэлжилнэ.

49 дүгээр зүйл.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргыг чөлөөлөх, түдгэлзүүлэх, огцруулах

49.1.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргыг дараах тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

49.1.1.өөрөө хүсэлт гаргасан

49.1.2.биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон

49.1.3.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон.

49.2.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны дарга гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол энэ өдрөөс эхлэн түүнийг албан тушаалаас нь огцруулсанд тооцно.

49.3.Хуульд зааснаас бусад үндэслэлээр аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, тойргийн аюулгүй байдлын албаны даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх буюу огцруулахыг хориглоно.

50 дугаар зүйл.Аюулгүй байдлын төв байгууллагын даргын бүрэн эрх

50.1.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

50.1.1.албаны үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдах;

50.1.2.байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

50.1.3.аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг баталж, мөрдүүлэх;

50.1.4.албаны хүний нөөц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргах;

50.1.5.алба хаагчийн томилох, чөлөөлөх, зэрэг дэв, нэмэгдэл олгох, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

50.1.6.албаны барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, хувцас, бусад хангамжийн талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

50.1.7.шүүхийн байранд аюулгүй байдлыг хангахад шаардагдах техник хэрэгслээр хангах саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд тавьж, шийдвэрлүүлэх;

50.1.8.алба хаагчдыг сургаж, бэлтгэх, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, мэргэшлийн зэрэг олгох;

50.1.9.албаны чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдээлэл өгөх, санал тавих, үйл ажиллагааны үр дүнг хариуцан тайлагнах;

50.1.10.албаны үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг шийдвэрлэх;

50.1.11.байгууллагыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

50.1.12.хуульд заасан бусад.

50.2.Аюулгүй байдлын төв байгууллагын даргын түр эзгүйд тэргүүн дэд дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

51 дүгээр зүйл.Аюулгүй байдлын байдлын албаны алба хаагчийг томилох

51.5.Аюулгүй байдлын албаны тусгай ажилтанаар батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагад гурваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын иргэнийг энэ хуулийн 46.3-т заасан шалгуур үзүүлэлтийг харгалзан томилно.

51.4.Тусгай ажилтан нь мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.

51.5.Тусгай ажилтанг албан тушаалд анх томилох, эсхүл албан тушаал дэвшүүлэн томилохдоо алба хаагчийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, гаргасан амжилт, хувийн болон мэргэжлийн ёс зүйг үндэслэл болгож, албан тушаал эрхлэх шат дарааллаар томилох зарчмыг баримтална.

52 дугаар зүйл.Шүүхийн аюулгүй байдлыг хангах тусгай ажилтан, түүний эрх хэмжээ

52.1.Тойргийн шүүхэд ажиллах алба хаагчийн тоог Аюулгүй байдлын албаны төв байгууллагын дарга холбогдох шүүхийн тамгын газрын даргатай зөвшилцөн тогтоож, шүүхийн тусгай ажилтнаар томилно.

52.2.Шүүхийн тусгай ажилтан тойргийн аюулгүй байдлын албаны бүрэлдэхүүнд багтах бөгөөд түүнийг тойргийн аюулгүй байдлын алба мэргэжлийн удирдлагаар хангана.

52.3.Шүүхийн тусгай ажилтан шүүхийн дотоод журамд захирагдан ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд шүүхийн тамгын газрын дарга ерөнхий хяналт тавина.

52.4.Шүүхийн тамгын газрын дарга нь шүүхийн тусгай ажилтны үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлтээ харьяалах тойргийн аюулгүй байдлын албаны удирдлагад танилцуулна.

52.5.Шүүхийн тусгай ажилтан шүүх хуралдааны дэг сахиулах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

52.5.1.шүүх хуралдаанд хүргэж ирсэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийг хуяглан хүргэгчээс хүлээн авах;

52.5.2.яллагдагчийг хяналтдаа байлган шүүх хуралдаанд хуяглан харгалзах;

52.5.3.шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах;

52.5.4.шүүх хуралдааны дэг зөрчсөн яллагдагч, шүүгдэгч, зохигч, бусад оролцогчийг шүүгчийн захирамжийн дагуу хуралдааны танхимаас гаргах, дуудсан үед оруулах;

52.5.5.танхимд байгаа бусад хүн шүүх хуралдааны дэг зөрчсөн бол шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрээр танхимаас гаргах;

52.5.6.шүүх хуралдааны явцад болон завсарлах хугацаанд цагдан хоригдсон яллагдагчийг өмгөөлөгчөөс бусад хүнтэй уулзуулахгүй байх, бусдаас эд зүйл авах, дамжуулахгүй байх арга хэмжээг авах;

52.5.7.хорих ялаар шийтгэгдсэн ялтныг хяналтдаа байлган, хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр гэр бүлийнхэнтэй нь уулзуулах;

52.5.8.ялтныг хуяглан хүргэгчид хүлээлгэн өгөх.

52.6.Шүүхийн тусгай ажилтан шүүхийн байрыг хамгаалж, журмын дагуу үзлэг шалгалт хийн шалган нэвтрүүлэх, шүүхийн байрны гадна орчны аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

52.7.Аюулгүй байдлын алба нь батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан иргэнийг тав хүртэл жилийн хугацаагаар гэрээгээр ажиллуулж, шүүхийн тусгай ажилтны үүргийг гүйцэтгүүлж болох ба тухайн цалин хөлс олгоно.

52.8.Шүүх хуралдааны явцад эсэргүүцэл үзүүлэх, эмх замбараагүй байдал үүсч болзошгүй нөхцөл байдал үүсвэл аюулгүй байдлын албаны болон цагдаагийн байгууллагаас нэмэлт хүч татан ирүүлэх ажлыг тухайн тойргийн аюулгүй байдлын алба зохион байгуулна.

52.9.Аюулгүй байдлын алба шүүхийн тусгай ажилтанд галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгслийг албан хэрэгцээнд олгож, ашиглалтад хяналт тавина. Шүүхийн тусгай ажилтны үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ажилтанд галт зэвсэг олгохгүй.

52.10.Шүүгч, хуралдаанд оролцогчийн амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэн халдсан, эсхүл шүүх хуралдааныг хэвийн явуулах боломжгүй болсон тохиолдолд шүүхийн тусгай ажилтан биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэглэнэ.

52.11.Шүүхийн тусгай ажилтан нь шүүх хуралдааны үед хуралдаан даргалагчид захирагдана.

53 дугаар зүйл.Тусгай ажилтны дүрэмт хувцас, таних тэмдэг

53.1.Тусгай ажилтан хэрэгжүүлж байгаа чиг үүргээс хамааран дүрэмт хувцас, хувийн дугаар бүхий таних тэмдэгтэй байна. Дүрэмт хувцасны загварыг Засгийн газар батална.

53.2.Тусгай ажилтны дүрэмт хувцас, таних тэмдэг хэрэглэх журмыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

53.3.тусгай ажилтан ажил үүргийн онцлогоос шалтгаалан дүрэмт хувцсыг өдөр тутам хэрэглэхгүй байж болно.

53.4.Аюулгүй байдлын албаны алба хаагчаас бусад этгээд аюулгүй байдлын албаны албан хаагчийн дүрэмт хувцас, таних тэмдэг хэрэглэхийг хориглоно.

53.5.Алба хаагч тэтгэвэр тогтоолгох болон алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр албанаас чөлөөлөгдсөн бол дүрэмт хувцас, тэмдгийг түүнд хадгалуулна.

53.6.Энэ хуулийн 53.5-д зааснаас бусад үндэслэлээр албанаас чөлөөлөгдсөн, халагдсан болон өөр ажилд томилогдсон, сонсгогдсон тохиолдолд дүрэмт хувцас, тэмдгийг хураан авна.

54 дүгээр зүйл. Аюулгүй байдлын албаны алба хаагчийн эрх

54.1. Аюулгүй байдлын албаны алба хаагч Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах эрх эдэлнэ:

54.1.1. хамгаалалттай холбоотой хууль ёсны хүсэлт, шаардлагыг иргэн, албан тушаалтанд тавих, дэмжлэг, туслалцаа авах;

54.1.2. алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан хэрэгжүүлэх;

54.1.3. аюулгүй байдлын үзлэг хийх;

54.1.4. шүүхийн аюулгүй байдлыг хангах ажлын зорилгоор иргэний бичиг баримт шалгах, бие болон эд зүйлд үзлэг хийх, шалган нэвтрүүлэх;

54.1.5. зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис болон хуулиар хязгаарласан, хориглосон бусад зүйл илэрвэл хураан авах, холбогдох байгууллагад шилжүүлэх;

54.1.6. хамгаалалтын дэглэм, тогтоосон дэг журмыг сахихыг шаардах, шаардлага биелүүлээгүй иргэн, албан тушаалтныг хамгаалалтын бүсээс албадан гаргах, нэвтрүүлэхгүй байх;

54.1.7. хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлээс сорьц авч шинжилгээ хийлгэх, хамгаалалтын бүсэд ажиллах бусад байгууллагын ажилтанд зааварчилгаа өгөх, хяналт тавих;

54.1.8. хамгаалуулагч тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үеийн замын чиглэл, цуваагаар явах дэг тогтоох, зорчих үед үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хурд, чиглэлийг өөрчлөх;

54.1.9. хамгаалуулагчид бодитой аюул учирсан тохиолдолд хуулиар хориглосноос бусад тээврийн хэрэгслийг дайчлах;

54.1.10. ажлын шаардлагаар байр, орон сууцанд оршин суугчийн зөвшөөрлөөр нэвтрэн орох, үзлэг хийх;

54.1.11. зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүчийг тогтоосон үндэслэл, журмын дагуу хэрэглэх;

54.1.12. дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх техник хэрэгсэл ашиглах;

54.1.13. амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлаа аливаа халдлагаас хамгаалах, өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулах, зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

54.1.14.хуульд заасан бусад.

54.2.Аюулгүй байдлын албаны алба хаагч биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэж болно.

54.3.Энэ хуулийн 54.2-т заасан биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхэд Цагдаагийн албаны тухай хуулийн тавдугаар бүлэгт заасныг баримтална.

55 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн үүрэг

55.1.Аюулгүй байдлын албаны алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

55.1.1.хамгаалалтын бүсэд тогтоосон хамгаалалтын дэглэм, дэг журмыг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

55.1.2.хамгаалалтын бүсэд гарсан зөрчил, гэмт халдлагыг таслан зогсоож, эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэх арга хэмжээг авах;

55.1.3.үүрэг гүйцэтгэж байхдаа ажлын байраа шууд удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр орхиж явахгүй байх, бусдад шилжүүлэхгүй байх;

55.1.4.албан үүргийнхээ дагуу олж мэдсэн хамгаалуулагчийн хувийн болон бусад мэдээллийн нууцлалыг хамгаалах;

55.1.5.хуульд заасан бусад.

56 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны алба хаагчид хориглох зүйл

56.1.Аюулгүй байдлын албаны алба хаагчид Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулиар хориглосон үйл ажиллагаанаас гадна дараах зүйлийг хориглоно:

56.1.1.удирдах албан тушаалтны хууль ёсны шийдвэр, тушаалыг биелүүлэхээс татгалзах;

56.1.2.хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хэвлэн нийтлэх;

56.1.3.албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан илэрхий болсон, эсхүл албан үүргийн дагуу олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц болон хувь хүний эмзэг мэдээллийг задруулах;

56.1.4.албан үүрэг гүйцэтгэж байгаа, албаны бэлэн байдал зарласан үед, эсхүл дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;

56.1.5.мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх;

56.1.6.хуульд заасан бусад.

57 дугаар зүйл.Алба хаагчийг албанаас чөлөөлөх

57.1.Аюулгүй байдлын албаны алба хаагчийг Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр албанаас чөлөөлж болно:

57.1.1.бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр албан тушаал, орон тоо нь хасагдсан;

57.1.2.биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

57.1.3.хуульд заасан бусад.

57.2.Алба хаагч гэмт хэрэг, зөрчил болон ёс зүй, сахилгын зөрчилд холбогдсон бол бүрэн эрхийг уг асуудлыг шалгах хугацаагаар түдгэлзүүлж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АЛБА ХААГЧИЙН БАТАЛГАА

58 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн баталгаа

58.1.Аюулгүй байдлын албаны алба хаагч төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэлт баталгаа, цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдана.

58.2.Аюулгүй байдлын албаны алба хаагч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.

59 дүгээр зүйл.Улс төрийн баталгаа

59.1.Аюулгүй байдлын албаны алба хаагчийг хуульд заасан албан үүргээс нь гадуур улс төрийн үйл ажиллагаанд дайчлах, оролцуулахыг хориглоно.

59.2.Аюулгүй байдлын албаны алба хаагч албаны үүргээсээ гадуур энэ хуулийн 59.1-д заасан үйл ажиллагаанд оролцохоос татгалзсан нь хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.

59.3.Аюулгүй байдлын албаны алба хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.

60 дугаар зүйл.Хууль зүйн баталгаа

60.1.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн ажлыг шууд удирдах албан тушаалтанд нь мэдэгдэлгүйгээр шалгах, түүнийг албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.

60.2.Алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байхад нь шууд харьяалах нэгжийн даргад мэдэгдэхгүйгээр саатуулах, бие, эд зүйлд нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

60.3.Алба хаагчаас ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар гэрч, хохирогчийн хувиар мэдүүлэг авах тохиолдолд харьяалах албаны даргад мэдэгдэнэ.

60.4.Аюулгүй байдлын төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар

баривчилсан бол хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд, бусад алба хаагчийг аюулгүй байдлын төв байгууллагын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

60.5.Алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс бусдад учруулсан хохирлыг төр хариуцна.

60.6.Эрх бүхий албан тушаалтны өгсөн үүрэг даалгаврыг албан хаагч ёсчлон биелүүлснээс үүссэн үр дагаврыг үүрэг даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.

60.7.Алба хаагч ажлын бус цагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явах болон энхийг дэмжих ажиллагаанд оролцохыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.

60.8.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан алба хаагч болон түүний гэр бүлийн гишүүний амь биед аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг авах асуудлыг Аюулгүй байдлын алба хариуцна.

60.9.Аюулгүй байдлын албаны алба хаагчийг гүйцэтгэх ажлын зорилгоор ашиглахыг хориглоно.

60.10.Аюулгүй байдлын албаны алба хаагч албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

60.11.Хуульд зааснаас бусад үндэслэлээр алба хаагчийг ажлаас чөлөөлөх, халах, өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

61 дүгээр зүйл.Нийгмийн баталгаа

61.1.Аюулгүй байдлын албаны алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг түүний гэр бүлд нэг удаа олгоно.

61.2.Аюулгүй байдлын албаны алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, эсхүл албанаас чөлөөлөгдсөн иргэний урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол энэ хуулийн 61.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.

61.3.Энэ хуулийн 61.1-д заасан тэтгэмжийн зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

61.4.Аюулгүй байдлын албаны алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд Засгийн газар дараах нөхөх олговрыг олгоно:

61.4.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;

61.4.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардал;

61.4.3.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.

61.5.Алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрд энэ хуулийн 61.4-т заасан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.

61.6.Алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

61.7.Алба хаагчийг гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.

61.8.Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирсны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхтэй холбоотой зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

61.9.Энэ хуулийн 61.4-т заасан нөхөх олговрыг олгох журам, энэ хуулийн 61.8-д заасан зардлыг олгох журмыг Засгийн газар батална.

61.10.Алба хаагчийн тус албанд ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.

61.11.Тойргийн албаны дарга, алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх хугацаандаа тухайн тойрогтоо амьдрах бөгөөд томилогдсон тойрогт гэр бүлээрээ амьдрах, эхнэр/нөхөр нь ажиллах боломжоор хангах асуудлыг Аюулгүй байдлын алба хариуцна.

61.12.Үндсэн чиг үүргээ гүйцэтгэх, дайны болон онц байдал, энхийг дэмжих ажиллагаа, гамшиг, түүний үр дагаврыг арилгах зэрэг алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд өндөр эсрдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай холбоотойгоор сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай бол 3 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулна.

61.13.Алба хаагч ажлын шаардлагаар орон нутагт шилжин ажиллах болсны улмаас түүний эхнэр/ нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх бөгөөд, дэмжлэг үзүүлээгүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний хэмжээгээр тооцож, төсвөөс төлнө.

62 дүгээр зүйл.Эдийн засгийн баталгаа

62.1.Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжид ажиллах үед алба хаагчид олгох хоол, унааны зардал, хээрийн сургууль, дадлагын үед олгох хүнсний болон эд зүйлийн хангалтыг Аюулгүй байдлын алба хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амрах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.

62.2.Аюулгүй байдлын албаны захиалгаар гадаад улсын их, дээд сургуульд суралцагч алба хаагчийн суралцах хугацааны сургалтын зардал, ирэх, буцах тээврийн зардлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

62.3.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

62.4.Алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож, 2 жилд нэг удаа олгоно.

62.5.Ажлын шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй алба хаагчид түүний зөвшөөрлөөр хоногт ногдох цалинг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэмцэх хэмжээний нөхөн олговор олгоно.

62.6.Аюулгүй байдлын албаны алба хаагч Авилгатай тэмцэх газрын адилтгах албан хаагчийн адил хэмжээний цалин хангамж, зэрэг дэв, бусад нэмэгдлийг эдэлнэ.

62.7.Нийтийг хамарсан эмх замбараагүй, онц байдлын үед болон халдварын голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс 3 дахин нэмэгдүүлж олгоно.

62.8.Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод түүнчлэн аймаг, хотын дотор ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, замын зардал, түүний гэр бүлийн асрамжид байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа тээврийн хэрэгслийн үнэлгээгээр тооцож олгоно.

63 дугаар зүйл.Бусад баталгаа

63.1.Аймгийн төвөөс бусад суманд томилогдсон алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх албаны орон сууц, холбооны хэрэгслээр хангах үүргийг байгууллага хүлээнэ.

63.2.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа алба хаагчид 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 5 жил тутамд олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

64 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн сахилгын хариуцлага

64.1.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн сахилгын дүрмийг аюулгүй байдлын албаны төв байгууллагын дарга батална.

64.2.Алба хаагчид Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэсэн нь сахилгын шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

НАЙМДУГААР БҮЛЭГ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ДЭРГЭДЭХ ТУСГАЙ МӨРДӨХ АЛБА

65 дугаар зүйл. Тусгай мөрдөх алба

65.1.Аюулгүй байдлын албаны дэргэд хуулиар харьяалуулсан гэмт хэргийг мөрдөн шалгах үндсэн чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан Тусгай мөрдөх алба ажиллана.

65.2.Тусгай мөрдөх алба нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

65.3.Тусгай мөрдөх албаны мөрдөн шалгах ажиллагаанд аливаа албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

65.4.Тусгай мөрдөх албаны орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

65.5.Тусгай мөрдөх товчоо нь үйл ажиллагаа, удирдлага, боловсон хүчний хувьд бие даасан байх бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны болон түүнд дэмжлэг үзүүлэх бусад нэгжтэй байна.

65.6.Тусгай мөрдөх товчооны даргыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар, дэд даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, бусад алба хаагчдыг Тусгай мөрдөх товчооны дарга томилно.

65.7.Тусгай мөрдөх товчооны алба хаагч аюулгүй байдлын албаны адилтгах алба хаагчийн адил зэрэг дэвтэй байна.

65.8.Тусгай мөрдөх албаны дарга, мөрдөгч нь Авилгатай тэмцэх газрын адилтгах алба хаагчийн адил хэмжээний цалин хангамж, бусад нэмэгдлийг эдэлнэ.

66 дугаар зүйл.Тусгай мөрдөх товчооны алба хаагчийн баталгаа

66.1.Тусгай мөрдөх товчооны алба хаагч төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэлт баталгаа, цалин хөлс, нөхөх төлбөр, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллаас гадна энэ хуулийн 58-63 дугаар зүйлд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн болон бусад баталгаагаар хангагдана.

66.2.Тусгай мөрдөх товчооны алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.

66.3.Тусгай мөрдөх товчооны алба хаагчийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах, саатуулах, баривчлах тохиолдолд Аюулгүй байдлын албаны даргын зөвшөөрлийг үндэслэнэ.

66.4.Аюулгүй байдлын албаны даргын зөвшөөрөл олгоогүй тохиолдолд эрх бүхий байгууллагаас хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал хүргүүлэх ба ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, БУСАД ЗҮЙЛ

67 дугаар зүйл.Аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд тавих хяналт

67.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналт тавина.

67.2.Шүүх, прокурорын байгууллага нь Аюулгүй байдлын албаны хууль сахиулах үйл ажиллагаанд холбогдох хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавина.

67.3.Аюулгүй байдлын албаны мөрдөн шалгах нууц ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо хяналт тавина.

67.4.Аюулгүй байдлын төв байгууллага нь тойргийн аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, хууль тогтоомж, хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, илэрсэн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авна.

68 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах

68.1.Хамгаалалтад байгаа этгээд энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 5 хоногийн дотор гомдлоо харьяалах шүүхэд гаргана.

68.3.Шүүх гомдлыг ажлын таван өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

69 дүгээр зүйл.Аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд гомдол гаргах

69.1.Аюулгүй байдлын албаны үйл ажиллагааны талаарх гомдлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан, эсхүл дээд шатны байгууллагад гаргана.

69.2.Энэ хуулийн 69.1-д заасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргаж болно.

70 дугаар зүйл.Шүүх, шүүгч, шүүх хуралдаанд оролцогчийг хамгаалах талаарх Засгийн газар, төрийн захиргааны төв болон бусад байгууллага, Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх үүрэг

70.1.Засгийн газар хамгаалалтыг хэрэгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

70.1.1.гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар хөтөлбөр баталж хэрэгжүүлэх;

70.1.2.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний зардлыг улсын төсөвт тусгах.

70.2.Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

70.2.1.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх талаар гадаад улстай хэлэлцээр хийх, гэрээ байгуулах;

70.2.2.энэ хуулийн 70.1.1-д заасан хөтөлбөрийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх ажлыг уялдуулан зохицуулах.

70.3.Шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хамгаалалтад байгаа болон хамгаалалтад байсан этгээдийг хамгаалах зорилгоор Аюулгүй байдлын албыг дараах мэдээллээр шуурхай хангах үүрэгтэй:

70.3.1.яллагдагчид авсан, өөрчилсөн таслан сэргийлэх арга хэмжээний талаар;

70.3.2.өршөөсөн, уучилсан шийдвэрийн талаар;

70.3.3.сулласан, хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон талаар;

70.3.4.ялтан хорих байгууллагаас түр болон бүрмөсөн чөлөөлөгдсөн талаар.

70.4.Шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хамгаалуулагчтай харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, баталж мөрдүүлнэ.

70.5.Тагнуул, цагдаа, авилгатай тэмцэх байгууллага, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад шаардлагатай төрийн байгууллагатай Аюулгүй байдлын алба хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.

70.6.Аюулгүй байдлын алба нь энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ цагдаагийн байгууллага, алба хаагчийн туслалцаа, дэмжлэгийг авч болно.

70.7.Цагдаагийн байгууллага нь хамгаалуулагчийн хамгаалалт хүссэн дуудлага, мэдээллийг хүлээн авч, аюулгүй байдлын албанд мэдэгдэж, зохих арга хэмжээ авах хүртэл хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

70.8.Бүх шатны Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад төрийн байгууллага хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

70.9.Сумын Засаг дарга тухайн нутаг дэвсгэр хариуцсан аюулгүй байдлын албаны алба хаагчийг орон байраар хангах арга хэмжээ авна.

71 дүгээр зүйл.Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

71.1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж болох бөгөөд тэдгээр нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

72 дугаар зүйл.Хамгаалалтын мэдээллийн сан

72.1.Аюулгүй байдлын алба нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан, сүлжээ байгуулж ашиглана.

72.2.Хамгаалалтын мэдээллийн сан нь хамгаалалтын арга хэмжээний талаарх мэдээллийг тусгайлан боловсруулсан программ хангамжаар мэдээллийн санд бүртгэсэн мэдээллийн цогц байна.

72.3.Аюулгүй байдлын албаны хамгаалалтын мэдээллийн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд аливаа халдлагаас хамгаалагдсан байна.

72.4.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий алба хаагч нь мэдээллийн санд дараах мэдээллийг тухай бүрт оруулна:

- 72.9.1.хамгаалалтын арга хэмжээний шийдвэрийн бүртгэл;
- 72.9.2.хамгаалуулагчийн бүртгэл;
- 72.9.3.арга хэмжээ авагдсан этгээд /заналхийлэгч/-ийн бүртгэл;
- 72.9.4.хамгаалалтын арга хэмжээг цуцлах шийдвэрийн бүртгэл.

72.5.Хамгаалалтын арга хэмжээний мэдээллийг бүртгэсэн алба хаагч зөвхөн өөрийн оруулсан мэдээллийг харах бөгөөд зөвхөн хамгаалалтын нэгжийн эрх бүхий албан тушаалтан нь сангийн мэдээллийг хянаж, засварлах эрхтэй.

72.6.Санд хамгаалалтын арга хэмжээний мэдээллийг оруулахдаа сангаас олгогдсон хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэргийн дугаараас өөр дугаараар бүртгэхийг хориглоно.

73 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох

73.1.Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно.

74 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

74.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

74.2.Аюулгүй байдлын албаны алба хаагч дараах тохиолдолд эд хөрөнгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө:

74.2.1.албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэсний улмаас учирсан хохирол;

74.2.2.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онцгой нөхцөл байдлын улмаас учирсан хохирол.

74.3.Аюулгүй байдлын албаны алба хаагчийн энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, албан үүрэгтэй нь холбогдуулан албан хаагч, түүний хамаарал бүхий этгээдийг болон тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн үндэслэлээр албанаас чөлөөлөгдсөн иргэнийг заналхийлсэн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

75 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

75.1.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөрУлаанбаатар
хот**“ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ
БҮДҮҮВЧИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын тохируулагч агентлаг" хэсэгт "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын ерөнхий газар" гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоолыг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд дараах агуулга бүхий 5 дахь хэсэг нэмсүгэй:

6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны дэргэдэх Тусгай мөрдөх товчооны албаны хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг дараах дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны дэргэдэх Тусгай мөрдөх товчоо нь шүүгч, прокурор, цагдаагийн үйлдсэн болон тагнуулын байгууллагын албан хаагчийн үйлдсэн энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад, авилгатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт” гэснийг “энэ зүйлийн 1, 2, 4 дэх хэсэгт” гэж, 8.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 11 дэх хэсэг, 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж, 12.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “цагдаагийн байгууллага” гэснийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын алба” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг дараах агуулгаар өөрчлөн найруулсугай:

“8.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг хамгаалах тухай болон хамгаалалтыг цуцлах тухай шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.”

5 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.1.9, 9.1.10 дахь заалт:

“9.1.9.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын алба Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан хамгаалуулагчийн болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, гүйцэтгэх ажил явуулах байгууллагуудтай хамтран ажиллах;

9.1.10.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны дэргэдэх Тусгай мөрдөх товчоо гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах байгууллагуудтай хамтран ажиллах”

2/11 дүгээр зүйлийн 11.9, 11.10 дахь хэсэг:

“11.9.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах, хууль заасан хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдалд халдлага, хор аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.;

11.10.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны дэргэдэх Тусгай мөрдөх товчоо энэ хуулийн 11.2.1, 11.2.2, 11.2.3, 11.2.5, 11.2.6-д заасан үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.”

2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг дараах агуулгаар өөрчлөн найруулсугай:

“9.1.3.цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АВИЛГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авилгын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.12-ын “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн “этгээд, гэрчийг” гэснийг “этгээдийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийн “Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээ авна” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтад хамруулах арга хэмжээг авна” гэж өөрилсүгэй.

2 дугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.18 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хамруулж болно” гэснийг “хамруулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд хамруулж болно.” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-ын “Үндэсний болон орон нутгийн аудитын газар” гэсний дараа “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах алба, түүний дэргэдэх Тусгай мөрдөх товчоо” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтын “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4.п. заалт, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалтын “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 230 дугаар зүйлийн 230.5 дахь хэсгийн “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.2 дахь хэсгийн “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.15 дахь заалтын “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийн “цагдаагийн байгууллага” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дүгээр зүйлийн 43.5 дахь хэсгийн “цагдаагийн албанд” гэснийг “эрх бүхий байгууллагад” гэж, 77 дугаар зүйлийн 77.10 дугаар хэсгийн “цагдаагийн алба” гэснийг “эрх бүхий байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалтын “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” гэснийг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ